



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



“ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ

Гарын авлага

Зохиогч: А.Эрдэнэцогт (Ph.D)

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яамнаас хэрэгжүүлж буй
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар хот
2013 он

**DDC
342.06
3-325**

ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ

Гарын авлага

Хөтөлбөр, гарын авлага боловсруулсан баг: Зохиогч А.Эрдэнэцогт (Ph.D)

Хэвлэлийн хуудас: 15.8
Цаасны хэмжээ: В5
Хэвлэсэн тоо: 1200
Хэвлэсэн газар: “BCI” Хэвлэлийн компани

ISBN 978-99962-56-70-7

© Энэхүү гарын авлага нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан тул зөвшөөрөлгүйгээр хэвлэж олшруулахыг хориглоно.



ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ОЮУТАН, БАГШ НАРТ



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, “Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт”-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг шинэчлэхэд

чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон.

2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

*Төслийн Зохицуулагч
Большорлоогийн Сарантуяа*

ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагыг баримталж байна. Нэг дэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг. Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцагчдын ур чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг. 1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих” дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- Зорилго, хүрэх үр дүнг тодорхой болгосон.
- Онолын мэдлэгийг эзэмшүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшүүлэх, үнэт зүйлсийн төлөвшилд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

Төслийн зөвлөх Ухнаагийн Туяа (Ph.D)

Адилбишийн ЭРДЭНЭЦОГТ

Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Төр-захиргааны эрх зүйн тэнхлгийн эрхлэгч



Захиргааны процессын эрх зүй, Нутгийн эрх зүйн чиглэлээр сургалт, судалгааны ажил эрхэлдэг

Захиргааны процессын эрх зүйн үндэсний сурах бичгийг анхлан бичиж хэвлүүлсэн. Мөн Захиргааны процессын эрх зүйн хичээлийн хөтөлбөрийг анх боловсруулсан. 2010 онд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах УИХ-ын ажлын хэсэгт орж ажиллав. Мөн шүүхийн шинэтгэлийн багц хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Шүүхийн захиргааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллав.

Захиргааны хэргийн шүүхийг Монголд анх байгуулагдах үеэс эхлэн өнөөг хүртэл уг шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийг бэлтгэх, шүүгч, өмгөөлөгч, хуульчдын ур чадварыг дээшлүүлэх болон ЗХШ-ийн үйл ажиллагааг сурталчлах зэрэг чиглэлээр сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг хийж гүйцэтгэж ирэв.



ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад төр нь иргэнийхээ өмнө хариуцлага хүлээх эрх зүйт төрийн шаардлага, эрх мэдлийн харилцан тэнцвэртэй байх суурь зарчим, нэн ялангуяа шүүх эрх мэдлийн зүгээс гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавих арга зам иргэний субъектив эрхийн баталгаагаар дамжин хэрэгждэг байдал нь Захиргааны процессын эрх зүй хэмээх шинэ салбар эрх зүйн үндсийг бүрэлдүүлжээ.

Захиргааны процессын эрх зүй нь нийтийн эрх зүйн салбаруудын зааг ялгаа, тэдгээрийн уялдаа холбоог тодорхой болгоход нэн чухал үүрэгтэй болох нь уг эрх зүй үүсч хөгжсөн шинэхэн түүх нотлон харуулж байна.

Иймд эрх зүйд эхлэн суралцаж буй оюутнуудын эзэмшвэл зохих эрх зүйн мэдлэгийн нэг салбар нь Захиргааны процессын эрх зүй юм.

Энэхүү гарын авлагад Захиргааны процессын эрх зүйн үндсэн ойлголт, түүнийг танин мэдэх онол, эрх зүйн арга, зарчим, хэрэглэгдэхүүнийг аль болох бүрэн гүйцэд тусгахыг эрмэлзлээ.

Захиргааны процессын эрх зүйд суралцсанаар оюутан та бүхэн нийтийн эрх зүйн маргаан гэх шинэ ойлголттой танилцаж, улмаар уг маргааныг хянан шийдвэрлэх үүрэг бүхий Захиргааны шүүх хэмээх цоо шинэ институтын үйл ажиллагааг танин мэдэж, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг тодорхойлоход шаардагдах онол, эрх зүйн арга, зарчимд суралцаж, энэ талаарх анхны практик чадварыг эзэмших юм.

Энэхүү гарын авлага нь захиргааны дур зоргоос иргэний үндсэн эрхийг хамгаалах эрмэлзэл, чадвар бүхий эрх зүйчдийг бэлтгэхэд зохих хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

Захиргааны процессын эрх зүйн сургалтын хөтөлбөр болон гарын авлагын
Зохиогч А.Эрдэнэцогт (Ph.D), дэд профессор

ГАРЧИГ

Өмнөх үг.....5

I. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Хичээлийн залгамж холбоо.....	8
2. Хичээлийг судлах хэрэгцээ шаардлага	8
3. Хичээлийн зорилго	9
4. Хичээлийн зорилт	9
5. Захиргааны процессын эрх зүй хичээлийн агуулга, цагийн хуваарилалт..	11

II. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Нэг. Үндсэн ойлголт

Захиргааны процессын эрх зүйн ойлголт	15
Захиргааны процессын эрх зүйн зарчим	18
Захиргааны процессын эрх зүй ба бусад салбар эрх зүйн харилцан хамаарал.....	20
Нийтийн эрх зүйн маргаан ба захиргааны хэрэг	23

Хоёр. Захиргааны процессын эрх зүйн онцлог ажиллагаа

Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны ойлголт, онцлог	25
Урьдчилан шийдвэрлүүлэх гомдолд тавигдах шаардлага.....	28
Гомдлын үндэслэл.....	30

Гурав. Захиргааны процессын оролцогч ба эрх зүйн хамгаалалт

Захиргааны хэргийн оролцогч, тэдгээрийн эрхийг хангах асуудал	32
Бусад оролцогч	35
Нэхэмжлэлийн ойлголт, төрөл	38
ЗХШ-д нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөл.....	41
Нэхэмжлэлийн үндэслэл.....	43
Нэхэмжлэлийн үндэслэлийг шалгах \загвар хичээл\.....	44
Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх.....	46



Дөрөв. Нотлох баримт

Захиргааны хэргийн нотлох баримт	48
Нотолгоо	52

Тав. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа

Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа	54
Шүүх бүрэлдэхүүн, шүүгчийг татгалзан гаргах	57
Шүүхийн шинжилгээ	59
Шүүхийн зардал ба улсын тэмдэгтийн хураамж	61
Анхан шатны шүүх хуралдаан	66
Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, түүний төрөл	70
ЗХШ-ийн шийдвэр биелүүлэх ажиллагаа	74
Давж заалдах шатны журмаар ЗХХША	77
Хяналтын шатны журмаар ЗХХША	81
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллагаа	84

Ш. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

1. Захиргааны процессын эрх зүй хичээлийн хөтөлбөрийн агуулга	88
2. Захиргааны процессын эрх зүй хичээлийн хөтөлбөрийн арга зүй	107
3. Захиргааны процессын эрх зүй хичээлийн үнэлгээ	117

ГАРЫН АВЛАГЫН НОМ ЗҮЙ	122
------------------------------------	------------

I. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр: “Захиргааны процессын эрх зүй”

Кредит: 2 үүнээс: лекц - 16

Нийт цаг: 48 бусад хэлбэр - 32

Хичээлийн залгамж холбоо

Захиргааны процессын эрх зүй хичээлийг үзэхийн өмнө оюутан Үндсэн хуулийн эрх зүй, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, Газрын эрх зүй, Татварын эрх зүй зэрэг захиргааны эрх зүйн тусгай ангийг судласан байвал зохино. Түүнчлэн логикийн гаргалгаа хийх чадварыг эзэмшиж, мэргэжлийн гадаад хэлний зохих мэдлэгтэй байх шаардлагатай.

Энэ хичээлтэй Үндсэн хуулийн, Иргэний болон Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зэрэг процессын эрх зүйн хичээлүүдийг зэргэмжээ судлуулвал тэдгээрийн адилсах, ондоосох талыг онол-эрх зүйн түвшинд харьцуулан мэдэж мэргэжлийн зөв хандлага төлөвшихөд нэн тустай байх болно.

Хичээлийг судлах хэрэгцээ шаадлага

Нийгмийн хэрэгцээ, шаардлага

Монголд ноёрхож байсан тоталитари дэглэмийн гол арга болох захиргаадалтаас эх үндэстэй захиргааны байгууллагын дур зоргын шийдвэр, үйл ажиллагаа өнөөг хүртэл амь бөхтэй хэвээр байж шинэ Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрч баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хэрэг дээр нь хэрэгжих нөхцлийг алдагдуулах, зөрчихөд хүргэж байгаа нь хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын байгууллагуудын судалгаагаар тодорхой байгаа билээ¹. Энэ нь нийтийн захиргааны шийдвэр, үйл ажиллагаанд эрх зүйт төрийн зарчмуудыг нэвтрүүлж, зүй зохист соёлыг төлөвшүүлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

Мэргэжлийн хэрэгцээ, шаардлага

Нийгмийн шаардлага нь мэргэжлийн хэрэгцээ, шаардлагыг төрүүлнэ. Захиргааны процессын эрх зүй нь иргэний болон хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нийтийн захиргааны хууль бус шийдвэр, үйл ажиллагаанаас

¹ Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл., УБ хот. 2001, 2002, 2003, 2004 он.



хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн, учирсан хохирлыг арилгахтай холбогдсон харилцааг зохицуулж, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл хоорондын харилцан тэнцлийг хангах зориулалт бүхий үндэсний эрх зүйн бие даасан салбар юм.

Нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтны акт буюу хууль бус ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй)-тай холбоотой гомдол, нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэх чиг үүрэг бүхий дээд шатны захиргаа, ЗХШ-ийн үйл ажиллагааг судлан зохих суурь мэдлэг, дадлага эзэмших явдал хууль зүйн болон захиргаа, удирдлагын чиглэлээр суралцаж байгаа оюутны мэргэжилд тавигдах шинэ шаардлага болов. Учир нь Монголд анх удаа Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдан гарч дагнасан шүүхийн тогтолцоо бүрэлдэж буй нь захиргааны хэргийн шүүхийн шүүгч, энэ чиглэлийн өмгөөлөгч, хуулийн зөвлөгч, түүнчлэн засаг захиргааны мэргэшсэн ажилтан бэлтгэх “зах зээлийн эрэлт хэрэгцээ” бий болсон бөгөөд энэ чиглэлээр ажиллахын тулд өөрийгөө нээн харуулах боломж олгохуйц мэргэжлийн ирээдүйтэй нэг чиглэл энд байх болно.

Хичээлийн зорилго

Нийтийн захиргааны үйл ажиллагаатай холбогдон үүссэн эрх зүйн маргаан болон уг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай онолын үндэс, эрх зүйн журмыг судалж танин мэдэх, гомдол, нэхэмжлэлийн зүйл болох захиргааны акт нь зорилгодоо нийцсэн хийгээд хууль ёсны эсэхийг мэргэжлийн түвшинд задлан шинжилж захиргааны урьдчилсан болон шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй гарган иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад шаардагдах онол, эрх зүйн арга хэрэглүүр, түүнийг хангах нэн анхны практик чадварыг эзэмших; захиргааны дур зоргоос хүний эрх, эрх чөлөөг хамгаалах эрмэлзэлтэй болоход чиглэсэн хандлага төлөвшихөд энэ хичээлийн зорилго оршино.

Хичээлийн зорилт

Дээрх зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг тавьж хэрэгжүүлнэ. Үүнд:

- Захиргааны процессын эрх зүйн ойлголт, зарчим, үе шатуудыг нийтийн материаллаг болон процессын эрх зүйтэй харьцуулан судалж, адилсах тал хийгээд онцлогийг танин мэднэ.
- Нийтийн эрх зүйн маргаан ба захиргааны хэргийн ойлголтыг харьцуулан судалж тэдгээрийн агуулга багтаамжийг тодорхойлно.
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ойлголт, онцлог, дотоод бүтэц, төрөл зүйлийн талаар логик уялдаа бүхий цогц мэдлэг бүтээнэ.
- Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны онцлог, зорилго, зорилт, ач холбогдлыг мэдэж захиргааны актын зорилгодоо нийцсэн

хийгээд хууль зүйн үндэслэлтэй эсэхийг шалган тогтоож үндэслэл бүхий шийдвэр гаргах чадвар эзэмшинэ.

- ЗХХШ ажиллагааны зохих үе шатан дахь шүүхийн шатлал тус бүр (анхан, давах, хяналтын шүүх)-ийн гүйцэтгэх үүрэг, ажиллагааны онцлог, эрх зүйн журам, хуулийн шаардлагын талаар тогтолцоожсон (эрэмбэтэй) мэдлэг бүтээнэ.
- Захиргааны хэргийг анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааг тал бүрээс нь судалж, түүнийг шийдвэрийн хууль ёсны болон бодит үндэслэлийг олж тогтоох чадвар эзэмшинэ.
- ЗХШ-ийн шийдвэр биелүүлэх эрх зүйн үндэслэл, онцлогтой танилцаж, уг ажиллагаанд учрах хүндрэл бэрхшээл, түүнийг даван туулах арга замыг олох чадварыг эзэмшинэ.
- ЗХШ-ээс гарах баримт бичгийг агуулга, бүтэц, соёл, техникийн талаар үндэслэлтэй боловсруулах чадварыг зохих түвшинд эзэмшинэ.
- ЗХШ-ийн шийдвэрт маргах хэрэгслийн талаар цэгцтэй мэдлэг авч, хувийн ба нийтийн /төрийн/ ашиг сонирхлыг мэргэжлийн түвшинд хамгаалах чадвартай, хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгааг хангах хандлага бүхий мэргэжилтэн болж төлөвшихөд нь туслана.



“Захиргааны процессын эрх зүй” хичээлийн агуулга, цагийн хуваарилалт

д/д	Хичээлийн сэдэв	Цаг	Хичээлийн санал болгож буй арга	Хичээлийн товч агуулга
1	Захиргааны процессын эрх зүйн ойлголт	1	Лекц	<ul style="list-style-type: none">- Захиргааны процессын эрх зүйн ойлголт- Захиргааны процессын эрх зүйн үндсэн шинж- Хууль зүйн бусад процессоос захиргааны процессын эрх зүйн ялгарах онцлог
2	Захиргааны процессын эрх зүйн зарчим	1	<ul style="list-style-type: none">- Лекц- Жижиг бүлгээр ажиллах- Идэвхтэй ярилцлага	<ul style="list-style-type: none">- Эрх зүйн зарчмын тухай ойлголт, тогтолцоо түүний шинэтгэл- Захиргааны процессын эрх зүйн үндсэн зарчмууд, тэдгээрийн илрэл, онцлог- Захиргааны процессын эрх зүйн зарчмыг баримтлах нь- Эрх зүйн хийдэл, давхардал утга, тодорхойгүй байдал үүссэн үед эрх зүйн зарчмыг хэрэглэх нь
3	Захиргааны процессын эрх зүй ба бусад салбар эрх зүйн харилцан хамаарал	1	<ul style="list-style-type: none">- Лекц- Жижиг бүлгээр ажиллах- Идэвхтэй ярилцлага	Захиргааны процессын эрх зүй нь бусад салбар эрх зүйтэй харилцан хамаарах байдал, тэдгээрийн уялдаа холбоог хангах шалгуурыг судлах
4	Нийтийн эрх зүйн маргаан ба захиргааны хэрэг	1	Лекц	<ul style="list-style-type: none">- Нийтийн эрх зүйн болон хувийн эрх зүйн маргааны адилсах, ондоосох талууд- Захиргааны “маргаан”, “хэрэг” гэх ойлголт, онцлог- Захиргааны хэргийг ангилах нь
5	Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны ойлголт онцлог	1	Лекц	<ul style="list-style-type: none">- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл, зүйл- Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны ойлголт, хоёрдмол шинж- Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргах шийдвэр, чиг үүрэг, ач холбогдол

ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ

ГАРЫН АВЛАГА

6	Нэхэмжлэлийн ойлголт, төрөл	2	- Лекц - Хүн бүр багш	- Хүчингүй болгуулах тухай нэхэмжлэл - Тогтоох нэхэмжлэл - Даалгах нэхэмжлэл - Хохирлоо арилгуулах тухай нэхэмжлэл
7	Захиргааны хэргийн оролцогч, тэдгээрийн эрхийг хангах асуудал	2	- Лекц - Хүн бүр багш	- Оролцогч \нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд\ -ын эрх, үүрэг - Бусад оролцогч тэдгээрийн эрх, үүрэг
8	Нотолгоо	1	Лекц	- Нотолгооны үүрэг - ЗХШ-ийн нотлох баримт цуглуулах арга Шүүх нотлох баримтыг үнэлэх, бодит бүрдлийг хангах
9	Шүүхийн шинжилгээ	1	Лекц	Шүүхийн шинжилгээ хийлгэх арга, ажиллагаанд суралцах
10	Шүүхийн зардал ба улсын тэмдэгтийн хураамж	1	- Лекц	- Шүүхийн зардал ба улсын тэмдэгтийн хураамжийг тодорхойлох
11	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, түүний төрөл	2	Лекц	- Шүүхийн шийдвэрийн төрөл, тэдгээрийн учир холбогдол \захирамж, тогтоол шийдвэр г.м\ - Шүүхийн шийдвэрийн бүтэц
12	ЗХШ-ийн шийдвэр биелүүлэх ажиллагаа	2	Лекц	- ЗХШ-ийн шийдвэр биелүүлэх ажиллагаа, түүний онцлог - Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх нь - Албадан гүйцэтгэх онцлог
	Бүгд	16	Лекц	
13	Нэхэмжлэлийн үндэслэлийг шалгах \загвар хичээл\	3	Тохиолдол шинжлэх арга \case study\	- Захиргааны бодлого бодох аргачлал - Хууль тогтоомжийн лавламж \мэдээллийн сан\ ангиллаар хайх - Шүүхийн практик ашиглах
14	Урьдчилан шийдвэрлүүлэх гомдолд тавигдах шаардлага	2	- Тохиолдол шинжлэх арга - Эвлүүлгийн арга	Гомдлыг каталогийн дагуу шалгах



15	Гомдлын үндэслэл	2	Тохиолдол шинжлэх арга	<ul style="list-style-type: none">- Захиргааны акт зорилгодоо нийцсэн эсэхийг шалгах онцлог- Захиргааны акт хууль зүйн үндэслэлтэй эсэхийг шалгах онцлог
16	ЗХШ-д нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөл, нэхэмжлэл гаргахад туслах ажиллагаа	2	<ul style="list-style-type: none">-Тохиолдол шинжлэх арга-Бичил багаар ажиллах арга	<ul style="list-style-type: none">- ЗХШ-ийн хэргийн харьяаллыг тодорхойлох- Өөрийнх нь эрх зөрчигдсөн эсэх г.м- “Дутуу” үбүрдэлгүй нэхэмжлэл, шүүхэд хандах, нэхэмжлэгчид туслах үйлдэл
17	Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа	2	<ul style="list-style-type: none">-Тохиолдол шинжлэх арга-Бичил багаар ажиллах арга	<ul style="list-style-type: none">- Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн жишиг ажиллагаа- Шаардлагатай бусад ажиллагааг тодорхойлох, явуулах чадвар эзэмших
18	Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх	2	-Тохиолдол шинжлэх Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга	Түдгэлзүүлж болох нөхцөл байдал болон түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдлуудыг холбосон казус бодох
19	Бусад оролцогч	2	Хүн бүр багш Эвлүүлгийн арга	Оюутан бусад оролцогч болж “тоглол” өөрсдийн эзэмшсэн мэдлэгийг шалгах, бусдад богино хугацаанд түгээх
20	Захиргааны хэргийн нотлох баримт	2	Эвлүүлгийн арга	Оюутан “мэргэжилтэн” болж богино хугацаанд нотлох баримт болон нотолгооны хэрэгслийн талаар мэдээлэл олж авч харилцан солилцоно
21	Нэхэмжлэлийн үндэслэл	2	Цомхон багаар ажиллах	Нэхэмжлэлийн үндэслэлийг цомхон багаар судлан, харилцан мэдээлэл солилцож, дүн шинжилгээ хийх
22	Шүүх бүрэлдэхүүн, шүүгчийг татгалзан гаргах	2	Хүн бүр багш	Оюутан бүр шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах үндэслэлийг судалж мэдээлэл түгээх
23	Анхан шатны шүүх хуралдаан	4	<ul style="list-style-type: none">- Дүрд тоглох- Шүүх хуралдаанд сууж дүгнэж ярилцах	Тодорхой тохиолдол сонгон оюутан дүрд хувилж тухайн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх жүжигчилсэн тоглолтыг явуулж дүгнэх

ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ

ГАРЫН АВЛАГА

24	Давж заалдах шатны журмаар ЗХХША	2	Эвлүүлгийн арга	Оюутан “мэргэжилтэн” болж богино хугацаанд ДЗШ-ны талаар мэдээлэл олж аван мэдээллээ харилцан солилцоно
25	Хяналтын шатны журмаар ЗХХША	3	Эвлүүлгийн арга	Оюутан “мэргэжилтэн” болж богино хугацаанд хяналтын шатны талаар мэдээлэл олж аван мэдээллээ харилцан солилцоно
26	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллагаа	2	Цомхон багаар ажиллах	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин үндэслэлийг цомхон багаар судлан, харилцан мэдээлэл солилцож, дүн шинжилгээ хийх
	Бүгд	32	Семинар	
	Нийт цаг	48	Лекц семинар	



II. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

НЭГ. ҮНДСЭН ОЙЛГОЛТ

СЭДЭВ 1. Захиргааны процессын эрх зүйн ойлголт

Сэдвийн зорилго: Захиргааны процессын эрх зүйг салбар эрх зүйн үндсэн

шалгуураар авч үзсэнээр бусад салбар эрх зүйгээс ялгагдах онцлогийг тодорхойлж, уг эрх зүйн суурь асуудлаар өөрийн үзэл бодлыг илэрхийлэх чадвараа бататган, эрх зүйн харилцаан дахь асуудалд процессын эрх зүйн үүднээс хандах хандлага төлөвшүүлэхэд оршино.

Нэр томъёоны тайлбар

- **Процесс-** Үргэлжлэл, явц гэсэн утгатай латин нэр томъёо. Нэг үе шатнаас нөгөө үе шатыг заавал дамжих замаар эцсийн тодорхой үр дүнд хүрэхэд чиглэсэн харилцан уялдаатай хэрэгжих үйл явцыг хэлнэ
- **Хууль зүйн процесс-** Эрх зүйн маргаан хянан шийдвэрлэх үйл явц
- **Процессын эрх зүй-** Хүний амь нас, эрх эрх чөлөө, өмчтэй холбогдон үүссэн маргааныг эрх бүхий субъектээс хянан шийдвэрлэх харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээ, зарчмуудын нийлбэр
- **Ажиллагаа-** Тодорхой төрлийн хэрэг хянан шийдвэрлэх үе шатны нийлбэр. Процессын эрх зүй нь дотоод бүтцийн хувьд харьцангуй бие даасан ажиллагаануудаас бүрдэнэ.
- **Материаллаг эрх зүй-** Эрх зүйн харилцаанд оролцогч субъектүүдийн эрх, үүрэг болон тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлон зохицуулж буй хэм хэмжээ, зарчмуудын нийлбэр
- **Процедур-** Эрх бүхий субъектээс материаллаг хуулиар олгогдсон эрх, үүргээ тодорхой үе шатаар, бие даан хэрэгжүүлэх үйл ажиллагаа

ӨРГӨН

ЯВЦУУ

ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ГЭЖ ЮУ ВЭ?

Онолын утгаар Захиргааны процессын эрх зүй гэдэг нь нийтийн захиргааны захирамжилсан шийдвэр, үйл ажиллагааны явцад төдийгүй иргэн, захиргааны хоорондын эрх тэгш харилцаанаас үүссэн бөгөөд ҮХЦ, ердийн шүүхэд харьяалагдахаас бусад нийтийн эрх зүйн маргааныг дээд шатны захиргаа болон ЗХШ-ээс ерөнхий заалтын зарчмын дагуу хүлээн авч хянан шийдвэрлэх үйл явц мөн.

Хуульчлагдсан утгаараа захиргааны процессын эрх зүй нь нийтийн захиргааны зөвхөн захирамжилсан шийдвэр, үйл ажиллагаа “захиргааны акт”-ны улмаас тухайн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн талаарх нийтийн эрх зүйн маргааныг дээд шатны захиргаа болон ЗХШ-ээс жагсаалтын зарчмын дагуу хүлээн авч хянан шийдвэрлэх явцад үүссэн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээ, зарчмуудын нийлбэр юм.

ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ

ГАРЫН АВЛАГА



Захиргааны процессын эрх зүй нь нэг талаас мөрдөн шалгах зарчмыг баримталдагаараа эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйтэй төсөөтэй шинжтэй бол нөгөө талаар нэгэн зэрэг диспозитив зарчмыг баримталдагаараа иргэний процессын эрх зүйтэй нийтлэг шинжтэй бөгөөд энэ байдал нь захиргааны процессын эрх зүйг хосолмол шинжтэй гэж нэрлэхэд хүргэж буй юм. Мөн захиргааны процессын эрх зүй нь маргаан хянан шийдвэрлэдэг байдлаараа процессын эрх зүйн нийтлэг шинжийг өөртөө агуулдаг бөгөөд энэ шинж болон эрх зүйн харилцааны субъектын гурвалсан шинжээрээ захиргааны материаллаг эрх зүйгээс зааглагдан ялгагддаг онцлогтой.

Дээрх үндсэн шинж онцлогоос үүдэн дараахь төрлийн ажиллагаа буюу харилцаа захиргааны процессын эрх зүйд хамаарахгүй. Үүнд:





Учир нь энэхүү 3 төрлийн ажиллагаа буюу харилцаа нь захиргааны захиргааны акт гаргахад чиглэгдсэн материаллаг эрх зүйн ажиллагаа буюу харилцаа юм.

Захиргааны процессын эрх зүй нь нийтлэг шинж бүхий бие даасан ажиллагаанаас бүрдэх бөгөөд үүнийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж нэрлэнэ.

ЗХХША нь хэрэгжих үе шат, журам, эрхлэн явуулах субъектын онцлогоос хамааран дараахь хоёр төрөлд хуваагдана. Үүнд:

- захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа
- захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа

Хяналтын асуулт:

- Процессын хууль зүйн утга нь юу вэ? Түүнийг процессын талаарх энгийн түүнчлэн бусад шинжлэх ухааны салбарт авч үздэг ойлголтоос хэрхэн зааглаж авч үзэх вэ?
- Захиргааны процессын эрх зүйг захиргааны материаллаг эрх зүйгээс зааглах гол шалгуурыг нэрлэнэ үү?
- Захиргааны процессын эрх зүй нь бусад процессын эрх зүйн салбаруудаас ялгарах онцлог, шалгуурыг тайлбарлана уу?

Сорил

1. Монгол улсын ЗПЭЗ-н нэг үндсэн шинж

- а. Эрх бүтээх шинж
- б. Захирах, захирагдах харилцаанаас үүссэн маргаан
- в. Эрх зүйн маргаан

2. ИПЭЗ ба ЗПЭЗ-н нийтлэг тал

- а. Мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлдгээрээ
- б. Ихэнхдээ болон зарим тохиолдолд УША хэрэгжүүлэхийг шаарддагаараа
- в. Маргаанд оролцохын өмнө талууд “адил зэвсэгтэй” байдгаараа

3. ЭБШЭЗ ба ЗПЭЗ-н ялгаа

- а. Мөрдөн шалгах зарчим хэрэгжүүлдэгээр
- б. Мөрдөн шалгах зарчим төгс хэрэгжих эсэхээр
- в. УША хийгддэгээр

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Friedhelm Hufen. Verwaltungsprozeßrecht. 3. Auflage. München 1998

3. Ballentine's law Dictionary. Calif. 1969. P-1001
4. Duden, Deutsches Universalwörterbuch. 1996. S-1191
5. “Монголын Төр, эрх зүй” сэтгүүл. 2005 он. №4
6. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3

Сэдэв 2. Захиргааны процессын эрх зүйн зарчим

Сэдвийн зорилго: Захиргааны процессын эрх зүйн зарчимтай танилцаж, тэдгээрийг хэрэглэх онол, арга зүйн чадварыг эзэмшихэд чиглэнэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Эрх зүйн зарчим-** Эрх зүйн мөн чанар, түүний гол шинжийг илэрхийлсэн бөгөөд эрх бүхий субьектээс үйл ажиллагаандаа мөрдлөг болговол зохих үзэл баримтлал
- **Захиргааны процессын эрх зүйн зарчим-** Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдод адил тэгш эрхтэйгээр оролцох нөхцлийг бүрдүүлэх болон уг эрх зүйн харилцааны явцад үүссэн бэрхшээл, төвөгтэй асуудлыг даван туулахад удирдлага болговол зохих үзэл баримтлал.
- **Мэдэгдэх ба сонсгох зарчим:** “Audi alteram partem” буюу “нөгөө талаа сонсох” гэсэн зарчим эртний Римийн үеэс эхтэй бөгөөд өнөө үед процессын эрх зүйн нэг гол зарчим болон тогтжээ. Мэдэгдэх гэдэг нь процессын эрх зүйн үүднээс авч үзвэл процессын оролцогчдыг ЗХХША-нд урьж оролцуулахаар урьдчилан мэдэгдэхийг хэлнэ. Сонсгох гэдэг нь хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, нотлох баримт гаргаж өгөх, шүүхэд хүсэлт гаргах, хамгийн гол нь шүүх хуралдаанд үг хэлэх байдлаар илэрнэ.
- **Тэгш байдлын зарчим:** Мэдэгдэх ба сонсгох зарчмын үндсэн дээр хэрэгжинэ. Тэгш байдлын зарчим нь ажиллагаанд талуудын эрхийг тэнцвэржүүлэх болон шүүх төвийг сахих, шударгаар хандах үүргээр илрэлээ олно.
- **Мөрдөн шалгах зарчим:** Хэргийн нөхцөл байдлыг илрүүлэх, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг ЗХШ гүйцэтгэхээр хуульд заасан нь энэ зарчмын илрэл юм. Энэ нь хэргийн оролцогчдын эрх тэгш байдлыг хангах зорилгоос үүдэлтэй. Учир нь захиргааны хэрэг бол үндсэндээ иргэн, захиргааны хоорондын захирах, захирагдах харилцаанаас үүссэн маргаан байдаг. Энэ зарчмын гол агуулга нь хэрэгт ач холбогдолтой нотлох баримтыг шүүх албаны шугамаар бүрдүүлэх бөгөөд хэргийн оролцогчдоос ирүүлсэн нотлох баримт нь уг хэрэгт хамааралгүй, хууль зүйн ач холбогдолгүй гэж шүүх үзвэл түүнийг үгүйсгэх, хүлээн авахаас татгалзах, ийм баримтыг хэргийн баримтаас хасах эрх бүхий байдагт оршино.
- **Диспозитив зарчим:** Энэ зарчим нь ЗХШ маргааныг талуудын тавьсан шаардлагын хүрээнд л шийдвэрлэх гэсэн утгыг илэрхийлнэ. Энэ нь



нэхэмжлэл гаргах, нэхэмжлэгч нэхэмжлэлээ өөрчлөх, түүний шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэх зэрэг нь зөвхөн хэргийн оролцогчдын эрхэд байдгаар тайлбарлагдана.

- **Шүүх хуралдааныг амаар, шууд явуулах зарчим:** Шүүх хуралдааныг нээх, ирд танилцуулах, эрх, үүргийг нь тайлбарлаж өгөх, нотлох баримтыг шинжлэх, шүүхийн шийдвэрийг сонсгох зэрэг нь зөвхөн амаар явагдана. Шууд явуулах гэдэг нь шүүх хуралдааны үеэр хийгдэх нотолгооны ажиллагааг багтаасан ойлголт юм.
- **Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах:** Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах зарчмын ач холбогдол нь шүүхийн анхаарлыг нэг хэрэгт төвлөрүүлж, шүүгчийн дотоод итгэл бүрдэхэд нөлөөлөх бүх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.
- **Шүүх хуралдааныг нээлттэй явуулах:** Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

Захиргааны процессын эрх зүйн зарчим нь нэг нь нөгөөтэйгээ уялдсан цогц шийдэл төдийгүй бусад салбар эрх зүйгээс зааглах нэг гол шалгуур болдог онцлогтой.

Хяналтын асуулт:

- Процессын зарчим хэнд зориулагддаг вэ?
- Зарчим зөрчигдсөнөөс үүсэх үр дагаврыг хэн хариуцах вэ?
- Захиргааны процесст мөрдөн шалгах зарчим төгс хэрэгжих үү?
- Захиргааны хэргийн хяналтын шатны шүүхэд диспозитив зарчим хамаарах уу?

Сорил

1. Мэдэгдэх ба сонсгох зарчим

- а. Нотлох баримт гаргаж өгөхийг шүүхээс шаардах
- б. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангах боломжийг нэхэмжлэгчид олгох
- в. Хэргийн оролцогчоос шүүгч асууж тодруулах

2. Диспозитив зарчмын гол онцлог

- а. Маргааны талуудын тавьсан шаардлагын хүрээнд л шийдвэрлэх
- б. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах
- в. Талууд эвлэрэх

3. Тэгш байдлын зарчим

- а. Нотлох баримт гаргаж өгөхийг шүүхээс шаардах
- б. Шүүх ажиллагаанд биеэр оролцох
- в. Шүүгч татгалзан гарах

Дасгал

1. Захиргааны хэргийн шүүх хуралдааны танхимд дэг сахиулагч эхний 30 хүнийг оруулаад дараагийн 15 хүнийг танхимын багтаамж хүрэлцэхгүй тул оруулаагүй байна. Энэ нь тэгш байдлын зарчмыг зөрчих үү?

2. ЗПЭЗ-н хамгийн гол зарчмыг үндэс болгон ЭБШЭЗ ба ИПЭЗ-тэй харьцуулсаны үндсэн дээр ЗПЭЗ нь уг хоёр эрх зүйн хаана, хэрхэн байрлахыг зурж үзүүлнэ үү?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Friedhelm Hufen. Verwaltungsprozeßrecht. 3. Auflage. München 1998
3. “Монголын Төр, эрх зүй” сэтгүүл. 2004 он. №2
4. “Государство и право”, 2001, №3
5. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45

СЭДЭВ 3. Захиргааны процессын эрх зүй ба бусад салбар эрх зүйн харилцан хамаарал

Сэдвийн зорилго: Захиргааны процессын эрх зүйн бусад салбар эрх зүйтэй уялдах байдлыг тодорхойлж, түүнийг танин мэдэх, мэргэшлийн зөв хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Нэр томъёоны тайлбар

- **Эрх зүйт төр-** Төр нь зөвхөн эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулах буюу түүнд зөвхөн хууль ноёрхох ёстой гэсэн ойлголт. Төрийн эрх мэдэл зохих ёсоор хуваарилагдсан байх, хүний эрх эрх чөлөөг хангах, хууль дээдлэх нь эрх зүйт төрийн гол элементүүд юм.
- **Ардчилал-** Ард түмний засаг гэсэн утгатай. Ардчилсан ёсны зайлшгүй чухал элементийн нэг болох цөөнхийг хамгаалах нь хууль зүйд тэр дундаа процессын эрх зүйд шууд хамааралтай ойлголт болох юм.
- **Үндсэн эрхийн өдөр тутмын хэрэгжилт-** Гүйцэтгэх эрх мэдлийн



хүрээнд захиргааны байгууллагуудын хувьд үндсэн эрхийн өдөр тутмын хэрэгжилтийг хангах үүргээ биелүүлж буй эсэх нь чухлаар тавигддаг. Иймд үндсэн эрхийн өдөр тутмын хэрэгжилттэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх үүргийг Үндсэн хуулийн шүүх бус Захиргааны шүүх хэрэгжүүлдэг.

- **Захиргааны акт**- Захиргааны процессын эрх зүйд хамгийн ойр байж, түүнд тогтмол нөлөөлж ирсэн захиргааны материаллаг эрх зүйн үндсэн элемент бол захиргааны актын тухай сонгодог ойлголт юм. Захиргааны байгууллагаас гаргаж, тодорхой нэг тохиолдолтой холбоотой бөгөөд түүнийг зохицуулахад чиглэгдсэн байх зэрэг шинжүүд нь орчин үеийн захиргааны шүүхийн үйл ажиллагаанд хамгийн ихээр нөлөөлөгч элемент гэж үздэг.
- **Объектив эрх зүйн хяналт**- Объектив эрх зүй бол тухайн нэг хувь хүнд хамааралгүй бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн хэм хэмжээний нийлбэр юм. Объектив эрх зүйн хяналтыг ҮХЦ хэм хэмжээний хийсвэр хяналтын хэлбэрээр тавьж байна.
- **Субъектив эрх зүйн хамгаалал**- Субъектив эрх гэдэг бол хувь хүнд хамаатай бөгөөд тодорхой нэг тохиолдолд хэрэглэж болох эрхийг хэлнэ. Хуулийн этгээдийн хувьд хэрэглэж болохоор бол түүнийг субъектив эрхтэй гэж үзнэ. Субъектив эрх зүйн хамгааллыг ЗХШ хэрэгжүүлдэг.
- **Шалгалтын хэмжүүр**- Шүүх, эрх бүхий субъект тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хэмжүүр болгон хэрэглэж буй материаллаг хууль юм.
- **Гомдлоор авч хэлэлцэх хэрэг**- Захиргааны байгууллагаас гаргасан дотогш үйлчлэл бүхий акт болон эрх зүйн шууд үр дагаваргүй үйлдэлтэй тус тус холбогдон үүссэн маргаан

Хяналтын асуулт

1. Захиргааны процессын эрх зүй нь материаллаг Үндсэн хуулийн эрх зүйтэй хэрхэн холбогдох вэ? Түүний агуулгыг тайлбарлана уу?
2. Захиргааны процессын эрх зүй ба Үндсэн хуулийн процессын эрх зүйг зааглаж буй шалгуурыг тодорхойлно уу?
3. Захиргааны процессын эрх зүй болон Захиргааны эрх зүй хоёрыг холбогч сэжим нь юу вэ?
4. Хувийн эрх зүйн маргаан нь нийтийн эрх зүйн маргаан болон хөгжих зүй тогтол байгаа эсэхийг тодорхой жишээ татан тайлбарлана уу?

Сорил

1. Ардчилал нь хууль зүйн үүднээс:
 - а. Халдашгүй чөлөөтэй байх эрх
 - б. Жагсаал цуглаан хийх эрх
 - в. Сурч боловсрох эрх юм.

2. Дараахь өгөгдлийн аль нь үндсэн эрхийн өдөр тутмын хэрэгжилтэд хамаарах вэ?
 - а. Өөрийн эрүүл мэндээ хамгаалуулах
 - б. Хуулийн хэлэлцүүлэгт оролцох
 - в. Ард нийтийн санал асуулга явуулах үйл ажиллагаа
3. Захиргааны процессын эрх зүй ба Үндсэн хуулийн процессын эрх зүйг зааглаж буй шалгуур аль нь вэ?
 - а. Шалгалтын хэмжүүр
 - б. Нийтийн эрх зүйн маргаан хянан шийдвэрлэх
 - в. Үндсэн эрхийг хамгаалах байдлаар
4. Дараахь тохиолдлоос аль нь захиргааны процессын эрх зүй ба иргэний процессын эрх зүйн уялдаа холбоог илэрхийлж байна вэ?
 - а. Төр ба хувийн хэвшлийн хамтран ажиллах үйл ажиллагаа
 - б. Төрийн албан хаагчид сануулах арга хэмжээ авсан үйлдэл
 - в. Тендерын дагуу төрийн байгууллагын худалдан авах ажиллагаа

Дасгал

1. Нийтийн эрх зүйн гэрээнээс үүссэн маргаан нь Захиргааны процессын эрх зүй ба өөр аль салбар эрх зүйн уялдаа холбоог илүүтэй илэрхийлэх вэ?
2. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч телевизээр гадаадаас импортолж буй гоймон хадгалалтын шаардлага хангахгүй байгааг анхааруулж, импортын гоймон худалдаж авахгүй байх сэрэмжлүүлэг хийв. Энэ асуудалтай холбоотой маргаан үүсвэл Захиргааны процессын эрх зүй ба өөр аль салбар эрх зүйн хоорондын уялдааг илүүтэй илэрхийлж байна вэ?
3. Төрийн жинхэнэ албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулжээ. Уг асуудлаас маргаан үүссэн гэж үзвэл Захиргааны процессын эрх зүй ба өөр аль салбар эрх зүйн хоорондын уялдаа холбоог илүүтэй илэрхийлж байна вэ?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Friedhelm Hufen. Verwaltungsprozeßrecht. 3. Auflage. München 1998
3. Ц.Сарантуяа. “Төрийн ерөнхий онол”, УБ, 1998
4. Н.Лүндэндорж “Төрийн онол”, УБ, 2008



СЭДЭВ 4. Нийтийн эрх зүйн маргаан ба захиргааны хэрэг

Сэдвийн зорилго: Нийтийн эрх зүйн маргааны ойлголт, агуулгатай танилцаж, түүнийг практикт хэрэглэх чадварыг эзэмшихэд чиглэгдэнэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Нийтийн эрх зүйн маргаан-** Материаллаг нийтийн эрх зүйн харилцааны явцад үүссэн маргаан.
- **Захиргааны хэрэг-** Өргөн буюу онолын утгаар ЗХШ-д хамаарч байгаа төдийгүй, түүнд харъяалагдвал зохих нийтийн эрх зүйн маргаан юм. Явцуу буюу хуульчлагдсан утгаар нь авч үзвэл иргэн, захиргааны хоорондын захирах, захирагдах харилцаанаас үүссэн маргааныг хэлнэ.
- **Ашиг сонирхлын онол (Interessentheorie)** - Уг онол ёсоор нийтийн ашиг сонирхолд нийцэж, уг ашиг сонирхлыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг нийтийн эрх зүй гэж үзэх бөгөөд түүнээс үүсэн гарч буй маргааныг нийтийн эрх зүйн маргаан гэнэ. Харин хувийн сонирхлыг илэрхийлж, түүнд нийцэж байвал хувийн эрх зүйд хамааруулах бөгөөд уг маргаан нь хувийн эрх зүйн маргаан болно.
- **Захирагдах ёсны онол (Subordinationstheorie)** - Захиргаа, иргэний хооронд захирах, захирагдах шинжтэй харилцаа үүсч байвал нийтийн эрх зүйд хамааруулах бөгөөд уг харилцаанаас үүссэн маргаан нь нийтийн эрх зүйн маргаан болох юм.
- **Субъектын онол (Subjekttheorie)** - Уг онол нь хуучин субъектын онол болон тусгай эрхийн онол гэж хуваагдана. Хуучин субъектын онол ёсоор эрх зүйн харилцааны нэг талд нь захиргааны эрх бүхий эрх бүхий субъект оролцож түүнийг нийтийн эрх зүйн харилцаа гэж үзэх бөгөөд энэ нь иргэн, захиргааны хоорондох захирах, захирагдах харилцаа төдийгүй, тэдгээрийн хоорондын эрх тэгш харилцаа ч нийтийн эрх зүйд хамаарна гэсэн агуулгатай юм.

Тусгай эрхийн онол нь уг харилцаа “хэн бүрт” хамаарах эрх зүйн зохицуулалттай юу, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэхээр хүлээсэн үүрэгтэй холбоотой юу гэдгээс хамаарна. Хэрэв тухайн эрх зүйн хэм хэмжээ нь “хэн бүрт” хамаатай бол хувийн эрх зүйд, харин төр түүнийг төлөөлсөн субъектын үйл ажиллагааг тусгайлан тогтоож өгсөн хэм хэмжээ байвал нийтийн эрх зүйд хамаарна гэж үздэг.

Өнөөгийн судлаачдын дийлэнх нь нийтийн эрх зүйн маргааныг тодорхойлохын тулд дээрх онолуудыг хослуулан хэрэглэхийг зөвлөж байна. Нийтийн эрх зүйн маргаан ба хувийн эрх зүйн маргааныг ялгахад бэрхшээлтэй үед эдгээр онолыг дэс дараалан хэрэглэхийг зохистой гэж үздэг. Нийтийн эрх зүйн маргааныг хувийн эрх зүйн маргаанаас зааглахдаа мөн салбар эрх зүйн болон шүүхийн практик гэсэн шалгуураар улам гүнзгийрүүлэн хөгжүүлжээ.

Хяналтын асуулт:

1. Нийтийн эрх зүйн маргааныг хувийн эрх зүйн маргаанаас зааглах шалгууруудыг нэрлэнэ үү?
2. Ашиг сонирхлын онолын гол агуулгыг тайлбарлана уу?
3. Тусгай эрхийн онолын агуулга юу вэ?
4. Захиргааны хэргийн ойлголтын онолын үндэслэлийг тайлбарлана уу?
5. Нийтийн эрх зүйн гэрээний маргаан нь захиргааны маргаан мөн үү?

Сорил

1. Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй дэх захиргааны хэргийн ойлголт
 - а. Захиргааны байгууллагын захирах захирагдах харилцаанаас үүссэн маргаан
 - б. Эрх тэгш харилцаанаас үүссэн маргаан
 - в. Нийтийн эрх зүйн маргаан
2. Захиргааны хэрэг гэдэг нь
 - а. Ажиллагаа
 - б. Ажил хэрэг
 - в. Маргаан
3. Захиргааны шүүхийн практикаар үүссэн онол
 - а. Ашиг сонирхлын онол
 - б. Хоёр шатны онол
 - в. Тусгай эрхийн онол

Дасгал

- Хүүхэд нэртэй байх нь хэний ашиг сонирхолд нийцэх вэ? Энэ шаардлагыг хаанаас тавьдаг вэ? Энэ тохиолдолд уг харилцаа аль эрх зүйгээр зохицуулагдах вэ?
- Хүүхэд хэн гэдэг нэртэй байх нь хэний ашиг сонирхолд нийцэх вэ? Маргаан үүсвэл түүнийг аль эрх зүйд хамааруулах вэ?

Эх сурвалж

5. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
6. Friedhelm Hufen. Verwaltungsprozeßrecht. 3. Auflage. München 1998



ХОЁР. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНЦЛОГ АЖИЛЛАГАА

СЭДЭВ 5. Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны ойлголт, чиг үүрэг

Сэдвийн зорилго: Захиргааны хэрэг УША-ны ойлголт, онцлогийг танин мэдэж түүний чиг үүргийг тодорхойлно.

Нэр томъёоны тайлбар:

- **Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа-** Захиргааны актыг хууль бус гэж үзэж эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг тухайн шийдвэр гаргасан захиргааг шууд харьяалах дээд шатны захиргаа нь процессын эрх зүйн хэм хэмжээний дагуу хянан шийдвэрлэх үйл ажиллагаа.
- **Гомдол гаргах эрх-** Энэ нь үндсэн эрх бөгөөд иргэний гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх, түүнийг төрийн байгууллага хуулийн дагуу шийдвэрлэх үүргээр агуулга нь тодорхойлогдоно.
- **Урьдчилан шийдвэрлүүлэх гомдол-** Иргэн захиргааны акттай холбоотой гомдлоо уг шийдвэрийг гаргасан захиргааны шууд харьяалах дээд шатны захиргаа болон эсхүл хөндлөнгийн хараат бус байгууллагад хандан гаргаж байгаа эсэргүүцэл.
- **Шууд харьяалах дээд шатны захиргаа-** Тухайн акт гаргасан захиргааны дээд шатны буюу хоёр дахь шатны захиргааны байгууллага, албан тушаалтныг хэлнэ. Агуулгаар нь авч үзвэл уг захиргааны байгууллагыг байгуулах, татан буулгах, албан тушаалтныг сонгох, томилох, тэдний гаргасан тушаал, шийдвэр, тогтоол, захирамжийг өөрчлөх буюу хүчингүй болгох эрх бүхий удирдах байгууллага юм. Хөндлөнгийн хараат бус агентлагийг шууд харьяалах дээд шатны захиргаатай адилтган үзнэ.



1. Захиргааны хэрэг УША нь “хоёрдмол” шинжтэй ажиллагаа юм. Нэг талаас уг ажиллагаа нь процессын буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа юм. Энэ нь УША нь захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаатай чиг үүргийн уялдаа холбоотой юм. Тухайлбал, хэргийн харьяалал, гомдол ба нэхэмжлэлийн шаардлагын агуулга, тэдгээрийн хууль зүйн үндэслэл зэрэг нь давхцах шинжтэй бөгөөд нэг нь урьдчилсан нөгөө нь эцсийн байдлаар явагдах процессын ажиллагаануудын нийлбэр юм.
2. УША нь процессын бие даасан шинжийг өөртөө агуулна. Энэ нь УША-ны хүрээнд дээд шатны захиргаанаас бие даасан шийдвэр гаргадаг бөгөөд уг шийдвэрт гомдол гаргаагүй тохиолдолд тэр нь эцсийн шийдвэр болох боломжийг агуулж байдгаар тайлбарлагдана.
3. УША-ны хүрээнд гомдлыг зөвхөн нэг л шатаар хянуулах онцлог бий. Энэ нь гомдлыг захиргааны бүх шатыг дамжуулж, гомдол гаргагчийг чирэгдүүлэхгүй гэсэн хууль тогтоогийн шийдэл. Тэрхүү нэг шат нь тухайн захиргааг шууд харьяалах дээд шатны захиргаа юм.
4. Шууд харьяалах дээд шатны захиргаанаас хэргийг урьдчилан шийдвэрлээд гаргасан шийдвэр нь эцсийн шийдвэр биш байдаг онцлогтой.



1. Захиргааны актын улмаас иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тухай гомдлыг үндэслэн иргэнд эрх зүйн хамгаалал үзүүлэх нь УША-ны эхний зориулалт юм.
2. Захиргааны байгууллага гаргасан алдаагаа эхлээд өөрийн тогтолцоондоо засах боломжийг олгох нь УША-ны хоёрдахь зориулалт болно.
3. Иргэн ЗХШ-д хандан нэхэмжлэл гаргахаас өмнө гомдлоо дээд шатны захиргаагаар хянуулах нь шүүхийн ачааллыг багасгахад чиглэсэн түүний гуравдахь зориулалт болно.



Хяналтын асуулт

1. УША нь бусад процессын эрх зүйгээс захиргааны процессын эрх зүйн ялгарах нэг онцлог мөн үү?
2. Ерөнхий гомдол ба урьдчилан шийдвэрлүүлэх гомдлын ялгааг тайлбарлана уу?
3. Процессын гомдол гэж юу вэ?
4. УША-ны эрх зүйн хамгаалал үзүүлэх чиг үүргийг тодорхой жишээн дээр тайлбарлана уу?

Сорил

1. Урьдчилан шийдвэрлүүлэх гомдол нь:
 - а. Хүсэлт
 - б. Эсэргүүцэл
 - в. Өргөдөл
2. Өнөөгийн ЗХХШТХ нь шүүхийн ачааллыг багасгах чиг үүрэгт:
 - а. Бүрэн нийцнэ
 - б. Нийцэхгүй
 - в. Зарим талаар нийцэхгүй
3. Захиргааны хэрэг УША-ны хоёрдмол шинж
 - а. Хэргийн харьяалал
 - б. Захиргааны актын бодит үндэслэл
 - в. Хөндлөнгийн шинж

Дасгал

1. Өнөөгийн Татварын ерөнхий хуулийн §72.1.3-72.1.4-т татвар төлөгч нь татварын улсын байцаагчийн шийдвэртэй холбоотой гомдлоо тухайн байцаагчийн шууд харьяалах татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлд, Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлыг дээд шатны татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлд тус тус гаргахаар заасан нь УША-ны зориулалтад нийцэх үү?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Friedhelm Hufen. Verwaltungsprozeßrecht. 3. Auflage. München 1998

3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
4. Татварын ерөнхий хууль. ТМ эмхтгэл. 2008 он. №22

СЭДЭВ 6. Урьдчилан шийдвэрлүүлэх гомдолд тавигдах шаардлага

Сэдвийн зорилго: Дээд шатны захиргаанд гаргасан гомдолд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийх эсэхийг шалган шийдвэрлэх чадварыг эзэмшихэд чиглэнэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Гомдол гаргах эрх нээгдэх нөхцөл-** Гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхэд иргэнд хуулиар тавигдаж буй шаардлагыг хэлнэ

Гомдол гаргах эрх нээгдэх нөхцөл:

Хуулиар тавигдах шаардлага	Агуулга
Харьяалал	- Урьдчилан шийдвэрлүүлэх гомдлын хэргийн харьяалал нь ЗХШ-ийн харьяаллын хүрээнд байна. Хэрэв тухайн маргаан нь ЗХШ-д харьяалагдахгүй бол УША явуулах шаардлага тавигдахгүй
Бүрдүүлбэр	- Гомдлыг бичгээр эсхүл цахим сүлжээгээр гаргах - Гомдол гаргагчийн овог нэр - Оршин суугаа газрын буюу шуудангийн хаяг - Гарын үсэг - Зайлшгүй чухал агуулга
Хөөн хэлэлцэх хугацаа	-Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн хуулийн этгээд холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлоо гаргана
Субъектив эрх	Гомдлыг иргэн, хуулийн этгээд өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тухай асуудлаар гаргана. Харин бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар өөрийн нэрийн өмнөөс гомдол гаргах нь зарчмын хувьд зөвшөөрөгдөхгүй
Эрх зүйн чадвар, чадамж	Гомдлыг эрх зүйн бүрэн чадамж бүхий иргэн гаргана
Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байхгүй байх	Хэрэв тухайн асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа бол гомдлыг хүлээн авахгүй байж болно
Уг асуудлаар өмнө нь гомдол гаргаж шийдвэрлүүлээгүй байх	Гомдолд дурдсан асуудлаар өмнө нь захиргаанд хандаж шийдвэрлүүлээгүй байх



Хяналтын асуулт

1. Гомдол гаргах эрх нээгдэх нөхцөл нь бүхий л гомдолд тавигдах шаардлага мөн үү?
2. Гомдлын хэлбэр, бүтцэд тавигдах шаардлагыг аль хуульд заасан журмаар тодорхойлох вэ?
3. УША-ны хэргийн харьяаллыг аль хуульд заасан журмаар тодорхойлох вэ?
4. УША-ны хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ?

Сорил

1. Урьдчилан шийдвэрлүүлэх гомдолд тавигдах шаардлага
 - а. Гомдол гаргагчийн харилцах утасны дугаар
 - б. Гомдол гаргагчийн ажил, албан тушаал
 - в. Бусад
2. Захиргааны хэрэг УША-ны хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа
 - а. 30 хоног
 - б. 40 хоног
 - в. 90 хоног
3. Захиргааны хэрэг УША-ны хянан хэлэлцэх үе шат:
 - а. Захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах
 - б. Нотлох баримт цуглуулах
 - в. Шинжээчийн дүгнэлтийг шинжлэн судлах
4. Захиргааны хэрэг УША-нд ИТБАТГӨрГомШХ-ийн 13-р зүйлийг баримтлах эсэх?
 - а. Баримтлана
 - б. Баримтлахгүй
 - в. Зарим тохиолдолд баримтлана.

Дасгал

Нэгэн аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн Б-г эрх бүхий захиргааны албан тушаалтан ажлаас үндэслэлгүй халсан тухай шийдвэрийг эс зөвшөөрч тэрээр гомдол гаргах болов.

Дээрх тохиолдолд Б гомдлоо хаана гаргах вэ? Гомдол гаргах эрх нээгдэх нөхцлийг хууль хэрэглэн тодорхойлно уу?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл. 1995, №7. нэмэлт, өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2003, №43, ТМ, 2009, №26

СЭДЭВ 7. Гомдлын үндэслэл

Сэдвийн зорилго: Гомдолд холбогдож буй захиргааны актын зорилгодоо нийцсэн хийгээд хууль зүйн үндэслэлийг шалгах чадварыг эзэмшихэд чиглэнэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Илт хууль бус захиргааны акт-** Захиргааны актын алдаа нь илэрхий ба ноцтой тохиолдлыг хэлнэ. Илэрхий буюу илт алдаатай болох нь энгийн хүний нүдэнд ч ажиглагдахаар байна. Ноцтой алдаа гэдэг нь манай нийгмийн хүлээн зөвшөөрсөн үнэт зүйл болон эрх зүйн журмыг шууд зөрчсөн тохиолдол юм.
- **Маргаан бүхий захиргааны акт-** Захиргааны актын алдаа нь ялимгүй биш бөгөөд мөн илт хууль бус болоход хүргэхээргүй эрх зүйн алдаатай актыг хэлнэ.
- **Захиргааны акт зорилгодоо нийцсэн эсэх-** Энэ нь захиргааны актын бодит үндэслэл юм. Уг актыг гаргах болсон бодит шалтгаан буюу түүний зорилгыг шалгахыг хэлнэ.
- **Гомдол үндэслэлтэй эсэх-** Захиргааны акт хууль бус бөгөөд уг актаар гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд гомдлыг үндэслэлтэй гэж үзнэ.

Хүчингүй болгуулах гомдол дараахь тохиолдолд үндэслэлтэй байна:

- Маргаан бүхий захиргааны акт хууль бус болон зорилгодоо нийцээгүй бол
- Мөн тухайн актаар гомдол гаргагчийн эрх зөрчигдсөн бол

Даалгах гомдлыг дараахь тохиолдолд үндэслэлтэй гэж үзнэ:

- Захиргааны акт гаргахаас татгалзсан нь эсхүл эс үйлдэхүй нь тус тус хууль бус бол
- Уг татгалзсан шийдвэр болон эс үйлдэхүйн улмаас гомдол гаргагчийн эрх зөрчигдсөн бол



- Гомдол гаргагчид энэхүү даалгах шийдвэр гаргуулах нь зайлшгүй шаардлагатай бол

Захиргааны акт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх тухай гомдол дараахь тохиолдолд үндэслэлтэй байна:

- Гомдолд дурьдсан захиргааны акт нь ЗХХШТХ-ийн §9-д заасан утгаар хүчин төгөлдөр бус болох нь тогтоогдсон.

Хяналтын асуулт

1. Захиргааны актын хууль зүйн үндэслэл болон зорилгодоо нийцсэн эсэхийн алийг түрүүлж шалгах вэ?
2. Захиргааны акт хууль зүйн үндэслэлтэй эсэхийн шалгуур юу вэ?
3. Илт хууль бус болон маргаан бүхий захиргааны актын гол ялгаа юу вэ?
4. Илт хууль бус болон маргаан бүхий захиргааны актын аль нь практикт түгээмэл тохиолддог вэ? Учрыг тайлбарлана уу?

Дасгал

Зөвшөөрөлгүй барьсан барилгаа захиргааны шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 6 долоо хоногийн дотор зайлуулах тухай газрын албанаас акт гарган иргэнд үүрэг болгосон мэдэгдэлд уг иргэн гомдол гаргажээ. Тэрээр гомдолдоо 6 долоо хоногийн хугацааг 12 долоо хоног болгож өгөхийг хүсчээ. Үүнийгээ иргэн өөрийн хүчээр нүүлгэх хүсэлтэй байгаа тул 6 долоо хоногт багтахгүй гэж үндэслэв.

Энэ тохиолдолд уг иргэний гомдол үндэслэлтэй юу? Амжилтад хүрэх үндэслэл бий юу?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45

ГУРАВ. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ОРОЛЦОГЧ БА ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

СЭДЭВ 8. Захиргааны хэргийн оролцогч, тэдгээрийн эрхийг хангах асуудал

Сэдвийн зорилго: Хэргийн оролцогчийн эрх зүйн байдлын онцлог, тэдгээрийн ашиг сонирхлын зааг ялгааг тал бүрээс нь судалж, тэдгээр ашиг сонирхлыг хамгаалах болон хөндлөнгийн байр сууринаас хандах, хэргийн оролцогчийн эрхийг хангах дадал чадварыг эзэмшихэд чиглэнэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Хэргийн оролцогч-** Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй бөгөөд маргааны эцсийн үр дүнг сонирхож буй этгээд юм
- **Нэхэмжлэгч иргэн-** Захиргааны актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн нэхэмжлэгч байна
- **Нэхэмжлэгч хуулийн этгээд-** Захиргааны актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн хувийн эрх зүйн болон нийтийн эрх зүйн хуулийн этгээд нэхэмжлэгч болно
- **Хамтран нэхэмжлэгч-** Нэг захиргааны актын улмаас 20 буюу түүнээс дээш этгээдийн эрх хууль ёсны ашиг сонирхол зэрэг хөндөгдсөн бол хамтран нэхэмжлэгч гэж үзнэ
- **Хариуцагч-** Тухайн захиргааны актыг гаргасан бөгөөд ЗХХШтХ-ийн §4.1-ийн жагсаалтад буй захиргааны байгууллага, албан тушаалтан
- **Хамтран хариуцагч-** Хамтран нэг захиргааны акт батлан гаргасан хоёр буюу түүнээс дээш захиргааны байгууллага
- **Гуравдагч этгээд-** Тухайн захиргааны актын талаар бие даасан шаардлага гаргасан, эсхүлүг актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн буюу хөндөгдөж болзошгүй байгаа бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь зүйтэй гэж ЗХШ шийдвэрлэсэн иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.
- **Хэргийн оролцогчийн эрхийг хангах-** Шүүх хуралдаанд биеэр оролцох боломжийг хангах, нотлох баримттай танилцах эрхийг нь хангах, шүүхэд хандаж хүсэлт гаргах эрхийг нь хангах гэх мэт.

Хэргийн оролцогч болох нэхэмжлэгч, гуравдагч этгээдэд тавигдах хууль зүйн гол шаардлага бол түүний эрх зүйн чадвар, чадамж юм. Шүүхэд захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр заагдсан эрхээ өөрөө хэрэгжүүлж үүргээ биелүүлэх, хариуцлага хүлээх буюу төлөөлөгчөөрөө гүйцэтгүүлэх чадварыг иргэний эрх зүйн



бүрэн чадамжтай этгээд эдэлнэ ЗХХШТХ-§18.1. Харин 16 нас хүрсэн иргэн өөрөө хүсвэл түүний эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр ЗХШ-ээр хэрэг хянан шийдвэрлэхэд иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэний нэгэн адил биечлэн оролцох эрхтэй ЗХХШТХ-§18.3.



- Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд бол нэхэмжлэгч болон хариуцагчийн шаардлагаас агуулгын хувьд өөр шаардлага тавьж байгаа этгээдийг хэлнэ.
- Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд бол хэргийн оролцогчийн хэн нэгтэй нэгэн адил шаардлагатай байгаа гуравдагч этгээд болно.



- Заавал татан оролцуулах шаардлагатай гуравдагч этгээд нь шүүхээс гаргах шийдвэр түүний хувьд эрх зүйн шууд үр дагавартай байдаг. Харин шүүх цэгнэн үзсэний үндсэн дээр оролцуулах гуравдагч этгээдийн тухайд түүний хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөнө гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулна.

Хяналтын асуулт

1. Захиргааны хэргийн оролцогчийг тодорхойлох гол шалгуур юу вэ?
2. Захиргааны хэргийн оролцогч нь иргэний хэргийн оролцогчоос юугаараа ялгаатай вэ?
3. Нэхэмжлэгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох гол шалгуур юу вэ?
4. Хариуцагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох гол шалгуур юу вэ?
5. Гуравдагч этгээдийн эрх зүйн байдлын шалгуур юу вэ?
6. Хэргийн оролцогчийн эрхийг шүүхээс хангах гэдэгт ямар ойлголтыг хамааруулж үзэх вэ?
7. Хэргийн болон бусад оролцогчийн эрхийг шүүхээс хангахдаа ялгамжтай хандах уу?
8. Шүүх дээрх үүргийг гүйцэтгэхдээ өөрийн үзэмжээр хандах уу?

Сорил

1. Нэхэмжлэгч иргэн
 - а. Монгол Улсын иргэн
 - б. Улсын байцаагч
 - в. Газар эзэмших эрхийн гэрчилгээ нь хүчингүй болсон иргэн
2. Нэхэмжлэгч хуулийн этгээд
 - а. Төрийн өмчит үйлдвэрийн газар
 - б. Олон нийтийн радио телевиз
 - в. Оюуны өмчийн газар
3. Хариуцагч
 - а. Хувийн өмчийн дээд сургууль
 - б. Төрийн өмчийн дээд сургууль
 - в. Нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр нийтлэг үйлчилгээ үзүүлдэг эмнэлэг
4. Гуравдагч этгээд
 - а. Улсын байцаагч
 - б. Иргэн
 - в. Төрийн өмчит үйлдвэрийн газар



Дасгал

1. Татварын улсын байцаагч Б нь ТТ компанид татварын актаар торгууль, нөхөн төлбөр ногдуулжээ. Энэ актыг ТТ компани эс зөвшөөрч Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргав. Татварын маргаан таслах зөвлөл уг гомдлыг хянан үзээд ТТ компанийн гомдлыг хүлээн авч улсын байцаагч Б-ийн тавьсан торгууль, нөхөн төлбөрийг хүчингүй болгох шийдвэр гаргав. Татварын улсын байцаагч Б нь Татварын маргаан таслах зөвлөлийн эл шийдвэрийг эс зөвшөөрч Нийслэлийн ЗХШ-д хандан уг шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргажээ.

Энэ маргааны тухайд захиргааны хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг тодорхойлно уу?

2. Нэхэмжлэгч, хариуцагчийн нийтлэг эрх болон тэдгээрийн ялгаатай эрх, түүнчлэн тэдгээрийн нийтлэг үүрэг болон ялгаатай үүргийг тус тус тодорхойлно уу?
3. Гуравдагч этгээдийн эрх, үүргийг нэхэмжлэгч, хариуцагчийн эрх, үүрэгтэй харьцуулан тодорхойлно уу?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45

СЭДЭВ 9. Бусад оролцогч

Сэдвийн зорилго: Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчийн эрх зүйн байдлыг судалж, бусдын эрх ашгийг хамгаалах болон хөндлөнгийн байр сууринаас хандах чадвар төлөвшүүлэхэд чиглэнэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Өмгөөлөгч-** Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй бөгөөд шүүхэд төлөөлөх эрхтэй хуульч
- **Итгэмжлэгдсэн төлөөлөгч-** Төлөөлөгч нь 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байна. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаална. Хуулийн этгээдийг хууль, эрх зүйн бусад акт болон үүсгэн байгуулах баримт бичгийн дагуу олгогдсон эрх хэмжээний хүрээнд байгууллагын эрх баригч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь төлөөлнө.
- **Иргэдийн төлөөлөгч-** Эрх зүйн бүрэн чадамжтай, 25 нас хүрсэн Монгол Улсын иргэн шүүхийн иргэдийн төлөөлөгч байна

- **Шинжээч**- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгайлан эзэмшсэн мэдлэгтэй, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй, Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасны дагуу ЗХШ-ээс томилогдсон этгээдийг хэлнэ
- **Орчуулагч, хэлмэрч**- Хэргийн оролцогч монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий бол түүний хүсэлтээр орчуулагч, хэлмэрчийг захиргааны хэргийн шүүгч захирамж гарган томилно
- **Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга**- Шүүхийн захиргааны ажилтан. Бүх шатны шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ажиллана.



Бусад оролцогч гэдэг нь тухайн хэрэгт хувийн сонирхлын үүднээс бус, харин бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, эсхүл албан үүргийн дагуу оролцож байгаа этгээд юм.



Харин албан үүргийн дагуу оролцогчийн үйл ажиллагаа нь хөндлөнгийн шинжтэй байна.



Хяналтын асуулт

1. Бусад оролцогчийн хэргийн оролцогчоос ялгагдах онцлог юу вэ?
2. Иргэдийн төлөөлөгчийн оролцооны зорилго юу вэ?

Сорил

1. Бусад оролцогч
 - а. Прокурор
 - б. Гэрч
 - в. Хэлмэрч
2. Иргэдийн төлөөлөгч
 - а. Анхан шатны шүүх хуралдаанд оролцоно
 - б. Бүх шатны шүүх хуралдаанд оролцоно
 - в. Зөвхөн анхан шатанд хэргийг хамтын зарчмаар хянан шийдвэрлэхэд оролцоно.
3. Бусад оролцогч ЗХХША-нд оролцох нь
 - а. Зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахын тулд
 - б. Бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд
 - в. Маргааны эцсийн үр дүнг сонирхдог
4. ЗХХША-нд албан үүргийн дагуу оролцогч
 - а. Өмгөөлөгч
 - б. Иргэдийн төлөөлөгч
 - в. Гуравдагч этгээд

Дасгал

1. Анхан шатны ЗХШ нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. Үүнийг эс зөвшөөрч нэхэмжлэгчийн өмгөөлөгч давж заалдах гомдол гаргав. Давж заалдах шатны шүүх хуралдаан товлон зарлагдсаны дараа нэхэмжлэгч гомдолгүй гэдгээ давж заалдах шатны шүүхэд бичгээр гаргажээ. Энэ тохиолдолд нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гомдлын дагуу давж заалдах шатны журмаар хэргийг хянан хэлэлцэх үү?
2. Бусад оролцогчийн эрх, үүргийг нэг бүрчлэн тодорхойлно уу?
3. Прокурор ЗХХША-нд оролцох эрх зүйн үндэслэлийг шүүн хэлэлцэнэ үү?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Шүүхийн шинжилгээний тухай хууль. ТМ, 2010, №02
4. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль. ТМ, 2012, №11
5. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль. ТМ, 2012, №24
6. Шүүхийн тухай хууль. ТМ, 2012, №11

СЭДЭВ 10. Нэхэмжлэлийн ойлголт, төрөл

Сэдвийн зорилго: ЗХШ-д гаргах нэхэмжлэлийн агуулга, онцлогийг танин мэдэж, бусад процессын эрх зүйн хүрээнд гаргадаг нэхэмжлэлээс ЗХШ-ийн нэхэмжлэлийг ялгах чадварыг эзэмшинэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Нэхэмжлэл-** Иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актад холбогдуулан өөрийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар ЗХШ-д хандан гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шаардлага
- **Нэхэмжлэлийн зүйл-** Хэргийн харьяаллыг зааж буй шалгуур шинжийг хэлнэ
- **Хүчингүй болгуулах нэхэмжлэл-** Иргэн, хуулийн этгээдэд дарамт учруулсан захиргааны актын эсрэг чиглэсэн шаардлага
- **Илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл-** Илт хууль бус захиргааны актын эсрэг чиглэсэн шаардлага



- **Даалгах нэхэмжлэл**- Захиргааны акт гаргахгүй байгаа болон эс үйлдэхүйн эсрэг чиглэсэн шаардлага
- **Эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох нэхэмжлэл**- Эрх зүйн харилцаа байгаа болон эсхүл байхгүй фактыг тогтоолгох шаардлага
- **Хохирлоо арилгуулах тухай нэхэмжлэл**- Захиргааны актын улмаас иргэн, хуулийн этгээд өөрт учирсан хохирлоо арилгуулахаар тавьж буй шаардлага

Нэхэмжлэлийн зүйл \approx Захиргааны акт

Захиргааны актын үндсэн шинж	Эсрэг таван шинж
Нийтийн эрх зүйн хүрээнд байх	Хувийн эрх зүйн хүрээ
Захиргааны байгууллага, албан тушаалтан	Парламент, шүүх эрх мэдлийн байгууллага
Тодорхой нэг тохиолдол	Хийсвэр- ерөнхий зохицуулалт = хэм хэмжээ
Зохицуулалт	Бодит үйл ажиллагаа
Гадагш чиглэсэн байх	Дотогш чиглэсэн байх

ЗХШ-Д ГАРГАЖ БУЙ НЭХЭМЖЛЭЛИЙН ОНЦЛОГ

Нэхэмжлэлийн агуулга нь захиргааны хууль бус акттай холбоотой байна.

Шаардлага нь зөвхөн захиргааны байгууллага, албан тушаалтны эсрэг чиглэсэн.

Нэхэмжлэл нь захиргааны актыг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг эрх зүйн үр дагавар бүхий хамгаалалтын цогц шинжийг агуулж байдаг.

Нэхэмжлэл нь бүрдүүлбэр хангаагүй үндэслэлээр буцаагддаггүй

Хяналтын асуулт:

1. Хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг аль захиргааны актад холбогдуулан гаргах вэ?
2. Даалгах нэхэмжлэлийг аль захиргааны акттай холбогдуулан гаргадаг вэ?
3. Захиргааны актын процессын эрх зүйн учир холбогдлыг тайлбарлана уу?
4. Захиргааны актыг хүчингүй болгуулахын зэрэгцээ даалгах нэхэмжлэл гаргаж болох уу? Учрыг тайлбарлана уу?

Сорил

1. Хүчингүй болгох нэхэмжлэлийг дараах зүйлд холбогдуулан гаргана:
 - а. Хууль бус эс үйлдэхүйд
 - б. Биелэгдсэн захиргааны актад
 - в. Бусад
2. Тогтоох нэхэмжлэлийг дараах зүйлд холбогдуулан гаргана:
 - а. Иргэн А татварын хууль тогтоомжийн тодорхой хэм хэмжээг хэрхэн ойлгох талаар мэдэхийг хүссэн тохиолдолд
 - б. Иргэн Б нь зан чанарын хувьд багшлах боломжтой гэдгийг тодорхойлуулахаар
 - в. Бусад
3. Нэхэмжлэлийн зүйлийн гол ялгаа
 - а. Хууль зүйн хүчин төгөлдөр шинжээрээ
 - б. Хууль бус шинжээрээ
 - в. Гаргах эрх бүхий субъектээрээ

Дасгал

1. Иргэн Б-ийн хайгуулын тусгай зөвшөөрлийг төлбөрөө хугацаанд нь төлөөгүй үндэслэлээр эрх бүхий захиргаа хүчингүй болгожээ. Иргэн Б энэ шийдвэрийг эс зөвшөөрч зохих журмын дагуу харьяалах ЗХШ-д нэхэмжлэл гаргажээ. Энэ тохиолдолд иргэн Б ЗХШ-д аль төрлийн нэхэмжлэлийг гаргах вэ?
2. Иргэн А хайгуулын тусгай зөвшөөрөл авахаар холбогдох бичиг баримтыг бүрдүүлж эрх бүхий захиргаанд хандсан боловч татгалзсан хариу авчээ. Тэрээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан үндэслэлийг хүлээн зөвшөөрөөгүй тул харьяалан ЗХШ-д нэхэмжлэл гаргах болов. Энэ тохиолдолд иргэн А ямар төрлийн нэхэмжлэл гаргавал зохистой вэ?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45



СЭДЭВ 11. ЗХШ-д нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөл

Сэдвийн зорилго: ЗХШ-д нэхэмжлэх эрх нээгдэх үндэслэл, нөхцлийг хэрэг дээр нь тодорхойлох чадварыг эзэмшинэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөл-** Иргэн, хуулийн этгээдээс ЗХШ-д гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхэд түүнд өөрт нь хуулиар тавигдаж буй шаардлагыг хэлнэ.
- **Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл (агуулга)-** Нэхэмжлэлийн шаардлагын агуулгад тавих хамгийн дээд хязгаар.
- **Нэхэмжлэлийн бүрдүүлбэр-** Хуульд заасан бөгөөд нэхэмжлэлд нэгбүрчлэн зайлшгүй тусгавал зохих мэдээлэл.

ЗХШ-д нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөл

Хэргийн харьяалал (мөн нутаг дэвсгэрийн ба шүүхийн харьяалал)	Нэхэмжлэлд дурьдсан захиргааны шийдвэр нь захиргааны акт мөн бол ЗХШ-д харьяалагдана. Хэргийн харьяаллыг шалгасны дараа нутаг дэвсгэрийн харьяалал зөв эсэхийг шалгана. Нутаг дэвсгэрийн харьяалал бол тухайн захиргааны хэргийг аль засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид буй ЗХШ харьяалан шийдвэрлэх эрхтэй болохыг зааж буй ойлголт юм. Харин шүүхийн харьяалал гэдэг нь уг захиргааны хэргийг аль шатны ЗХШ харьяалан шийдвэрлэх эрхтэй вэ гэдгийг хуулиар тодорхойлсныг хэлнэ
Гомдлыг урьдчилан шийдвэрлүүлэх	Тухайн маргааныг хуулиар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлага тавигдсан бол уг шаардлагыг хангасан байхыг шаардана
Субъектив эрх хөндөгдсөн байх	Захиргааны актын улмаас нийт иргэдийн болон аль нэг гуравдагч этгээдийн бус харин нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн байх нь ЗХШ-д нэхэмжлэх эрх нээгдэх нэгэн нөхцөл болно
Эрх зүйн чадвар, чадамжтай байх	Нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээд эрх зүйн чадвар чадамжтай байна. Эрх зүйн зарим чадамжтай, эсхүл эрх зүйн бүрэн чадамжгүй бол төлөөлөн хамгаалалт тогтоосны үндсэн дээр төлөөлөгчөөрөө дамжуулан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулна
Уг маргааны талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, тогтоол, захирамж байхгүй байх	Нэхэмжлэлд дурьдсан үйл баримт, хариуцагчийн гэм буруугийн талаар, эсхүл уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр буюу шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж байгаа бол нэхэмжлэх эрх нээгдэхгүй

Эрх залгамжлагдсан байх	Нэхэмжлэгч болох иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан боловч эрх, үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй бол нэхэмжлэх эрх нь нээгдэхгүй
Хөөн хэлэлцэх хугацаа хэтрээгүй байх	Нэхэмжлэгч ЗХХШТХ-ийн §12.1; 12.2-т иш татсан 30 хоногийн хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлээгүй байх
Нэхэмжлэлийн хэлбэр, бүрдүүлбэрийн шаардлага хангасан байх	Нэхэмжлэл бичгийн хэлбэртэй байна. Нэхэмжлэлийн бүрдүүлбэрт: <ul style="list-style-type: none"> - нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шүүхэд гаргаж байгаа - нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг хуулийн этгээд бол нэр, оршин байгаа газрын хаяг; - нэхэмжлэлийн шаадлагын үндэслэл (агуулга); - хавсаргасан барим бичгийн жагсаалт эдгээр болно.

Захиргааны процессын эрх зүйд нэхэмжлэлээ гүнзгийрүүлэн үндэслэхийг нэхэмжлэгчээс шаардахыг хориглох зарчим үйлчилдэг. Энэ нь нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлд тухайн захиргааны актын хууль зүйн үндэслэлийн талаар заавал тусгахыг шаардахгүй гэсэн үг юм.

Хяналтын асуулт

1. Бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд иргэн өөрийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах эрхтэй юу?
2. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй бол нэхэмжлэлийг буцаах уу?
3. Холимог системээр явуулсан орон нутгийн сонгуулийн санал хураалтын эцсийн дүнтэй холбоотой асуудлаар уг сонгуульд оролцсон улс төрийн нам ЗХШ-д нэхэмжлэл гаргах эрхтэй юу?

Дасгал

1. Аймгийн Засаг даргын гаргасан захиргааны акттай холбоотой маргаанд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдэх үү?
2. ЗХШ нэхэмжлэлийн шаардлагыг хангалттай үндэслээгүй гэдэг шалтгаанаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах эрхтэй юу?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45



СЭДЭВ 12. Нэхэмжлэлийн үндэслэл

Сэдвийн зорилго: Нэхэмжлэлийн үндэслэлийн талаарх ойлголттой танилцах, түүнийг зөв тодорхойлох чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ

Нэр томъёоны тайлбар:

- **Нэхэмжлэлийг үндэслэлтэй гэж үзэх-** Нэхэмжлэлд дурдсан захиргааны акт хууль бус бөгөөд уг хууль бус актын улмаас нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн бол нэхэмжлэлийг үндэслэлтэй гэж үзнэ
- **Хүчингүй болгуулах нэхэмжлэлийн үндэслэл-** Нэхэмжлэлд дурдсан маргаан бүхий захиргааны акт нь эрх хэмжээ, үндэслэл, журам, хэлбэрийн талаасаа хууль зөрчсөн эсэхийг материаллаг хэмжүүрээр шалгах арга
- **Даалгах нэхэмжлэлийн үндэслэл-** Нэхэмжлэлд дурдсан маргаан бүхий захиргааны актыг гаргахаас татгалзсан болон эс үйлдэхүй нь хууль зөрчсөн эсэхийг материаллаг хэмжүүрээр шалгах арга
- **Илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэлийн үндэслэл-** Нэхэмжлэлд дурдсан захиргааны акт нь илт хууль бус эсэхийг материаллаг хэмжүүрээр шалгах арга
- **Хохирлоо арилгуулах нэхэмжлэлийн үндэслэл-** Нэхэмжлэлд дурдсан захиргааны актын улмаас нэхэмжлэгчид шууд хохирол учирсан эсэхийг материаллаг хэмжүүрээр шалгах арга.

Хүчингүй болгуулах нэхэмжлэлийн үндэслэлд холбогдож буй захиргааны акт нь маргаан бүхий захиргааны акт бөгөөд энэ нь иргэнд дарамт учруулахад чиглэдэг тул үүнийг дараахь схемийн дагуу шалгахыг зөвлөдөг. Үүнд:

- захиргааны актад ямагт үндэслэл бичигдсэн байх ёстой (эрхийг нь хязгаарлах талаас)
- тэдгээр үндэслэл нь заавал эрх зүйн холбогдох хэм хэмжээнд тулгуурлаж гарсан байх
- тодорхой шийдвэр гарсан байх ёстой.

Эдгээрийн дүнд захиргааны актын эрх зүйн үндэслэл хангагдах учиртай.

Хяналтын асуулт

1. Нэхэмжлэлийн үндэслэл гэдэгт хамаарч буй ойлголтуудыг тодорхойлно уу?
2. Нэхэмжлэлийн төрөл ба нэхэмжлэлийн үндэслэлийн харилцан хамаарал, зааг ялгааг тайлбарлана уу?
3. Материаллаг хэмжүүр гэдэгт юуг хамааруулж байна вэ?

Дасгал

1. Газрын тухай хуулийн §36.1-д “газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалын дагуу тухайн шатны Засаг дарга тогтооно” гэж заажээ. Дээрх аргачлал батлагдаагүй байхад Засаг дарга дуудлага худалдааны анхны үнийг тогтоон улмаар дуудлага худалдаа явуулжээ. Уг дуудлага худалдаанд оролцсон нэгэн компани энэхүү дуудлага худалдааны үр дүнг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд улмаар ЗХШ-д зохих журмын дагуу нэхэмжлэл гаргасанд шүүх нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэжээ.

Энэ тохиолдолд нэхэмжлэгч компани шүүхэд ямар төрлийн нэхэмжлэл гаргасан бэ? Нэхэмжлэл үндэслэлтэй юу?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45

СЭДЭВ 13. Нэхэмжлэлийн үндэслэлийг шалгах \загвар хичээл\

Сэдвийн зорилго: ЗХШ-д гаргасан нэхэмжлэлийн үндэслэлийг тодорхой нэг тохиолдол дээр бодлого бодох аргачлалын дагуу бодож шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй гаргах арга барил эзэмшүүлэх, бие даан ажиллах хандлагыг төлөвшүүлэхэд чиглэнэ

Нэр томъёоны тайлбар:

- **Байнга оршин суух газраа сонгох үндсэн эрх-** Үндсэн хуулийн эрх зүйн агуулгаар тодорхойлсон үндсэн эрх.
- **Иргэн нэг аймаг, хотоос нөгөө аймаг хотод бүрмөсөн шилжин суурьших эрх-** Дээрх үндсэн эрхийн өдөр тутмын хэрэгжилтийг тодорхойлсон Захиргааны эрх зүйн нэр томъёо
- **Хураамж-** Төрөөс үйлчилгээ үзүүснийхээ төлөө тухай бүр нь хураан авч улс, орон нутгийн төсөвт оруулж буй мөнгөн хөрөнгө
- **Татвар-** Албан татвар, төлбөр, хураамжийг хуульд татвар гэх нэр томъёогоор нэгтгэн тодорхойлсон. Татварыг бий болгох, өөрчлөх, хүчингүй болгох харилцааг гагцхүү УИХ хуулиар зохицуулахаар заажээ.

Бодлогын өгөгдөл: Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчид хуралдаж хөдөө орон нутгаас нийслэл УБ хотод бүрмөсөн шилжин ирж буй насанд хүрсэн хүн тутмаас 50000 төгрөг, насанд хүрээгүй хүүхэд бүрээс 25000 төгрөгийн шилжилт хөдөлгөөний үйлчилгээний хураамж авч байхыг заасан тогтоол гаргажээ. Ийнхүү шийдвэр



гаргахдаа нийслэл хотын хүн амын механик өсөлт урьд өмнө байгаагүйгээр өсч, хотын даац нэгэнт хэтэрсэн тул энэ өсөлтийг эдийн засгийн аргаар хязгаарлах нь зайлшгүй гэсэн үндэслэл баримталжээ.

Иргэн Цэрэнгийнх ам бүл 8, үүнээс насанд хүрсэн 4, насанд хүрээгүй 4 бөгөөд гэр бүлээрээ Ховд аймгаас нийслэлд суурьшихаар нүүн ирсэн боловч шилжилт хөдөлгөөний үйлчилгээний хураамж 300,000 төгрөг төлөх боломж түүнд байсангүй. Иймд Цэрэн дээрх шийдвэрийг эс зөвшөөрч зохих журмын дагуу Нийслэлийн ЗХШ-д хандан Нийслэлийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн тогтоолыг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Асуулт:

Иргэн Цэрэнгийн нэхэмжлэл үндэслэлтэй юу? Дүгнэлт гаргах аргачлалаар бодно уу?

Тавигдах асуулт:

1. Талуудын маргаж буй гол зүйл юу вэ?
2. Хураамж нь татвар мөн үү?
3. Албан татвар нь хураамж мөн үү?
4. Шилжилт хөдөлгөөний үйлчилгээний хураамж гэх нэр төрлийн татвар хуульд бий юу?
5. Нийслэлийн ИТХ-ийн Тэргүүлэгчдэд татвар бий болгох эрх хуулиар олгогдсон уу?
6. Иргэн Цэрэн нэг аймаг, хотоос нөгөө аймаг хотод бүрмөсөн шилжин суурьших эрхээ хэрэгжүүлэхэд хуулиар ямар шаардлага тавигдаж байна вэ?
7. Иргэн Цэрэн дээрх эрхээ хэрэгжүүлэхэд шилжилт хөдөлгөөний үйлчилгээний хураамж төлөх үүрэгтэй юу?
8. Нийслэлийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн дээрх тогтоолыг зөвтгөх хууль зүйн үндэслэл байна уу?
9. Иргэн Цэрэнгийн байнга оршин суух газраа сонгох үндсэн эрхийг хязгаарлах хууль зүйн үндэслэл бий юу?
10. Дүгнэлт

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Татварын ерөнхий хууль. ТМ эмхтгэл, 2008, №22

4. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. ТМ, 2007, №2
5. Иргэний бүртгэлийн тухай хууль. ТМ, 1999, №49
6. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль

Сэдэв 14. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх

Сэдвийн зорилго: Маргаан бүхий захиргааны актын үйлчлэлийг түдгэлзүүлэх шаардлага, түдгэлзүүлж болох ба болохгүй нөхцөл байдлуудыг ялган судлах замаар оюутан практикт уг хуулийн заалтыг хэрэглэх чадвар эзэмшихэд чиглэнэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх**- ЗХШ-ээс маргаан бүхий захиргааны актын хэрэгжилтийг түр хугацаагаар зогсоохыг хэлнэ
- **Маргаан бүхий захиргааны акт**- Хууль бус эсэхээс үл хамааран хууль зүйн хувьд хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны акт
- **Түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал**- Зарим маргаан бүхий захиргааны актын үйлчлэлийг хэвээр хадгалахаар хуульд заасан үндэслэл

ЗАХИРГААНЫ АКТЫН БИЕЛЭЛТИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЖ БОЛОХГҮЙ БАЙДАЛ

Түдгэлзүүлэх нь бусдад илт хохиролтой бол

Иргэн хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай акт бол

Захиргааны хариуцлага хүлээлгэсэн болон уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр бол

Хууль тогтоомжид заасан тохиолдолд үл маргалдах журмаар биелүүлэх бол

Өөр хуульд тусгайлан заасан бол

- Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээдэд илт хохирол учруулахаар бол түдгэлзүүлж болохгүй
- Нийтийн ашиг сонирхлын үүднээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй
- Нийгмийн хэв журмыг хамгаалах, нийтийн аюулгүй байдлыг хангахыг захиргааны зөрчлийн улмаас хариуцлага хүлээж буй иргэн, хуулийн этгээдийн эрх ашгаас дээгүүр авч үзнэ



- Хууль тогтоомжид заасан тохиолдолд үл маргах журмаар биелүүлэхээр заасан бол захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй;
- Өөр хуульд тусгайлан заасан бол захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй.

Хяналтын асуулт

1. Захиргааны актын үйлчлэлийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хууль зүйн агуулга, учир холбогдлыг тайлбарлана уу?
2. Захиргааны актын үйлчлэлийг хэдийд түдгэлзүүлэх вэ?
3. Захиргааны актын биелэлтийг хэсэгчлэн түдгэлзүүлж болох уу?

Сорил

1. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлснээр хариуцагчид хориглох зүйл
 - а. Уг маргаантай асуудлаар өөр захиргааны акт гаргах
 - б. Шүүгч захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх захирамждаа тусгайлан заагаагүй бол хариуцагч өөр захиргааны акт гаргаж болно
 - в. Шүүгчийн захирамжаар түдгэлзүүлсэн захиргааны актыг хэрэгжүүлэх чиглэлээр хариуцагч зарим үйл ажиллагаа явуулж болно.
2. Нэхэмжлэл нь одоохондоо шаардлага хангаагүй боловч шаардлага хангахыг хүлээх боломжгүй онцгой тохиолдолд маргаан бүхий захиргааны актын биелэлтийг шүүгч түдгэлзүүлэх боломж бий юу?
 - а. Боломжгүй
 - б. Боломжтой
3. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал
 - а. Төрийн захиргааны албан хаагчийг ажлаас халах тухай эрх бүхий захиргааны шийдвэр
 - б. Торгуулийн хуудсаар торгох шийдвэр
 - в. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон шийдвэр
4. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх шийдвэрийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа
 - а. Анхан шатны шүүхийн шийдвэр гарах хүртэл хугацаанд
 - б. Давж заалдах шатны шүүхийн магадлал гарах хүртэл хугацаанд
 - в. Шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэл хугацаанд

Дасгал

1. Нэгэн компанийн татварын өрийг гаргуулахаар татварын улсын байцаагч холбогдох арилжааны банкинд мэдэгдэх хуудас хүргүүлэв. Энэ шийдвэрийг уг компани эс зөвшөөрч зохих журмын дагуу харъяалах ЗХШ-д нэхэмжлэл гаргасныг шүүх хүлээн авчээ. Нэхэмжлэгч дээрх татварын байцаагчийн мэдэгдэх хуудсын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг гаргав.

Энэ тохиолдолд улсын байцаагчийн мэдэгдэх хуудсыг шүүгч түдгэлзүүлэх үү?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Татварын ерөнхий хууль. ТМ эмхтгэл, 2008, №22


ДӨРӨВ. НОТЛОХ БАРИМТ

Сэдэв 15. Нотлох баримтын ойлголт

Сэдвийн зорилго: Нотлох баримтын тухай ойлголт, нотолгооны хэрэгслийн талаар судалж, захиргааны хэргийн нотлох баримтын болохуйц хийгээд нотлох чадварын талаар цэгцтэй мэдлэг эзэмшинэ.


Нэр томъёоны тайлбар:


- **Нотлох баримт**- Хэргийн оролцогчоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай баримтат мэдээлэл
- **Нотлох баримтын хамаарал**- Тухайн хэрэгт холбоотой үйл явдлын талаар мэдээлэл өгч чадах нотлох баримтын чадварыг хэлнэ
- **Нотлох баримтын болохуйц байдал**- Тухайн нотлох баримт буюу баримт сэлт мэдээллийг агуулж буй эх сурвалж нь хууль ёсны эсэх, түүнийг хуульд заасан арга, хэрэгслээр эрх бүхий этгээд цуглуулж бэхжүүлсэн эсэхийг харуулах нотлох баримтын чанар
- **Нотолгооны хэрэгсэл**- Нотлох баримтын хуульчлагдсан эх сурвалж



Эдгээр шалгуур шинжийг агуулаагүй баримтат мэдээллийг захиргааны хэргийн нотлох баримт гэж үзэхгүй бөгөөд хэргийн нотлох баримтаас хасах төдийгүй ийм баримтыг шаардан гаргуулж болохгүй (ЗХХШтХ-§31.4 болон 31.8).

Нотлох баримтын ангилал





Нотолгооны хэрэгсэл

Хэргийн оролцогчийн тайлбар	Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн тайлбар хамаарна. Эдгээрээс хариуцагчид тайлбараа тодорхой хугацаанд заавал гаргаж өгөх үүрэг хуулиар хүлээлгэсэн. Нэхэмжлэгчийн тухайд тайлбараа амаар болон бичгээр гаргаж өгөх эрхтэй. Гуравдагч этгээд нь нэхэмжлэгчийн талын эсхүл хариуцагчийн талын гуравдагч этгээд үү гэдгээс хамаарч тэдгээрийн эрх, үүрэг тодорхойлогдсон
Хэргийн оролцогчийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар	Хэргийн оролцогчийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар нь үндэслэл бүхий байна
Гэрчийн мэдүүлэг	Гэрчийн мэдүүлэг нь өөр бусад шууд нотлох баримтаар давхар батлагдах шаардлага тавигдана
Шинжээчийн дүгнэлт	Шинжээч дүгнэлтдээ өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд хийсэн шинжилгээний явц үр дүнг тусгасан байна
Тэмдэглэл	Хуульд заасан байдлаар нь шүүх хуралдааны болон үзлэгийн, сорьж турьших, таньж олуулах ажиллагааны тэмдэглэл гэж ангилна
Баримт бичиг	Тодорхой үйл баримтыг гэрчилсэн, тогтоосон хэв загварын дагуу үйлдсэн, хууль зүйн ач холбогдол бүхий акт юм.
Нотолгооны бусад хэрэгсэл	Кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв болон бусад бичмэл баримтууд хамаарна



Хяналтын асуулт

1. Нотлох баримт болон нотолгооны хэрэгсэл хоорондоо юугаараа ялгаатай вэ?
2. Нотлох баримтын хамаарал болон болохуйц байдлын тус бүрийн онцлогийг тодорхой жишээн дээр тайлбарлана уу?
3. Нотлох баримтын нотлох чадвараа алдах тохиолдлуудыг нэрлэнэ үү?

Сорил

1. Нотлох баримтын шалгуур
 - а. Нотолгооны шинжтэй байх
 - б. Тухайн хэрэгт шууд хамааралтай байх
 - в. Эх сурвалжийн чадвартай байх
2. Нотлох баримтын болохуйц байдал
 - а. Баримт сэлт, үйл явдлын хоорондох шалтгаант холбоо
 - б. Орон зай, цаг хугацааны хүчин зүйл
 - в. Хуульд заасан журмын дагуу бэхжүүлсэн байдал
3. Анхдагч нотлох баримт
 - а. Гэрчийн мэдүүлэг
 - б. Хэргийн газрын үзлэгийн тэмдэглэл
 - в. Захиргааны акт
4. Нотолгооны хэрэгсэл
 - а. Хуульд бэхжүүлсэн байхыг шаардана
 - б. Хуульд бэхжүүлсэн байхыг шаардахгүй
 - в. Шүүхээс тогтооно

Дасгал

1. Дүүргийн ИТХ-ын сонгуулийн нэгэн хэсгийн санал хураалтын дүнг эс зөвшөөрч тухайн дүүрэгт нэр дэвшиж өрсөлдсөн иргэн Б зохих журмын дагуу харьяалах ЗХШ-д нэхэмжлэл гаргасныг шүүх хүлээн авч захиргааны хэрэг үүсгэжээ. Хэргийн нөхцөл байдлыг тогтоох хүрээнд шүүгч тухайн дүүргийн Засаг даргаас уг хэрэгт гэрчийн мэдүүлэг авчээ. Хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд гаргасан анхан шатны шүүхийн шийдвэр нь уг Засаг даргаас авсан гэрчийн мэдүүлэгт үндэслэжээ.
Энэ тохиолдолд анхан шатны ЗХШ-ийн шийдвэр үндэслэлтэй юу?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2002, №8 нэмэлт өөрчлөлт- ТМ, 2007, №32

СЭДЭВ 16. Нотлоо

Сэдвийн зорилго: Хэргийн нөхцөл байдлыг илрүүлэхийн тулд ЗХШ хэрхэн нотлох баримтыг цуглуулах, үнэлэх аргатай танилцаж, нотлох баримтыг яаж хуваарилах талаарх зохих мэдэгдэхүүн, чадварыг эзэмшинэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Нотлоогоо-** ЗХШ-ээс ЗХХШТХ-д заасан зарчим, журам болон хуулиар зөвшөөрсөн арга хэрэгслийн дагуу нотлох баримтыг олж цуглуулах замаар хэргийн нөхцөл байдлыг тогтооход чиглэгдсэн танин мэдэхүйн үйл ажиллагаа
- **Мөрдөн шалгах зарчмын хэрэгжилт-** Мөрдөн шалгах зарчим нь ЗХШ нотлох баримтыг цуглуулах чиг үүргийн хүрээнд шүүх ба хэргийн оролцогчийн хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжих нөхцлөөр тохируулагджээ
- **Нотлох баримтыг шууд, амаар цуглуулах зарчим-** ЗХШ нотлох баримтыг анхдагч эх сурвалжаас нь шууд буюу аман хуралдаанаар цуглуулах зарчим
- **Асуулт тавих эрх-** Хэргийн нөхцөл байдлыг илрүүлэхтэй холбогдуулан хийж буй процессын ажиллагааны явцад асуулт тавих эрхийг хэргийн оролцогчдод нээлттэй байлгах нь шүүгчийн үүрэг байна
- **Нотлох баримтыг үнэлэх-** Шүүгч ЗХХША-ны үр дүнд бий болсон итгэл үнэмшилд тулгуурлан нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.
- **Шүүгчийн дотоод итгэл-** Тэрээр хэргийн нөхцөл байдлын талаар бүрэн дүүрэн ойлголттой болохыг хэлнэ
- **Материаллаг нотлох үүрэг-** ЗХШ-ээс нотлох баримт цуглуулах үүргээ хуульд заасан бүх арга, хэрэгслээр хэрэгжүүлсэн боловч хэргийн нөхцөл байдал тогтоогдохгүй байгааг шүүх хүлээн зөвшөөрсний үндсэн дээр эцсийн мөчид нотлох үүргийг талуудад ногдуулахыг ойлгоно.



НОТОЛГООНЫ ҮЕ ШАТ

Цуглуулах

Шалгах

Үнэлэх

- Нотлох баримтыг цуглуулах үе шат нь дотроо а) Тодруулбал зохих нөхцөл байдал, түүнийг илрүүлэх арга, хэрэгслийг тодорхойлох шаардагдах нотлох баримтын эх сурвалжийг заах; б) ЗХШ-ээс шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх; в) Шүүх шаардлагатай ажиллагаа явуулах замаар нотлох баримтыг өөрөө цуглуулах гэсэн шатуудтай.
- Нотлох баримтыг шалгах үе шат нь хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн гүйцэд илрүүлэх чиг үүргийн хүрээнд хэрэгт авагдсан нотлох баримтын эх сурвалж нэг бүрийг өөр хооронд нь харьцуулан судлах замаар тэдгээрийн зөрөөтэй байдал болон үнэн зөв эсэхийг нягтлана
- Нотлох баримтыг үнэлэх үе шат нь шүүгч зөвхөн процессын ажиллагааны үр дүнд цугларсан бөгөөд шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн (хэргийн оролцогчид санал бодлоо илэрхийлсэн) нотлох баримтыг үнэлэх сэтгэхүйн ажиллагаа юм. Шүүгч нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ.

Хяналтын асуулт

1. ЗХХШтХ-д мөрдөн шалгах зарчим сонгодог утгаараа хуульчлагдсан эсэхийг тодорхойлно уу?
3. ЗХШ-ийн мөрдөн шалгах зарчмын хэрэгжилт хязгаарлагдах тохиолдлуудыг нэрлэнэ үү?
4. Нотлох баримтыг цуглуулах шатанд хэргийн оролцогчдын эрх, үүргийн ялгааг гаргана уу?

Сорил

1. ЗХШ-д нотлох баримт гаргаж өгөх үүрэг
 - а. Нэхэмжлэгч
 - б. Хариуцагч
 - в. Бусад оролцогч
2. Мөрдөн шалгах зарчмын хэрэгжилт ямар хэмжээ, хязгаарт байх вэ?
 - а. Сонгодог утгаар хэрэгжинэ
 - б. Шүүх ба хэргийн оролцогчийн хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжинэ
 - в. Нотлох баримтыг цуглуулах үе шатанд л хэрэгжинэ

3. Нотлох баримт цуглуулах үе шат
 - а. Нотлох баримтыг үнэлэх
 - б. Нотлох баримтыг хуваарилах
 - в. Бусад
4. Асуулт тавих эрх
 - а. Нотлох баримтыг амаар, шууд цуглуулах зарчмын бүрэлдэхүүн хэсэг
 - б. Нотлох баримтыг үнэлэх чухал хэрэглүүр
 - в. Нотлох үүргийг хуваарилах арга

Дасгал

1. Нэхэмжлэгч Б-ээс ЗХШ-ийн шүүгчид хандан уг хэрэгт гэрчийн мэдүүлэг авахуулах зайлшгүй шаардлагатай гэж үндэслэн хүсэлт гаргажээ.
Энэ тохиолдолд нэхэмжлэгчийн уг хүсэлтэд ЗХШ-ийн өгөх хариуны үндэслэлийг бэлтгэнэ үү?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2002, №8 нэмэлт өөрчлөлт- ТМ, 2007, №32

ТАВ. ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

СЭДЭВ 17. Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа

Сэдвийн зорилго: Захиргааны хэрэг үүсгэх болон хэрэг үүсгэсний дараа шүүгчээс явуулах жишиг ажиллагааны агуулгатай танилцаж, улмаар тухайн хэргийн нөхцөл байдлыг илрүүлэхийн тулд бие даан ажиллах чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Захиргааны хэрэг үүсгэх-** Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах хуульд заасан үндэслэл байхгүй бол ЗХШ-ийн шүүгч захиргааны хэрэг үүсгэх тухай захирамж гаргана



- **Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн жишиг ажиллагаа-** Тухайн хэргийн нөхцөл байдлыг илрүүлэхийн тулд шүүгчээс явуулахаар хуульд тусгайлан заасан процессын тодорхой ажиллагаануудын нийлбэр
- **Бусад шаардлагатай ажиллагаа-** Тухайн хэргийн нөхцөл байдлыг илрүүлэхийн тулд ямар ажиллагаа явуулбал зохихыг шүүгч өөрөө тодорхойлон хэрэгжүүлэх боломжийг агуулсан ойлголт. Шүүгч мөрдөн шалгах зарчмыг хэрэг дээр нь хэрэгжүүлэх нөхцлийг энэхүү нэр томъёогоор тодорхойлжээ.

Жишиг ажиллагаа

Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгч хэргийн нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай ажиллагааг төлөвлөн явуулна.

- Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ
- Хариуцагчийг дуудан ирүүлж нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримт бичгийн хувийг гардуулж, энэ тухайгаа баталгаажуулна. Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх эсэх тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй төдийгүй хэрэв нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй бол тайлбартаа үндэслэлийг зааж нотлох баримтаа хамтад нь гаргаж ирүүлнэ
- Хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримыг цуглуулах
- Гэрчийг дуудаж мэдүүлэг авах
- Шинжээч, орчуулагч, хэлмэрч томилох
- Шаардлагатай бол холбогдох шүүхэд шүүхийн дагавар явуулах
- Эвлэрүүлэх арга хэмжээ авна
- Хариуцагчийг солих болон гуравдагч этгээдийг татан оролцуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ
- Нэхэмжлэлийн хэд хэдэн шаардлагыг нэгтгэх болон тусгаарлах эсэх асуудлыг шийдвэрлэнэ
- Нэхэмжлэлийн гол зүйл биелэгдвэл түүнийг хангах арга хэмжээ авна

Бусад шаардлагатай ажиллагаа явуулах

Дээрх жишиг ажиллагааны хүрээнд хэргийн нөхцөл байдлыг илрүүлэх боломжгүй бол шүүгч тухайн хэргийн нөхцөл байдлыг илрүүлэхийн тулд чухам ямар ажиллагаа явуулбал зохихыг тодорхойлж, мөрдөн шалгах зарчмыг бодитой хэрэгжүүлнэ.

Хяналтын асуулт

1. Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаанд удирдлага болгох гол зарчмуудыг нэрлэнэ үү?
2. Жишиг ажиллагаа нь заавал хийгдэх ажлын дэс дараалал мөн үү?
3. Бусад шаардлагатай ажиллагаа ба жишиг ажиллагаа нь тус тусдаа хийгдэх ажиллагаа юу?

Сорил

1. Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаанд удирдлага болгох зарчим
 - а. Мэтгэлцэх зарчим
 - б. Шууд, амаар цуглуулах зарчим
 - в. Бодитой байх зарчим
2. Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа нь
 - а. ЗХХШтХ-д заагдсан дэс дараалан хийгдэх нэгбүрчилсэн ажиллагаа
 - б. Ерөнхий жишиг тогтоосон ажиллагаа
 - в. Гэрчийн мэдүүлэг авах ажиллагаа
3. Хариуцагчийг солих угтвар нөхцөл нь
 - а. Шүүх холбогдох нотлох баримтыг бүрдүүлсэн байх явдал
 - б. Ямар нэгэн нотлох баримт шаардлагагүй
 - в. Хариуцагчийг солихыг нэхэмжлэгч зөвшөөрсөн байх
4. Бусад шаардлагатай ажиллагаа гэж
 - а. Тухайн хэргийн нөхцөл байдлыг илрүүлэхэд шаардагдах хуулиар зөвшөөрсөн тодорхой ажиллагаа
 - б. Шинжээчийн дүгнэлт гаргуулах ажиллагаа
 - в. Орчуулагч томилох ажиллагаа

Дасгал

1. Жолооч Бат авто замын нэг чиглэлд улсын чанартай авто зам болон орон нутгийн чанартай авто зам ашигласны төлбөрийг тус бүр давхардуулан авч байгаа гэх үндэслэлээр Авто замын болон Нийслэлийн Засаг даргад холбогдуулан тус тус өөр өөр цаг хугацаанд ЗХШ-д нэхэмжлэл гаргажээ. Энэ тохиолдолд эдгээр хэргийг нэгтгэн хэлэлцэж болох уу?
2. Захиргааны актын улмаас учирсан хохирлын хэмжээний талаар хэргийн оролцогчдын хооронд маргаан гарсны улмаас хэргийн энэ хэсгийг тусгаарлан харьяалах шүүх рүү шилжүүлжээ. Харин нэхэмжлэлийн шаардлагын үлдсэн хэсгийг ЗХШ хянан шийдвэрлэх эрх хэмжээ бий юу?



Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2002, №8 нэмэлт өөрчлөлт- ТМ, 2007, №32

СЭДЭВ 18. Шүүх бүрэлдэхүүн, шүүгчийг татгалзан гаргах

Сэдвийн зорилго: Шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах хууль зүйн үндэслэлийг судалж энэхүү үндэслэл бүрдсэн үед тэдгээрийг татгалзан гаргах болон шүүгч өөрөө татгалзан гарахын учир холбогдлыг үнэлдэг болно.

Нэр томъёоны тайлбар:

- **Татгалзан гаргах тухай хүсэлт-** Шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах талаар хэргийн оролцогч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч түүнчлэн иргэдийн төлөөлөгч, прокурорт ЗХХШТХ-иар тусгайлан олгосон эрх
- **Үл оролцох үндэслэл-** Шүүгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй талаар хуульд заасан үндэслэл
- **Өөрөө татгалзан гарах үүрэг-** Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуульд заасан үндэслэлээр үл оролцох болон уг ажиллагаанаас өөрийн хүсэлтээр татгалзан гарах үүрэг

ҮЛ ОРОЛЦОХ ҮНДЭСЛЭЛ

Захиргааны хэргийг анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэхэд урьд нь оролцсон шүүгч уг хэрэг, маргааныг өөр шатны журмаар хянан шийдвэрлэх

Захиргааны хэргийг анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгчийн гэр бүлийн гишүүн, түүнтэй төрөл садангийн холбоотой шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэх

ШҮҮГЧ ӨӨРӨӨ ТАТГАЛЗАН ГАРАХ ҮҮРЭГ

Урьд нь уг захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчээр оролцож байсан

Уг захиргааны хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн гэр бүл, төрөл садан, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн болон төрөл садангийн холбоотой хүмүүс орсон

Хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, эсхүл уг захиргааны хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал

Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэх болсон

ЗХХШтХ-ийн §64.1-д буюу шүүгч өөрөө татгалзан гарах үүрэг бүхий үндэслэлээр шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргахыг хэргийн оролцогч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, прокурор хүсч болох ба энэ тохиолдолд ЗХШ хэргийн оролцогчийн санал болн татгалзан гаргагдаж байгаа этгээд хүсвэл түүний тайлбарыг сонсоно. Шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг түүнийг байлцуулахгүйгээр бусад шүүгчид шийдвэрлэх ба санал тэнцвэл уг шүүгчийг татгалзан гаргасанд тооцно. Хэд хэдэн буюу хэргийг дангаар шийдвэрлэх шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэж, захирамж гаргана.

Иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлтийг захиргааны хэргийг хэлэлцэж байгаа шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шийдвэрлэнэ.

Ерөнхий шүүгч дангаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөлгөөн олонхийн саналаар шийдвэрлэн тогтоол гаргана.

Хяналтын асуулт

1. Шүүгчийг татгалзан гаргахын учир холбогдлыг тайлбарлана уу?
2. Шүүх бүрэлдэхүүнийг эсхүл тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзсан тохиолдолд яах вэ?
3. Шүүгч өөрөө татгалзан гарах үүргээ зөрчвөл түүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг ярилцана уу?

Сорил

1. Шүүгчийг татгалзан гаргах нь аль зарчимд нийцэх вэ?
 - а. Мэдэгдэх ба сонсгох зарчимд
 - б. Тэгш байдлын зарчимд
 - в. Мөрдөн шалгах зарчимд



2. Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үл оролцох үндэслэл
 - а. Тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон анхан шатны шүүхийн шүүгчийн нөхрийнх нь нагац эгч УДШ-ийн шүүгч бол
 - б. Уг хэргийг давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгон дахин хэлэлцүүлэхээр уг шүүхэд буцаасан тохиолдолд тухайн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч
 - в. Бусад
3. Шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэл
 - а. Урьд нь уг захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд гэрчээр оролцож байсан
 - б. Уг захиргааны хэргийг тухайн шатаар дахин хянан хэлэлцэх бол
 - в. Хэргийн нэг оролцогчтой хамт нэг сургууль төгссөн бол
4. Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг гаргах эрх бүхий этгээд
 - а. Сонирхогч этгээд
 - б. Иргэдийн төлөөлөгч
 - в. Гэрч

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2002, №8 нэмэлт өөрчлөлт- ТМ, 2007, №32

СЭДЭВ 19. Шүүхийн шинжилгээ

Сэдвийн зорилго: Шүүхийн шинжилгээний тухай ойлголт, түүнийг хийх үндэслэл, журамтай танилцаж, шүүхийн шинжилгээ хийлгэх арга барилыг эзэмшихэд чиглэнэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Шүүхийн шинжилгээ-** Захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн захирамжид заасан тусгай мэдлэг шаардсан асуудал “шинжлэх ухаан, техник, урлаг, соёл, нягтлан бодох бүртгэл зэрэг”-ыг шийдвэрлэхийн тулд шинжилгээний объектод шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагаа

- **Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд**- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, шүүх болон хуульд заасан төрийн эрх бүхий байгууллага
- **Шинжилгээний объект**- Шинжилгээ хийж байгаа ул мөр, эд мөрийн баримт, бичиг баримт, эд юмс, амьтан, хүний бие цогцос болон түүний хэсэг, харьцуулан судлах хэв загвар, хэргийн бусад материалыг
- **Нэмэлт шинжилгээ**- Шинжээчийн дүгнэлт тодорхойгүй буюу бүрэн бус, эсхүл шинжилгээ хийлгэж байгаа асуудалтай холбоотой шинэ нөхцөл байдал бий болсон тохиолдолд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоол, захирамж, хүсэлтээр хийж буй шинжилгээ
- **Дахин шинжилгээ**- Шинжээчийн дүгнэлт, эсхүл түүний зарим хэсэг үндэслэлгүй буюу үнэн зөв болох нь эргэлзээтэй бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоол, захирамж, хүсэлтээр хийж буй шинжилгээ



Хяналтын асуулт

1. Шүүхийн шинжилгээ хийлгэх эрх зүйн үндэслэл юу вэ?
2. Шүүхийн шинжилгээ хийлгэх эрх бүхий субъектэд Татварын маргаан таслах зөвлөл хамаарах уу?
3. Нэмэлт шинжилгээ болон дахин шинжилгээний ялгааг тайлбарлана уу?

Сорил

1. Шүүхийн шинжилгээ нь
 - а. Шүүгчээс явуулах ажиллагаа
 - б. Тусгай мэдлэгийн хүрээнд хийгдэх ажиллагаа
 - в. Салбарын хүрээнд хийгдэх ажиллагаа



2. Шүүхийн шинжилгээ хийлгэх эрх бүхий субъект
 - а. Шүүх
 - б. Улсын байцаагч
 - в. Засаг дарга
3. Нэмэлт шинжилгээ хийх үндэслэл
 - а. Шинжээчийн дүгнэлт үндэслэлгүй
 - б. Шинжилгээ хийж буй асуудлаар шинэ нөхцөл байдал бий болсон
 - в. Шинжээчийн дүгнэлт үнэн зөв эсэх нь эргэлзээтэй
4. Шинжилгээний объект
 - а. Гэрчийн мэдүүлэг
 - б. Бичиг баримт
 - в. Шинжээчийн дүгнэлт

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Шүүхийн шинжилгээний тухай хууль. ТМ эмхтгэл, 2010, №02

СЭДЭВ 20. Шүүхийн зардал ба улсын тэмдэгтийн хураамж

Сэдвийн зорилго: Шүүхээс захиргааны хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах зардал ба улсын тэмдэгтийн хураамжийн талаарх ойлголттой танилцаж, улмаар шүүхийн нөхөн төлүүлэх зардал, түүний хэмжээ болон улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг зөв тодорхойлох чадвар эзэмшинэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Шүүхийн зардал-** Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардал
- **Нөхөн төлүүлэх шүүхийн зардал-** Шүүхээс гаргасан бөгөөд нэхэмжлэгч, хариуцагчаар нөхөн төлүүлэхээр хуульд заасан зардал
- **Улсын тэмдэгтийн хураамж-** Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүсний төлөө нэхэмжлэгч, хариуцагчаас төлж байгаа мөнгөн хөрөнгө

ЗХШ-ийн нөхөн төлүүлэх зардалд шүүхээс гаргасан дараахь зардал хамаарна:

- шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гүйцэтгэсэн ажил үүрэгт ажилд нь хамаарахгүй бол ажлын хөлс;
- гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс;
- үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал;
- эд мөрийн баримт хадгалах зардал;
- гэрчийн мэдүүлгийг очиж авсан зардал.

Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээг шүүх ИХШХШТХ-ийн §54.1-д заасан журмаар тодорхойлж төлүүлнэ.



• Нөхөн төлүүлэх шүүхийн зардлаас чөлөөлөх

Нэхэмжлэгч, хариуцагч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон, эсхүл хуульд заасан бусад үндэслэл байвал зохигчийг шүүхийн зардал нөхөн төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлж болно. Шүүх тухайн этгээдийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн зардлыг нөхөн төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж болно.



”Эд хөрөнгийн байдал” гэдэгт тухайн этгээдийн өмчилж, эзэмшиж буй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө, түүний гэр орны ахуй байдлыг харгалзан үзэхийг, харин “бусад байдал” гэдэгт тухайн этгээдийн сарын орлого, ам бүл, эрхэлж буй ажил, хөдөлмөрийн онцлогийг харгалзахыг хэлнэ. Тухайлбал, оюутан, суралцагч болон эсхүл хөдөлмөрийн чадваргүй, сарын орлого бага боловч ам бүл олуулаа гэх мэт нөхцөл байж болно.

- Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хуваарилах

Нэхэмжлэлийн шаардлагыг хангасан эсэхээс хамааруулан шүүхийн зардлыг нэхэмжлэгч, хариуцагч талд хуваарилан төлүүлнэ. Шүүхийн зардлыг нэхэмжлэл бүрэн хангагдсан тохиолдолд хариуцагчаар, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэхэмжлэгчээр нөхөн төлүүлнэ. Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол шүүхийн зардлыг тэр хэмжээгээр хариуцагч буюу нэхэмжлэгчид хариуцуулна. Хяналтын шатны болон давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилвөл шүүхийн зардлын хуваарилалтыг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзвал хариуцагч шүүхийн зардлыг нөхөн төлөхгүй. Харин хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг сайн дураар хүлээн зөвшөөрч биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан бол хариуцагчийн төлөх шүүхийн зардлыг тавин хувиар хөнгөлнө.

Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ

ЗХШ-ээс захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд хураах улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ нь:

- эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлж болохгүй нэхэмжлэлд 70200 төгрөг;
- эд хөрөнгийн чанартай үнэлж болох нэхэмжлэлд нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч тэмдэгтийн хураамжийг дараахь хүснэгтэд заасан хувь, хэмжээгээр төлүүлнэ:

Нэхэмжлэлийн үнийн дүн /төгрөгөөр/	Хураамжийн хувь хэмжээ /төгрөгөөр/
0-130 000	4550 төгрөг
130 001- 650 000	4550 төгрөг дээр 130 000 төгрөгөөс давсан үнийн дүнгийн 3 хувийг нэмнэ.
650 001-1300 000	20150 төгрөг дээр 650 000 төгрөгөөс давсан дүнгийн 2.4 хувийг нэмнэ.
1300 001-13000 000	35750 төгрөг дээр 1300 000 төгрөгөөс давсан дүнгийн 1.6 хувийг нэмнэ.
13000 001-ээс дээш	222950 төгрөг дээр 13000 000 төгрөгөөс давсан дүнгийн 0.5 хувийг нэмнэ.

- хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход хуудас тутамд 55 төгрөгийн хураамж төлөхөөр тус тус заажээ².

Эд хөрөнгийн бус үнэлж болохгүй нэхэмжлэлд захиргааны актыг хүчингүй болгуулах, зохих захиргааны акт гаргахыг даалгах, илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх зэрэг нэхэмжлэл орох бол эд хөрөнгийн чанартай үнэлж болох нэхэмжлэлд захиргааны актын улмаас учирсан хохирлоо гаргуулах тухай нэхэмжлэл хамаарахаар байна. Улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан нэхэмжлэгчээр төлүүлж нэхэмжлэл хангагдсан тохиолдолд хариуцагчаар төлүүлэн нэхэмжлэгчид буцаан олгоно.

Улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөх, хөнгөлөх

Захиргааны акттай холбоотой дараахь нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас “чөлөөлөхөөр” заажээ³:

- тэтгэвэр, тэтгэмжийн талаар гаргасан нэхэмжлэл;
- патент, зохиогчийн эрхтэй холбогдсон нэхэмжлэл;
- шүүхийн зардал төлөх хөрөнгөгүйн улмаас шүүхийн шийдвэр, магадлалаар шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн иргэний нэхэмжлэл;
- цэргийн албан хаагчаас цэргийн үүрэг гүйцэтгэхтэй холбогдон гаргасан нэхэмжлэл;
- захиргааны шийтгэлийн журмаар баривчлах арга хэмжээ авсны улмаас учирсан хохирлыг төлүүлэхээр гаргасан нэхэмжлэл;
- хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авсан тохиолдолд нөхөх олговор, үнийг төлүүлэхтэй холбогдон гаргасан нэхэмжлэл;
- “...хуульд заасан бусад үндэслэл байвал” түүнийг улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлнө.

Зохигчийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн шийдвэрээр улсын тэмдэгтийн хураамж төлөх хэмжээг “багасгах” буюу “хугацааг хойшлуулах”, эсхүл “хэсэгчлэн төлүүлж” болно.

Улсын тэмдэгтийн хураамжийг нөхөн төлүүлэх, буцаан олгох, хуваарилах

Нэхэмжлэл гаргах үед түүний үнийг шууд тогтооход бэрхшээлтэй байвал шүүгч улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг урьдчилан тогтоож, тухайн хэрэг хянан шийдвэрлэгдсэний дараа шүүхээс тогтоосон нэхэмжлэлийн үнэд тохируулан “нөхөн төлүүлэх” буюу илүү төлөгдсөн бол зөрүүг буцааж олгоно.

² ЗХХШТХ-ийн §80 → ИХШХШТХ-ийн §57.2 → УТэмХТХ-ийн §7.1.2; 7.1.1; 7.1.3. УТэмХТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

“Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2011 он. №25.

³ ЗХХШТХ-ийн §80 → ИХШХШТХ-ийн §57.3 → УТэмХТХ-ийн §41-ийг үз. УТэмХТХ (шинэчилсэн найруулга). “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2011 он. №1.



Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол улсын тэмдэгтийн хураамжийг хураасан хэмжээгээр нэхэмжлэгчид шүүгчийн захирамжаар “буцаан олгоно”. Давж заалдах буюу хяналтын журмаар гомдол гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө түүнээсээ татгалзвал... тухайн шатны шүүхэд гомдол гаргахдаа төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг “буцаан олгох” захирамж гаргана. Давж заалдах болон хяналтын шатны шүүх нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэж шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон буюу өөрчилсөн тохиолдолд гомдол гаргагчаас тухайн шатны шүүхэд гомдол гаргахдаа төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг тухайн шатны шүүгчийн захирамжаар “буцаан олгоно”.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг сайн дураар хүлээн зөвшөөрч биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан бол нэхэмжлэгчийн урьдчилан төлсөн улсын тэмдэгтийн хураамжийн тавин хувийг буцаан олгоно.

Нэхэмжлэгч шаардлагаа багасгах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг сайн дураар хүлээн зөвшөөрч биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсанаас бусад тохиолдолд нэхэмжлэлээсээ татгалзах, нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэх замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол улсын тэмдэгтийн хураамжийг “буцаан олгохгүй”. Харин нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүйн улмаас нэхэмжлэлийг буцаасан бол улсын тэмдэгтийн хураамжийг “улсын орлого болгоно”. Улсын тэмдэгтийн хураамжийг “зохигчид хуваарилан” хариуцуулах асуудлыг нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хуваарилахтай адилаар зохицуулна.

Хяналтын асуулт

1. Шүүхийн зардал ба нөхөн төлүүлэх шүүхийн зардлын ялгааг тайлбарлана уу?
2. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээг хэрхэн тодорхойлох вэ?
3. Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг хэрхэн тодорхойлох вэ?
4. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлаас чөлөөлөх үндэслэл юу вэ?
5. Улсын тэмдэгтийн хураамжийг төлөхөөс чөлөөлөх, хөнгөлөх үндэслэлийг тайлбарлана уу?

Сорил

1. Нөхөн төлүүлэх шүүхийн зардал
 - а. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарсан зардал
 - б. Улсын төсвөөс гаргасан зардал
 - в. Гэрчийн мэдүүлийг очиж авсны зардал

2. Эд хөрөнгийн бус үнэлж болохгүй нэхэмжлэл
 - а. Хохирлоо арилгуулах нэхэмжлэл
 - б. Хүчингүй болгуулах нэхэмжлэл
 - в. Төлбөрийн хэмжээг багасгах нэхэмжлэл
3. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлаас чөлөөлөх үндэслэл
 - а. Эд хөрөнгийн байдал
 - б. Төлбөрийн байдал
 - в. Бусад байдал
4. Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх нэхэмжлэл
 - а. Тэтгэвэр тэтгэмжийн талаар гаргасан нэхэмжлэл
 - б. Хүчингүй болгуулах нэхэмжлэл
 - в. Шүүхийн зардал төлөхийг нь тодорхой хугацаагаар хойшлуулсан иргэний гаргасан нэхэмжлэл

Дасгал

1. Иргэн Б газар эзэмших эрхийг гэрчилгээг нь хүчингүй болгох шийдвэрийн улмаас өөрт 5 сая төгрөгийн шууд хохирол учирсан хэмээн ЗХШ-д хандан хохирлоо арилгуулах нэхэмжлэл гаргажээ. Энэ тохиолдолд иргэн Б-ийн нэхэмжлэлийн дүнд тохирох улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээ хэд байх вэ?
2. Иргэн Ц түүний хувийн өмчийн объектыг улсын мэдэлд дайчлан авсны нөхөх олговор, үнийг төлүүлэхээр зохих журмын дагуу ЗХШ-д нэхэмжлэл гаргажээ. Энэ тохиолдолд иргэн Ц-ийн нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлөх үндэслэлийг тодорхойлно уу?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль. ТМ эмхтгэл, 2011, №1

СЭДЭВ 21. Анхан шатны шүүх хуралдаан

Сэдвийн зорилго: Анхан шатны шүүх хуралдааныг оюутан аль болох өөрт хамгийн ойртуулсан аргаар судалж, шүүх хуралдааны уур амьсгалыг бүрдүүлэн хэргийн аль нэг оролцогчийн ашиг сонирхлыг илэрхийлэх юмуу эсхүл хөндлөнгийн байр сууринаас хандах зэргээр шүүх хуралдаан явуулах чадвар эзэмшинэ.



Нэр томъёоны тайлбар:

- **Анхан шатны шүүх хуралдааны дэг** - Тодорхой үе шатны дагуу тасралтгүй явагдах ажиллагааг журамласан горим дүрэм
- **Шүүх хуралдаан даргалагчийн үүрэг**- Хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох, хэргийн оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, шүүх хуралдааны дэгийг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээ авахыг
- **Нотлох баримтыг шинжлэх**- Нотлох баримтын хамаарал, болохуйц байдлын талаар шүүх хуралдаан дээр шууд хийгдэх ажиллагаа
- **Иргэдийн төлөөлөгч анхан шатны шүүх хуралдаанд оролцох**- Захиргааны хэргийг анхан шатны журмаар, хамтын зарчмаар хянан шийдвэрлэхэд шүүх бүрэлдэхүүнд оролцохыг
- **Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх**- Зөвлөлдөх тасалгаанд тодорхой аргачлалын дагуу шүүхийн шийдвэр гаргах үйл явц
- **Шүүхийн шийдвэрийг сонсгох**- Шүүх хуралдаан даргалагч шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг танилцуулахыг.

Шүүх хуралдааны дэг

Шүүх хуралдааныг нээх	Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааныг нээж, ямар хэрэг хянан шийдвэрлэх гэж байгааг товч, тодорхой зарлан мэдэгдэж, танхимд байгаа хүмүүст суухыг зөвшөөрснөөр шүүх хуралдаан эхэлнэ
Ирцийг бүртгэж танилцуулах	Шүүх хуралдаан эхэлмэгц шүүх хуралдааны ирцийг нарийн бичгийн дарга хуралдаан даргалагчид илтгэн танилцуулна. Шүүх хуралдаан даргалагч оролцогчдын нэрсийг дуудан, шүүх хэргийн оролцогчтой нэгбүрчлэн танилцаж, ирцийг дахин шалгана. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн итгэмжлэлийг шалгана
Процессын оролцогч шүүх хуралдаанд ирээгүйгээс гарах холбогдлыг хэлэлцэж шийдвэрлэх	Хэргийн оролцогч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна
Орчуулагч, хэлмэрчийн үүргийг тайлбарлах	Шүүх хуралдаанд орчуулагч, хэлмэрч оролцож байгаа бол түүнд эрх, үүргийг нь тайлбарлан өгнө

Гэрчийг гаргах	Шүүхэд дуудагдсан гэрч байгаа бол түүнийг шүүх хуралдааны танхимаас түр гаргана
Шүүх бүрэлдэхүүнийг зарлах ба татгалзан гаргах эрхийг нь тайлбарлах	Шүүх хуралдаан даргалагч шүүх бүрэлдэхүүнийг зарлан, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын нэрсийг дуудан танилцуулах бөгөөд шүүх бүрэлдэхүүн болон албаны бусад оролцогчийг татгалзан гаргах эрхийг нь тайлбарлан, уг эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгоно
Хэргийн оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах	Шүүгч болон албаны бусад оролцогчийг татгалзаагүй, түүнчлэн татгалзан гаргах тухай хүсэлтийг шүүх хүлээн аваагүй бол хуралдаан даргалагч хэргийн болон бусад оролцогчийн хуульд заасан эрх, үүргийг тайлбарлан өгнө
Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх	Шүүх хуралдаан даргалагч хэргийн болон бусад оролцогчид шүүхэд хандан хүсэлт, санал гаргах боломжийг олгох бөгөөд тэдгээрээс гаргасан хүсэлт болон саналыг сонсмогц шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч нэн даруй шийдвэрлэнэ
Хэргийг хэлэлцэж эхлэх “хэргийг хэрэгсэхгүй болгох”	Нэхэмжлэгч нэхэмжлэлээ дэмжиж байгаа эсэх, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрч байгаа эсэх, нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэх хүсэлтэй байгаа эсэхийг шүүх хуралдаан даргалагч асууж тодруулна.
Талууд байр сууриа илэрхийлэх, харилцан асуулт тавих	Нэхэмжлэгч тал нэхэмжлэлийн шаардлагаа дэмжин тайлбарлана. Дараа нь хариуцагч тал нэхэмжлэлийн шаардлагын талаар өөрийн байр суурийг илэрхийлж, татгалзаж буй үндэслэлээ тайлбарлана. Хэргийн оролцогчид харилцан асуулт тавьж болох ба бусад оролцогчдод хандан асуулт тавьж болно
Нотлох баримтыг шинжлэх асуулт тавих дараалал	Шүүх гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, цугларсан бичмэл болон эд мөрийн баримтыг судлах, үзлэг хийх, бусад нотлох баримтыг шинжлэх дарааллыг тогтооно. Дараахь дарааллаар асуулт тавина: <ul style="list-style-type: none"> - шүүх хуралдаан даргалагч - шүүгч, иргэдийн төлөөлөгч - нотлох баримт гаргаж буй этгээд - нотлох баримтыг эсэргүүцэж буй этгээд



Гэрчийн мэдүүлэг сонсох	Гэрч бүрийг тус тусад нь асууна. Шүүх хуралдаан даргалагч гэрчийг шүүх хуралдааны танхимд оруулж, түүний эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг урьдчилан сануулж, энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусган гарын үсэг зуруулна
Бичмэл ба эд мөрийн баримтыг шинжлэх	Шүүх хэрэгт цугларсан бичмэл ба эд мөрийн баримтыг шүүх хуралдаан дээр шинжлэн судлана
Шинжээчийн дүгнэлт сонгох	Шинжээчийн дүгнэлтийг шүүх хуралдааны явцад уншиж сонсонг танилцуулна
Хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох	Хуралдаан даргалагч хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох арга хэмжээ авах үүрэгтэй
Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх	Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаан завсарласныг мэдэгдэж, шүүх бүрэлдэхүүн шийдвэрээ гаргахын тулд зөвлөлдөх тасалгаанд орно
Шүүхийн шийдвэрийг сонгох, шүүх хуралдааныг хаах	Шүүх хуралдаан даргалагч шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг хуралдаанд оролцогчдод танилцуулж, шаардлагатай бусад асуудлыг тайлбарлан шүүх хуралдааныг хааж, шүүхийн шийдвэрийг гардан авах болон давж заалдах журмыг тайлбарлана

Хяналтын асуулт

1. Анхан шатны шүүх хуралдаан дэгийн дагуу явж чадсан уу?
2. Шүүх хуралдаан даргалагч хэргийн оролцогчийн эрхийг хангасан уу?
3. Шүүх хэргийг шийдвэрлэхэд шаардлагатай хангалттай нотлох баримт цуглуулсан уу?

Сорил

1. ЗХШ-ийн анхан шатны шүүх хуралдааны дэг процессын эрх зүйн аль зарчмын хэрэгжилтийг хангахад илүүтэй зориулагдсан байна вэ?
 - а. Мөрдөн шалгах зарчмын
 - б. Мэтгэлцэх зарчмын
 - в. Бусад
2. Нэхэмжлэгч хоёр дахь удаагаа шүүх хуралдаанд ирээгүйн үр дагавар юу байх вэ?
 - а. Шүүх хуралдааныг хойшлуулна
 - б. Нэхэмжлэлийг буцаана
 - в. Түүний эзгүйд хянан шийдвэрлэнэ

3. Шүүх хуралдаан даргалагчийн хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн гүйцэд тодруулах үүргийн зориулалт
 - а. Гэнэтийн цочирдуулсан шийдвэр гаргахын эсрэг чиглэсэн
 - б. Хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулахад чиглэсэн
 - в. Хэргийн оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжийг олгоход чиглэсэн
4. Хариуцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаан хүрэлцэн ирээгүйн үр дагавар юу байх вэ?
 - а. Шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулна
 - б. Хэргийг хянан шийдвэрлэж болно
 - в. Шүүх хуралдааныг хойшлуулна

Дасгал

1. Нэхэмжлэгч шүүх хуралдаанд хоёр дахь удаагаа хүрэлцэн ирээгүй байна. Тухайн хэргийн нэхэмжлэлийн шаардлага нь зөвхөн нэхэмжлэгчийн төдийгүй нийтийн ашиг сонирхлыг хөндсөн шаардлагыг агуулж байжээ. Энэ тохиолдолд шүүх хэрхэн шийдвэрлэх вэ?
2. Анхан шатны шүүх хуралдааны эхэнд хэргийн оролцогчоос шүүх хуралдаан даргалагчид хандан хэрэгт авагдсан нотлох баримтаас заримыг нотлох баримтын шаардлага хангаагүй үндэслэлээр хасуулах хүсэлт гаргажээ. Хуралдаан даргалагч уг хүсэлтийг нотлох баримт шинжлэх үед хэлэлцье гэж шийдвэрлэжээ. Энэ тохиолдолд шүүх хуралдаан даргалагчийн шийдвэр зөв үү?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2002, №8, нэмэлт өөрчлөлт-ТМ, 2007, №32

СЭДЭВ 22. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, түүний төрөл

Сэдвийн зорилго: Анхан шатны шүүхийн шийдвэр, түүний төрлийг судалж, шүүхийн шийдвэрт тавигдах шаардлагын агуулгыг танин мэдэж, түүнийг үндэслэлтэй гаргах арга барилд суралцана

Нэр томъёоны тайлбар:

- **Шүүхийн шийдвэр-** Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд гаргасан шийдвэрийг



- **Шүүхийн шийдвэрт тавигдах шаардлага-** Шүүхийн шийдвэрт заавал тусгавал зохих хуульд заасан шаардлага
- **Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох-** Шүүхийн шийдвэрийг сонсгосноор хүчин төгөлдөр болно
- **Хүчингүй болгох тухай шийдвэр-** Маргаан бүхий захиргааны акт хууль бус бөгөөд уг хууль бус актаар нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн тохиолдолд гаргах шийдвэрийг
- **Даалгах шийдвэр-** Захиргааны акт гаргахаас татгалзсан болон эсхүл эс үйлдэхүй нь хууль бус бөгөөд уг хууль бус актаар нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн тохиолдолд зохих захиргааны акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах шийдвэрийг
- **Илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр-** Захиргааны акт илт хүчин төгөлдөр бус тохиолдолд гаргах шийдвэрийг
- **Эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр-** Эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож хүлээн зөвшөөрөх шийдвэрийг



Шүүхийн шийдвэрт тавигдах шаардлага

- Хууль зүйн шаардлага нь шүүхийн шийдвэр бүхэлдээ хуульд үндэслэсэн буюу хуулийн дагуу гарсан байхыг шаардана
- Үндэслэл бүхий байх шаардлага нь шүүхийн шийдвэрийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг харуулах буюу хэрэгт авагдсан, хуулийн шаардлага хангасан, уг хэрэгт хамааралтай, ач холбогдол бүхий, шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтад тулгуурласан бөгөөд түүнд үнэн зөв үнэлэлт өгсөн байх болон захиргааны актад материаллаг хэмжүүрээр хууль зүйн үндэслэл бүхий гаргалгаа хийн дүгнэлт гаргасан байхыг тус тус шаардана

- Хэл зүйн шаардлага нь шүүхийн шийдвэрийн хэл, найруулга энгийн ойлгомжтой, эргэлзээгүй, тодорхой, илүүц сул үггүй томъёологдсон байхыг шаардана

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН БҮТЭЦ

ГАРЧИГ

УДИРТГАЛ

Тодорхойлох
хэсэг

Үндэслэх
хэсэг

Тогтоох
хэсэг

- **Гарчиг:** ЗХШ шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана
- **Удиртгал:** ЗХШ-ийн шийдвэрийг хэзээ, хаана, ямар шүүх гаргаж байгаа, шүүх бүрэлдэхүүн болон шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, захиргааны хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заана
- **Тодорхойлох:** Хэргийн нөхцөл байдлыг аль болох бодитойгоор харуулахад чиглэнэ. Энэ хэсэгт нэхэмжлэлийн шаардлагын агуулга, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, прокурорын болон иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тусгана
- **Үндэслэх хэсэг:** Шүүхийн шийдвэрийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг харуулна. Үүний тулд шийдвэрийн үндэслэх хэсэг дэлгэрэнгүй бөгөөд маш тодорхой үндэслэгдсэн байвал зохино. Энэ хэсэгт захиргааны хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал, захиргааны актын хууль зүйн үндэслэлийг тусгана
- **Тогтоох хэсэг:** Шүүхийн шийдвэрийн шийдлийг товчхон бөгөөд захиран тушаах хэлбэрээр илэрхийлнэ. Энэ хэсэгт удирдлага болгон баримталсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь болон зарим хэсгийг хангасан болон хэрэгсэхгүй болгосон, түүнчлэн улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилах, эд мөрийн баримтыг хэрхэхийг тус тус шийдвэрлэнэ. Түүнчлэн шаардлагатай бол шийдвэр гүйцэтгүүлэх арга, журам, хугацаа, шийдвэрийг завж заалдах журам, хугацааг заана

Хяналтын асуулт

1. Шийдвэрийн удиртгал хэсэгт хийх гол дүгнэлт юу вэ?
2. Тодорхойлох хэсэгт захиргааны процессын аль зарчим илүүтэй тусгалаа олдог вэ?



3. Илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх шийдвэрийг ямар тохиолдолд гаргах вэ?
4. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох үндэслэлийг тайлбарлана уу?
5. Шүүхийн шийдвэрийн хууль зүйн болон агуулгын шаардлагыг тайлбарлана уу?

Сорил

1. Шүүхийн шийдвэр
 - а. Анхан шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргах шийдвэр
 - б. Хяналтын шатны шүүхээс гаргах шийдвэр
 - в. Анхан шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлээд гаргах шийдвэр
2. Захиргааны актыг хүчингүй болгох тухай шүүхийн шийдвэр
 - а. Маргаан бүхий захиргааны акт хууль бус бөгөөд уг актаар нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн тохиолдолд гаргана
 - б. Захиргааны актын улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тохиолдолд гаргана
 - в. Захиргааны акт илт хууль бус тохиолдолд гаргана
3. Даалгах шийдвэр
 - а. Төлбөр тогтоосон захиргааны актын төлбөрийн хэмжээг багасгах тохиолдолд гаргана
 - б. Захиргааны акт гаргахаас татгалзсан нь хууль бус бөгөөд уг актыг гаргах зайлшгүй шаардлага тулгарсан бол гаргана
 - в. Дахин шинэ акт гартал уг актыг түдгэлзүүлэх тохиолдолд гаргана
4. Шүүхийн шийдвэр үндэслэлтэй байх шаардлага
 - а. Шүүхийн шийдвэр хуулийн дагуу гарсан байх
 - б. Нэхэмжлэлд дурьдсан захиргааны актын хууль зүйн үндэслэлийг дүгнэсэн байх
 - в. Шүүхийн шийдвэр эргэлзээгүй тодорхой томъёологдсон байх

Дасгал

1. Өгөгдсөн анхан шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийнэ үү?
2. Анхан шатны шүүхийн шийдвэрийн төсөл бичнэ үү?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45

СЭДЭВ 23. ЗХШ-ийн шийдвэр биелүүлэх ажиллагаа

Сэдвийн зорилго: ЗХШ-ийн шийдвэр биелүүлэх ажиллагаа, түүний онцлогтой танилцаж, шүүхийн шийдвэрийг сайн дураар болон албадан биелүүлэх арга, журмын талаар цэгцтэй мэдлэг эзэмшинэ.

Нэр томъёоны тайлбар:

- **Төлөөлүүлэн гүйцэтгэж болох ажиллагаа-** Захиргааны өмнөөс хэн нэгэн төлөөлөн хийж болох үйлдэл
- **Төлөөлүүлэн гүйцэтгэж болохгүй ажиллагаа-** Захиргааны өмнөөс өөр хэн нэгэн төлөөлөн хийж болохгүй үйлдэл
- **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх арга-** Шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар хариуцагч (нэхэмжлэгч)-д нөлөөлөхүйц хууль зүйн арга, хэрэглүүрийг
- **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх журам-** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх аргыг хэрхэн хэрэгжүүлэх дэс дараалал тогтоосныг
- **Гүйцэтгэх баримт бичиг-** Хуулийн хүчин төгөлдөр болсон ЗХШ-ийн шийдвэр, захиргааны шийтгэвэр, мөн эвлэрлийн гэрээг баталгаажуулсан ЗХШ-ийн шүүгчийн захирамжийг тус бүрд нь эдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудсын хамт гүйцэтгэх баримт бичиг гэж нэрлэнэ
- **Гүйцэтгэх баримт бичигт тавигдах шаардлага-** Хэлбэрийн болон агуулгын шаардлага тавигдана. Хэлбэрийн шаардлагын хувьд гүйцэтгэх баримт бичгийг олгосон шүүхийн нэр, шүүхийн шийдвэр гаргасан огноо, дугаар, нэхэмжлэгч “төлбөр авагч” болон хариуцагч “төлбөр төлөгч”-ийн нэр, хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх, регистрийн дугаар, төлбөрийн төрөл, хэмжээ болон шүүхээс гаргасан шийдвэрийн хүчин төгөлдөр болсон хугацаа хамаарна. Агуулгын хувьд ЗХШ-ийн шийдвэр, шүүгчийн захирамж, шийтгэврийн тогтоох хэсгийн агуулга хангалттай тодорхойлогдсон байх шаардлага тавигдана.

ЗХШ-ийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог

ЗХШ-ийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлөөлүүлэн гүйцэтгэж болохгүй ажиллагаа нэлээдгүй байр суурийг эзэлдэг нь түүний онцлог гэж хэлж болно. Хууль тогтоогчийн зүгээс төлөөлүүлэн гүйцэтгэж болохгүй шүүхийн шийдвэрийг биелүүлэх эрх зүйн зохицуулалтыг ЗХХШТХ-ийн §78.2-т “ЗХШ шийдвэрээ биелүүлэх арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно” гэж шинээр тодорхойлжээ.



Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх

Ахлах шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг буцаах хуульд заасан үндэслэл байхгүй бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, гүйцэтгэх баримт бичиг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол гарган зохих шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолын хувийг түүнийг гаргасан өдрөөс хойш 3 хоногийн дотор төлбөр авагч, төлбөр төлөгч болон шүүхэд явуулна.



Хяналтын асуулт

1. ЗХШ-ийн шийдвэр болон иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхийн гол ялгааг тодорхойлно уу?
2. Зөвхөн захиргаа өөрөө биелүүлэх ажиллагаа шаарддаг шүүхийн шийдвэрийн талаар ярилцана уу?
3. Захиргаа заавал тусгайлан биелүүлэх ажиллагаа шаардахгүй “гармагц биелэгдсэнд тооцох” шүүхийн шийдвэрийг нэрлэнэ үү?
4. ЗХШ-ийн шийдвэрийг албадан биелүүлэх арга, журмын талаар ярилцана уу?

Сорил

1. Төлөөлүүлэн гүйцэтгэж болох ажиллагаа
 - а. Төлбөр гаргуулах
 - б. Барилга нураах
 - в. Даалгах шийдвэрийг биелүүлэх

2. Төлөөлүүлэн гүйцэтгэж болохгүй ажиллагааг албадан биелүүлэх гол арга
 - а. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх
 - б. Их хэмжээний торгууль ногдуулах
 - в. Харилцах дансыг битүүмжлэх
3. Нийтийн эрх зүйн субьектэд ашигтай шийдвэрийг гүйцэтгэх арга
 - а. Торгууль ногдуулах
 - б. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх
 - в. Харилцах дансыг битүүмжлэх
4. Гүйцэтгэх баримт бичгийн агуулгын шаардлага
 - а. Төлбөрийн төрөл, хэмжээг заах
 - б. Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулга тодорхой байх
 - в. Шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр болсон хугацаа

Дасгал

1. Төрийн жинхэнэ албан хаагчийг ажлаас үндэслэлгүйгээр халсан шийдвэрийг ЗХШ хүчингүй болгож, уг албан хаагчийг ажилд нь эгүүлэн томилох шийдвэрийг гаргажээ. Гэтэл хариуцагч болох захиргааны албан тушаалтан, уг ажилтныг ажилд нь эгүүлэн томилсон шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс тогтоож өгсөн хугацааг хэтрүүлжээ. Энэ тохиолдолд уг шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх хамгийн тохиромжтой аргыг тодорхойлно уу?
2. Төрийн жинхэнэ албан хаагчийг ажлаас үндэслэлгүйгээр халсан шийдвэрийг ЗХШ хүчингүй болгож, уг ажилтны ажилгүй байсан хугацааны цалинг түүнд олгохоор шийдвэрлэжээ. Хэрэв хариуцагч болох захиргаа ажилтны ажилгүй байсан хугацааны цалинг олгох шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд эл шүүхийн шийдвэрийг ямар аргаар, хэрхэн биелүүлэх вэ?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2002, №8, нэмэлт өөрчлөлт- ТМ, 2007, №32



СЭДЭВ 24. Давж заалдах шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Сэдвийн зорилго: Шүүхийн шийдвэрт маргах хэрэгсэл буюу түүний үр нөлөөг танин мэдэж, давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ, уг шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн магадлалын талаарх ойлголт, бусад шатны шүүхээс давж заалдах шатны шүүхийн ялгагдах онцлогийг судалж, уг шатаар хэргийг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх чадварыг эзэмшихэд чиглэнэ

Нэр томъёоны тайлбар:

- **Suspensiv-effekt**- Хойшлуулах үйлчлэлтэй. Анхан шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд уг шийдвэрийг давж заалдах болон хяналтын шатаар хянан шийдвэрлэх хүртэл анхан шатны шүүхийн шийдвэр үйлчлэхгүй гэсэн утгатай
- **Devolutiv-effekt**- Шилжүүлэх нөлөөлөлтэй. Анхан шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд тухайн хэрэг дээд шатны шүүхэд шууд шилжих үйлчлэлтэй
- **Давж заалдах гомдол гаргах эрх**- Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах эрх бүхий субъект нь хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч байна. Анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах эрхтэй
- **Магадлал**-Давж заалдах шатны шүүхээс захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргасан шийдвэрийг
- **Хэргийг бүхэлд нь хянах**-Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийн бодит болон хууль зүйн үндэслэлийг хянан үзэхийг
- **Магадлалд дурдсан заалт**- Давж заалдах шатны шүүхээс хэргийг анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаахдаа хэргийн нөхцөл байдлыг бүрэн гүйцэд илрүүлэх зорилгоор зайлшгүй хийгдвэл зохих алхмыг заасан заалт. Магадлалын заалтыг хэргийг дахин хэлэлцэж байгаа шүүх заавал биелүүлнэ.

ДАВЖ ЗААЛДАХ ГОМДОЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

<p>Давж заалдах гомдлыг нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд болон түүний төлөөлөгч, өмгөөлөгч гаргах эрхтэй</p>	<p>Анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах эрхтэй</p>	<p>Давж заалдах гомдолд дараахь бүрдүүлбэрийн шаардлага тавигдана:</p> <ul style="list-style-type: none"> - Бичгээр гаргах бөгөөд ямар шүүхэд гаргаж байгаа - Гомдол гаргаж байгаа этгээдийн овог, эцгийн нэр, нэр хаяг, эсхүл албан тушаал, хуулийн этгээд бол оноосон нэр хаяг, оршин байгаа газар - Аль шүүхийн ямар шийдвэрийг давж заалдаж байгаа - Шийдвэрийн ямар зүйл, заал, үндэслэлийг зөвшөөрөхгүй байгаа, түүний үндэслэл - Гомдол гаргаж буй этгээдийн хүсэлт - Гарын үсэг
---	---	--

Давж заалдах гомдол гаргах, шилжүүлэх, хүлээн авах

Давж заалдах гомдлыг тухайн шийдвэрийг гаргасан анхан шатны шүүхээр дамжуулан гаргана. Гомдлыг тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн нарийн бичгийн дарга хүлээн авч, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн гаргасан тайлбарыг хавсарган хэргийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд 3, орон нутагт 7 хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.

Давж заалдах гомдол бүхий хэргийг давж заалдах шатны захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу уг шатны шүүхийн шүүгчид хуваарилна.

Ийнхүү хэргийг хүлээн авсан шүүгч давж заалдах гомдлын зөвшөөрөгдөх байдлыг шалгах хийгээд үндэслэлтэй байдлыг судална. Ингэхдээ шүүхийн шийдвэрийн бодит үндэслэл буюу анхан шатны шүүх хэргийн нөхцөл байдлыг бүрэн дүүрэн тогтоосон эсэх, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын хамаарал, болохуйц байдал хангагдсан хийгээд түүний хууль зүйн үндэслэлтэй эсэхийг тус тус тал бүрээс нь судлан үзнэ.

Давж заалдах шатны шүүх хуралдаан


Хэргийг хүлээн авснаас хойш захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 30 хоногт багтаан шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу томилогдсон 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

Давж заалдах шатны шүүх хуралдаанаар анхан шатны шүүхийн шийдвэрийн бодит болон хууль зүйн үндэслэлийг хянаана. Үүний тулд давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүх хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг болон хэргийн нөхцөл байдлыг бүрэн дүүрэн тогтоосон эсэх, нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал зэргийг хянан үзэж, хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй.

Давж заалдах шатны шүүх хуралдааныг шүүгчдийн зөвлөлгөөнөөс томилогдсон шүүгч даргална. Давж заалдах шатны шүүх хуралдаанд шүүх бүрэлдэхүүний аль нэг шүүгч нь хэргийг илтгэж танилцуулна. Дараа нь шүүх бүрэлдэхүүн илтгэгчид асуулт тавих болон нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн тайлбарыг сонсоно. Шүүх бүрэлдэхүүн шаардлагатай зарим зүйлийг тэднээс асууж тодотгоно. Мөн хэргийн оролцогчид харилцан асуулт тавьж болно. Үүний дараа шүүх хуралдаан завсарлаж шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орж зөвлөлдөнө.



Магадлалын төрөл



- **Хэвээр үлдээх магадлал:** Давж заалдах гомдол үндэслэлгүй буюу анхан шатны шүүхийн шийдвэр хууль зүйн үндэслэлтэй бол давж заалдах шатны шүүх гомдлыг хангахгүй орхиж, анхан шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх тухай магадлал гаргана
- **Өөрчлөх магадлал:** Тухайн маргааныг шийдвэрлэх нөхцөл бүрэн хангагдсан бол давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөн шийдвэрлэж болно.
- **Хүчингүй болгох магадлал:** Анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлгүй бол түүнийг хүчингүй болгож дараахь байдлын аль нэгээр шийдвэрлэнэ. Үүнд:
 - а. Хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах
 - б. Нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгох
 - в. Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг буюу бүгдийг хангах
 - г. Хэргийг хэрэгсэхгүй болгон нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах

Магадлалыг гардан авах

Магадлал хүчинтэй болсноос хойш 7 хоногийн дотор магадлалын агуулгыг бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Магадлалыг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч өөрөө гардан авах буюу ийнхүү гардан аваагүй бол түүнд хүргүүлнэ.

Хяналтын асуулт

1. Шүүхийн шийдвэрт маргах хэрэгсэл гэж юу вэ? Түүний үр нөлөөг тайлбарлана уу?
2. Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ хязгаарлагдах тохиолдлуудыг нэрлэнэ үү?
3. Давж заалдах шатны шүүх хуралдаан ба анхан шатны шүүх хуралдааны дэгийг хооронд нь харьцуулан тайлбарлана уу?

Сорил

1. Давж заалдах гомдолд тавигдах шаардлага
 - а. Гомдлыг хэргийн оролцогч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч гаргах эрхтэй
 - б. Гомдлыг хэргийн болон бусад оролцогч гаргах эрхтэй
 - в. Гомдлыг анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногт багтаан гаргаж болно.
2. Хэргийг бүх талаас нь хянах гэж
 - а. Анхан шатны шүүхийн шийдвэрийн бодит болон хууль зүйн үндэслэлийг хянахыг
 - б. Анхан шатны шүүх хууль зөв хэрэглэсэн эсэхийг хянан үзэхийг
 - в. Гагцхүү анхан шатны шүүх хэргийн нөхцөл байдлыг зөв тогтоосон эсэхийг хянахыг
3. Хүчингүй болгох магадлал
 - а. Хэргийн нөхцөл байдлыг бүрэн гүйцэд илрүүлсэн боловч хууль буруу хэрэглэсэн
 - б. Анхан шатны шүүх хэргийн оролцогчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг нь хангалгүй захиргааны хэргийг шийдвэрлэсэн
 - в. Шүүх хуулийг буруу хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжтой бол
4. Магадлалыг гардан авах
 - а. Магадлалыг хэргийн оролцогч өөрөө гардан авах үүрэгтэй
 - б. Магадлалыг хэргийн оролцогчид шүүх гардуулан өгөх үүрэгтэй
 - в. Бусад

Дасгал

1. Давж заалдах шатны шүүх хуралдааны эхэнд гомдол гаргагч тал шүүх бүрэлдэхүүнд хандаж анхан шатны шүүхэд гаргаагүй буюу гаргах боломжгүй байсан бөгөөд уг хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий шинэ нотлох баримтыг гаргаж өгөв. Энэ тохиолдолд шүүх уг шинэ нотлох баримтыг хүлээн авах уу?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45



3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2002, №8, нэмэлт өөрчлөлт-ТМ, 2007, №32

СЭДЭВ 25. Хяналтын шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Сэдвийн зорилго: Хяналтын шатны шүүхээр захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, онцлогийг судалж, уг шатаар хэргийг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх чадварыг эзэмшихэд чиглэнэ

Нэр томъёоны тайлбар:

- **Хяналтын гомдол гаргах эрх-** Давж заалдах шатны журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлалыг хэргийн оролцогч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл УДШ-ийн захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй
- **Хяналтын шатны шүүхийн тогтоол-** Хяналтын шатны шүүх захиргааны хэргийг хянаад гаргасан шийдвэрийг
- **Хууль зөрчсөн гэж-** Анхан болон давж заалдах шатны шүүх захиргааны хэргийг хянан шийдвэрлэхдээ хууль буруу хэрэглэсэн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөний аль нэгийг ойлгоно

Хяналтын гомдолд тавигдах шаардлага

Гомдлын хэлбэрийн шаардлага	Гомдлыг бичгээр гаргана
Гомдлыг эрх бүхий этгээд гаргана	Хяналтын гомдлыг хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч буюу төлөөлөгч гаргах эрхтэй
Гомдол үндэслэл бүхий байна	Гомдлын үндэслэлд дараахь шаардлага тавигдана: - шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн - шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн
Хөөн хэлэлцэх хугацаа хэтрээгүй байх	Хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч буюу төлөөлөгч магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор хяналтын гомдол гаргаж болно
Давж заалдах гомдол гаргасан байх	Давж заалдах гомдол гаргаагүй бол хяналтын гомдол гаргах эрхгүй байна
Улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлэх	Шийдвэр, магадлалыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлнө

Хяналтын гомдол гаргах, шилжүүлэх, хүлээн авах

Хяналтын гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүх хүлээн авна. Гомдол хүлээн авсан шүүгч буюу нарийн бичгийн дарга хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчид гомдлыг танилцуулах бөгөөд тэдгээр нь гомдлын талаар тайлбараа өгөх эрхтэй байна. Хэрэгт хуульд заасны дагуу улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт болон хэргийн оролцогчийн гомдлыг хавсарган, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд 3 хоногийн дотор, хөдөө орон нутагт 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

Гомдол бүхий хэргийг УДШ-ийн Захиргааны хэргийн танхим хүлээн авч, шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу томилогдсон шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ.

Хэргийг хүлээн авсан шүүгч гомдол шаардлага хангасан эсэхийг шалгана. Гомдол шаардага хангаагүй бол уг гомдлыг хэлэлцэхээс татгалзах тухай шүүгч захирамж гаргана.

Хэргийг хүлээн авсан шүүгч гомдлын үндэслэл болон шүүхийн шийдвэр, магадлалын хууль зүйн үндэслэлийг хэргийн материалд түшиглэн холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг бүхий л талаар судална.

Хяналтын шатны шүүх хуралдаан

Хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хяналтын шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ. Хяналтын журмаар хэргийг УДШ-ийн Захиргааны хэргийн танхим 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.

Хэргийг илтгэгч шүүгч танилцуулна. Илтгэгчийг илтгэсний дараа хуралдаан даргалагч нь гомдол гаргагч талаас эхлэн бусад оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч гомдлын талаар өөрийн байр сууриа илэрхийлж тайлбар гаргах боломж олгоно. Үүнтэй холбогдуулан шүүх бүрэлдэхүүн хэргийн оролцогчоос асуулт асууж, хариулт авч болно. Хуралдаан даргалагч хэргийн оролцогчид харилцан асуулт тавьж хариулт авах боломж олгож болно. Хэргийг тал бүрээс нь хангалттай хэлэлцсэн гэж үзвэл хуралдаан даргалагч шүүх хуралдааныг завсарлуулж, шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөнө. Шүүх бүрэлдэхүүн асуудал бүрийг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Шүүх хуралдаан даргалагч хяналтын шатны шүүхийн тогтоолыг уншиж сонсгон, танилцуулснаар хуралдааныг хаана.



Тогтоолын төрөл

Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхих

Шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулах

Магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр мөн шүүхэд нь буцаах

Хяналтын асуулт

1. Хяналтын гомдолд ямар шаардлага тавигдах вэ?
2. Гомдлын үндэслэлд тавигдах шаардлагыг тайлбарлана уу?
3. Хяналтын шатны шүүх хэргийг бүх талаас нь хянах уу?
4. Хяналтын шатаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогийг тайлбарлана уу?

Сорил

1. Хяналтын гомдолд тавигдах шаардлага
 - а. Гомдлын үндэслэлийг заах
 - б. Магадлалыг гардан авсан, хүргүүлснээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах
 - в. Бусад
2. Хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ
 - а. Хэргийг бүхэлд нь хянах
 - б. Шийдвэр, магадлалын хууль зүйн үндэслэлийг хянах
 - в. Хэргийн бодит үндэслэлийг хянах
3. Магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх тогтоол
 - а. Хэргийн нөхцөл байдал бүрэн тодорхой болсон боловч магадлал бүхэлдээ болон эсхүл түүний зарим заалт алдаатай, харин шийдвэр бүхэлдээ болон түүний зарим заалт хууль зүйн үндэслэлтэй бол

- б. Хэргийн нөхцөл байдал бүрэн тодорхой болоогүй бөгөөд магадлал болон шийдвэрийн аль аль нь эрх зүйн алдаатай бол
 - в. Бусад
4. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох тогтоол
- а. Хэргийн нөхцөл байдал бүрэн тодорхой болоогүй бөгөөд магадлал болон шийдвэрийн аль аль нь эрх зүйн алдаатай бол
 - б. Шийдвэр, магадлалын аль аль нь эрх зүйн алдаатай бөгөөд уг шийдвэр, магадлалыг өөрчлөх юмуу буцаах хууль зүйн үндэслэлгүй бол
 - в. Бусад

Дасгал

1. Хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан нэхэмжлэгч Б-г хяналтын гомдолдоо гомдлынхоо үндэслэлийн талаар огт заагаагүй байна гэх үндэслэлээр тухайн хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шүүгч гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай захирамж гаргажээ. Энэ тохиолдолд анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж үндэслэлтэй юу?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт- ТМ эмхтгэл, 2010, №45
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2002, №8, нэмэлт өөрчлөлт- ТМ, 2007, №32

СЭДЭВ 26. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллагаа

Сэдвийн зорилго: Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг дахин хянах болон үүний улмаас хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа тус бүрийн онцлогийг танин мэдэх, уг ажиллагааг явуулах чадварыг эзэмшихэд чиглэнэ

Нэр томъёоны тайлбар:

- **Шинээр илэрсэн нөхцөл байдал-** Хуулийн хүчин төгөлдөр үйлчилж буй шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгоход шууд хүргэхүйц нөхцөл байдал, үйл баримтыг хэлнэ



- **Хүсэлт**- Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай өргөдөл
- **Ердийн журам**- Шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоож, шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгомогц хэргийн нөхцөл байдал анхны төлөв байдалдаа шилжин орж, шинээр шүүхийн процесс эхлүүлэхийг ойлгоно.

ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ		
Шүүхийн шийдвэр гарах үед хэргийн оролцогчид мэдэгдээгүй буюу мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрвэл	Шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болсон нотлох баримт хуурамч, эсхүл шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хэргийн оролцогчийн уг хэргийг хянан шийдвэрлэх үед гаргасан үйлдэл (эс үйлдэхүй) эрүүгийн гэмт хэрэг болох нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон	Шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон шүүхийн шийтгэх тогтоол буюу шийдвэр эсхүл төр, захиргааны болон бусад байгууллагын шийдвэр нь хууль бус байсны улмаас хүчингүй болсон

Хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг тийнхүү хянах үндэслэл байгааг мэдсэнээс хойш 30 хоногийн дотор хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч буюу төлөөлөгч тухайн хэргийг хамгийн сүүлд хянан шийдвэрлэсэн шүүхэд гаргана.



Шүүх хүсэлтийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ. Шүүх хуралдаан тухайн шатны шүүх хуралдааны дэгийн дагуу явагдана. Уг шүүх хуралдаанаар зөвхөн гаргасан хүсэлт нь үндэслэлтэй эсэхийг л хянан шийдвэрлэнэ.

Шүүх хүсэлтийг хангах эсхүл хангахаас татгалзах тухай тогтоол гаргана. Хэрэв хүсэлтийг хангавал шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгоно. Энэ тохиолдолд хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх төлөв байдал бий болно.

Хяналтын асуулт

1. Шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар тодорхой жишээ татан тайлбарлана уу?
2. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллагааны онцлогийг тайлбарлана уу?
3. Хэрийг ердийн журмаар хянан шийдвэрлэх гэдэгт юуг ойлгох вэ?

Сорил

1. Шинээр илэрсэн нөхцөл байдал гэж
 - а. Тогтоол, шийдвэр
 - б. Хууль зүйн факт
 - в. Хүсэлт
2. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэл
 - а. Хүсэлт гаргасан
 - б. Тогтоол, шийдвэр байгаа
 - в. Өмнө мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрсэн
3. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах хүсэлтийг
 - а. Шүүх хуралдаанаар хэлэлцэнэ
 - б. Дээд шатны шүүх шийдвэрлэнэ
 - в. Тухайн шатны шүүхийн ерөнхий шүүгч шийдвэрлэж хариу өгнө
4. Хэргийг ердийн журмаар хянан хэлэлцэх гэж
 - а. Шүүхэд анх нэхэмжлэл гаргах журмаар хянан хэлэлцэхийг
 - б. Дээд шатны шүүхээр хянан шийдвэрлэхийг
 - в. Хүсэлтийг буцаахыг

Дасгал

1. Өөр аймаг, сумын харьяалал бүхий хоёр иргэн санал өгсөн нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлсөн гэх үндэслэлээр орон нутгийн сонгуулийн нэгэн тойрогт явагдсан санал хураалтын дүнг баталсан сонгуулийн хорооны холбогдох



шийдвэрийг шүүх хүчингүй болгон шийдвэрлэжээ. Гэтэл шүүхийн шийдвэр гарсны дараа тухайн тойргийн сонгогчдын саналын хуудсыг буруу тоолсон болох нь тогтоогджээ. Энэ тохиолдлыг шинээр илэрсэн нөхцөл байдал гэж үзэх үү?

Эх сурвалж

1. А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”. Хоёр дахь хэвлэлт. УБ., 2012 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2003, №3, нэмэлт өөрчлөлт-ТМ эмхтгэл, 2010, №45
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. ТМ эмхтгэл, 2002, №8, нэмэлт өөрчлөлт-ТМ, 2007, №32

III. “ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

СЭДЭВ 1. Захиргааны процессын эрх зүйн ойлголт

Хичээлийн зорилго: Захиргааны процессын эрх зүйг салбар эрх зүйн үндсэн шалгуураар авч үзсэнээр бусад салбар эрх зүйгээс ялгагдах онцлогийг тодорхойлж, уг эрх зүйн суурь асуудлаар өөрийн үзэл бодлыг илэрхийлэх чадвараа бататган, эрх зүйн харилцаан дахь асуудалд процессын эрх зүйн үүднээс хандах хандлага төлөвшүүлэхэд оршино.

Түлхүүр үгс:

- Процесс- үйл явц
- Хууль зүйн процесс
- Процессын эрх зүй
- Ажиллагаа
- Материаллаг эрх зүй
- Процедур

Хичээлийн агуулга:

- Захиргааны процессын эрх зүйн ойлголт
- Захиргааны процессын эрх зүйн үндсэн шинж
- Хууль зүйн бусад процессоос захиргааны процессын эрх зүйн ялгарах онцлог, шалгуур

Хяналтын асуулт:

- Процессын хууль зүйн утга нь юу вэ?
- Материаллаг ба процессын эрх зүйн зааг ялгаа тайлбарлана уу?
- Захиргааны процессын эрх зүйн хамгийн гол шинжийг нэрлэнэ үү?
- Захиргааны процессын эрх зүй нь Захиргааны материаллаг эрх зүйгээс ялгагдах шалгуурыг тодорхойлно уу?
- Захиргааны процессын эрх зүй иргэний процессын эрх зүйгээс аль шинжээрээ ялгаатай вэ?



СЭДЭВ 2. Захиргааны процессын эрх зүйн зарчимын ойлголт, онцлог, төрөл

Хичээлийн зорилго:

Оюутныг зарчимд сургах. Ром-германы эрх зүйн тогтолцооны нэг гол онцлог үүнд оршино. Захиргааны процессын эрх зүйн зарчмын ойлголт, онцлог, төрлийн талаарх оюутны мэдлэгийг гүнзгийрүүлэх, уг зарчмыг хэрэгтэй үед тодорхой тохиолдолд нь мэргэжлийн түвшинд хэрэглэх чадварыг эзэмшихэд энэ хичээлийн зорилго оршино.

Түлхүүр үгс:

- Мэдэгдэх ба сонсгох зарчим
- Тэгш байдлын зарчим
- Мөрдөн шалгах зарчим (Inquisitionsmaxime)
- Диспозитив зарчим (Dispositionsmaxime)
- Мэтгэлцэх зарчим

Хичээлийн агуулга:

- Эрх зүйн зарчмын тухай шинэ ойлголт
- Захиргааны процессын эрх зүй хууль зүйн бусад процессоос ялгарах нэг шалгуур нь түүний зарчим болох нь
- Захиргааны процессын эрх зүйн гол зарчмууд
- Захиргааны процессын эрх зүйн зарчмыг процессын ажиллагаанд баримтлах нь
- Эрх зүйн хийдэл, давхардал утга, тодорхойгүй байдал үүссэн үед эрх зүйн зарчмыг хэрэглэж сурах нь

Хяналтын асуулт:

- Процессын зарчим хэнд зориулагддаг вэ?
- Зарчим зөрчигдсөнөөс үүсэх үр дагаварыг хэн хариуцах вэ?
- ЗПЭЗ-н хамгийн гол зарчмыг үндэс болгон ЭБШЭЗ ба ИПЭЗ-тэй харьцуулсаны үндсэн дээр ЗПЭЗ нь уг хоёр эрх зүйн хаана, хэрхэн байрлахыг зурж үзүүлнэ үү?
- Захиргааны процесст мөрдөн шалгах зарчим төгс хэрэгжих үү?
- Захиргааны хэргийн шүүх хуралдааны танхимд дэг сахиулагч эхний 30 хүнийг оруулаад дараагийн 15 хүнийг танхимын багтаамж хүрэлцэхгүй тул оруулаагүй байна. Энэ нь тэгш байдлын зарчмыг зөрчих үү?
- Захиргааны хэргийн хяналтын шатны шүүхэд диспозитив зарчим хамаарах уу?

СЭДЭВ 3. Захиргааны процессын эрх зүй ба бусад салбар эрх зүйн харилцан хамаарал

Хичээлийн зорилго:

Захиргааны процессын эрх зүйн бусад салбар эрх зүйтэй уялдах байдлыг тодорхойлж, түүнийг танин мэдэх, мэргэшлийн зөв хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Түлхүүр үгс

- Эрх зүйт төр
- Ардчилал
- Үндсэн эрхийн өдөр тутмын хэрэгжилт
- Захиргааны акт
- Объектив эрх зүйн хяналт
- Субъектив эрх зүйн хамгаалал
- Шалгалтын хэмжүүр
- Гомдлоор авч хэлэлцэх хэрэг

Хичээлийн агуулга:

- Материаллаг ба процессын эрх зүйн уялдах тал
- Захиргааны процессын эрх зүй ба Үндсэн хуулийн эрх зүйн уялдаа холбоо
- Захиргааны процессын эрх зүй ба Захиргааны эрх зүйн уялдаа холбоо
- Захиргааны процессын эрх зүй ба Иргэний процессын эрх зүйн уялдаа холбоо

Хяналтын асуулт

- Захиргааны процессын эрх зүй нь материаллаг Үндсэн хуулийн эрх зүйтэй хэрхэн холбогдох вэ? Түүний агуулгыг тайлбарлана уу?
- Захиргааны процессын эрх зүй ба Үндсэн хуулийн процессын эрх зүйг зааглаж буй шалгуурыг тодорхойлно уу?
- Захиргааны процессын эрх зүй болон Захиргааны эрх зүй хоёрыг холбогч сэжим нь юу вэ?
- Хувийн эрх зүйн маргаан нийтийн эрх зүйн маргаан болон хөгжих зүй тогтол байгаа эсэхийг тодорхой жишээ татан тайлбарлана уу?

СЭДЭВ 4. Нийтийн эрх зүйн маргаан ба захиргааны хэрэг

Хичээлийн зорилго:

Нийтийн эрх зүйн маргааныг эх газрын эрх зүйн орчин үеийн хандлагаар тодорхойлж, хувийн эрх зүйн маргаанаас ялгах онолын шалгуурыг гаргаж түүнийгээ



энэ хоёр төрлийн маргааныг ялгахад оновчтой хэрэглэх чадварыг эзэмшүүлж, нийтийн эрх зүйн маргаан ба захиргааны хэргийн уялдаа хийгээд ялгарах шинжийг товойлгох замаар уг хэргийн ойлголт, хамрах хүрээг нээн илрүүлэхэд нь оюутанд туслах

Түлхүүр үгс:

- Нийтийн эрх зүйн маргаан (Öffentlichrechtliche Streitigkeit)
- Ашиг сонирхлын онол (Interessentheorie)
- Субординацийн онол (Subordinatiostheorie)
- Субъектын онол (Subjekttheorie)
- Захиргааны хэрэг

Хичээлийн агуулга:

- Нийтийн эрх зүйн маргааны тухай ойлголт, төрөл
- Нийтийн эрх зүйн маргааныг хувийн эрх зүйн маргаанаас ялгах шалгуурууд
- Захиргааны хэргийн ойлголт, онцлог, төрөл
- Нийтийн эрх зүйн маргаан, захиргааны хэрэг хоёрын уялдаа, онцлог

Хяналтын асуулт:

- Хүүхэд нэртэй байх нь хэний ашиг сонирхолд нийцэх вэ? Энэ шаардлагыг хаанаас тавьдаг вэ? Энэ тохиолдолд уг харилцаа аль эрх зүйгээр зохицуулагдах вэ?
- Хүүхэд хэн гэдэг нэртэй байх нь хэний ашиг сонирхолд хамаатай вэ? Үүнтэй холбоотой харилцааг аль эрх зүйгээр зохицуулах вэ? Маргаан үүсвэл түүнийг аль эрх зүйд хамааруулах вэ?
- Нийтийн эрх зүйн гэрээний маргаан нь захиргааныхад хамаарах уу?

СЭДЭВ 5. Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны ойлголт, онцлог \ЗХУША

Хичээлийн зорилго:

ЗХУША-ны ойлголт, шинж, онцлог, чиг үүргийг танин мэдэж хэрэгжүүлэх арга, журмын талаар цэгцтэй мэдлэг эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа
- Илт хууль бус захиргааны акт
- Маргаан бүхий захиргааны акт
- Шууд харъяалах дээд шатны захиргаа

- Хуульд өөрөөр заагаагүй бол
- Актын үйлчлэлийг түдгэлзүүлэх

Хичээлийн агуулга:

- Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны тухай ойлголт
- Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хоёрдмол шинж
 - Захиргааны үйл ажиллагаа
 - Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
- Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үе шат
 - Гомдол хүлээн авах
 - Захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах
 - Шийдвэр гаргах
 - Биелүүлэх

Хяналтын асуулт:

- ЗХУША нь захиргааны процессыг хууль зүйн бусад процессоос онцлогтой гэдгийг харуулах 1 шалгуур мөн үү?

СЭДЭВ 6. Нэхэмжлэлийн ойлголт, төрөл

Хичээлийн зорилго:

ЗХШ-д гаргах нэхэмжлэлийн ойлголт, төрлийг судалж, тэдгээрийн хоорондын ялгааг танин мэдэж бусад процессын хүрээнд гаргах нэхэмжлэлээс ЗХШ-ийн нэхэмжлэлийг ялгах чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Нэхэмжлэл

Хичээлийн агуулга:

- Нэхэмжлэлийн ойлголт
- Нэхэмжлэлийн төрөл
- Хүчингүй болгуулах тухай нэхэмжлэл
- Илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх тухай нэхэмжлэл
- Даалгах нэхэмжлэл
- Хохирлоо арилгуулах тухай нэхэмжлэл
- Эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох нэхэмжлэл
- Нэхэмжлэлийн төрөл ба нэхэмжлэлийн зүйлийн хоорондын уялдаа



Хяналтын асуулт:

- Хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг аль захиргааны актад холбогдуулан гаргадаг вэ?
- Даалгах нэхэмжлэлийг аль захиргааны акттай холбогдуулан гаргадаг вэ?
- ЗХШ-д гаргах нэхэмжлэлийн талаар хууль зүйн зөвлөгөө өгнө үү?

СЭДЭВ 7. Захиргааны хэргийн оролцогч, тэдгээрийн процессын эрх, үүрэг

Хичээлийн зорилго:

Оюутан захиргааны хэргийн оролцогчийн эрх, үүргийг судласны үндсэн дээр тэдгээрийн эрх, үүргийн ялгааг танин мэдэж, олсон мэдлэгээ тодорхой тохиолдолд хэрэглэх чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Хэргийн оролцогч
- Нэхэмжлэгч
- Хариуцагч
- Гуравдагч этгээд
- Бусад оролцогч

Хичээлийн агуулга:

- Хэргийн оролцогчийн ойлголт, ангилал
 - Хэргийн ба бусад оролцогч
- Нэхэмжлэгчийн эрх, үүрэг
- Хариуцагчийн эрх үүрэг
- Гуравдагч этгээдийн эрх, үүрэг
- Хэргийн бусад оролцогч, тэдгээрийн адилсах шинж

Хяналтын асуулт:

- Нэхэмжлэгч, хариуцагчийн эрх, үүрэгт буй ялгааг нэрлэнэ үү?
- Гуравдагч этгээдийн эрх зүйн байдлын онцлог юу вэ?
- Төрийн өмчит үйлдвэрийн газар нэхэмжлэгч мөн үү?

СЭДЭВ 8. Нотолгоо

Хичээлийн зорилго:

Оюутан захиргааны процессын мөрдөн шалгах зарчмыг судласны үндсэн дээр ЗХШ-ийн нотлох баримт цуглуулах аргатай танилцаж, шүүх нотлох баримтыг хэрхэн цуглуулах, үнэлэх, хэрхэн нотлох үүргийг хуваарилах талаар зохих мэдлэг, чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Нотолгооны үүрэг
- Мөрдөн шалгах зарчим
- Нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх
- Шүүх өөрөө нотлох баримт цуглуулах

Хичээлийн агуулга:

- ЗХШ нотлох баримтыг цуглуулах арга, түүний төрөл
- Нотлох баримтыг цуглуулахад хэргийн оролцогчдыг идэвхтэй оролцуулах нь
- Хариуцагч нотлох баримт гаргаж өгөх үүргээ биелүүлээгүйгээс үүсэх эрх зүйн үр дагавар
- Нотлох баримтыг үнэлэх асуудал: хэдийд хэрхэн үнэлэх
- Нотлох үүргийг хуваарилах асуудал

Хяналтын асуулт:

- ЗХШ мөрдөн шалгах зарчимд хязгаарлалт бий юу?
- ЗХШ мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлээд хэргийн нөхцөл байдал тогтоогдохгүй тохиолдолд хэрхэх вэ?
- Хариуцагч нотлох баримт гаргаж өгөөгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээх вэ?

СЭДЭВ 9. Шинжээчийн эрх, үүрэг

Хичээлийн зорилго:

Захиргааны хэргийн онцлогтой холбогдон тусгай мэдлэгийн шинэ салбарын шинжээч томилох хэрэгцээ, шаардлага болон шүүхийн даалгаврын дагуу гаргасан шинжээчийн дүгнэлтийг судалж түүнийг үнэлэх чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Шинжээч
- Шинжээчийн эрх, үүрэг
- Шүүхийн даалгавар
- Шинжээчийн дүгнэлт

Хичээлийн агуулга:

- Захиргааны хэргийн шинжээч, түүний онцлог
- Шинжээч томилох үндэслэл, журам
- Шинжээчийн эрх, үүрэг



- Шинжээчийн дүгнэлт, түүнд тавигдах шаардлага
- Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх нь

Хяналтын асуулт:

- Захиргааны хэргийн шинжээч хууль зүйн бусад процессын шинжээчээс ялгарах ямар онцлогтой вэ?
- Захиргааны хэргийн шинжээч томилдох зайлшгүй шаардлага юу байж болох вэ?
- Шинжээчийн эрх үүргийн онцлогийг тайлбарлана уу?
- Шүүх шинжээчийн дүгнэлтийг хэрхэн үнэлэх вэ?
- Эсрэг хоёр шинжээчийн дүгнэлтийг шүүх үнэлэхдээ харгалзах хүчин зүйлс юу байх вэ?

СЭДЭВ 10. Нөхөн төлүүлэх шүүхийн зардал ба улсын тэмдэгтийн хураамж

Хичээлийн зорилго:

Захиргааны хэргийн шүүхийн нөхөн төлүүлэх зардал ба улсын тэмдэгтийн хураамжийн эрх зүйн зохицуулалтыг судалж энэ асуудлыг ЗХШ-ийн онцлогтой холбон үзэж үнэлэлт дүгнэлт гаргах чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Шүүхийн зардал
- Улсын тэмдэгтийн хураамж
- Нэхэмжлэх эрхийг хангах

Хичээлийн агуулга:

- Нөхөн төлүүлэх шүүхийн зардал ба захиргааны хэргийн онцлог
- Улсын тэмдэгтийн хураамжийн ойлголт, хэмжээ, ач холбогдол

Хяналтын асуулт:

- Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хэн төлөх вэ?
- Нэхэмжлэлийн шаардлагын үнэ тодорхой тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг яаж төлөх вэ?

СЭДЭВ 11. Шүүхийн шийдвэрийн төрөл, тэдгээрийн учир холбогдол

Хичээлийн зорилго:

Анхан шатны шүүхээс гарах шийдвэрийн төрлүүдийг харьцуулан судласнаар тэдгээрийн ялгааг танин мэдэж, бүтцийг нь задлан шинжилж түүнд дүн шинжилгээ хийх чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Шийдвэр

Хичээлийн агуулга:

- Анхан шатны шүүхийн шийдвэр, түүний төрөл, хэлбэр
- Захиргааны актыг хүчингүй болгох тухай шийдвэр
- Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр
- Захиргааны зохих акт гаргахыг даалгах тухай шийдвэр г.м
- Анхан шатны шүүхийн шийдвэрийн бүтэц
- Удиртгал хэсэг
- Тодорхойлох хэсэг
- Үндэслэх хэсэг
- Тогтоох хэсэг

Хяналтын асуулт:

- Шийдвэрийн удиртгал хэсэгт хийх гол дүгнэлт юу вэ ?
- Тодорхойлох хэсэгт захиргааны процессын аль зарчим илүүтэй тусгалаа олдог вэ?
- Үндэслэх хэсэгт захиргааны процессын аль зарчмыг баримтлах нь чухал вэ?
- Тогтоох хэсэгт шүүхийн ямар хуулийг сонгож хэрэглэх вэ? \материаллаг болон процессын хуулийн\
- АШШ-ийн Шийдвэрийн төсөл бичнэ үү.
- Өгөгдсөн АШШ-ийн Шийдвэрт анализ хийнэ үү?

СЭДЭВ 12. ЗХШ-ийн шийдвэр биелүүлэх ажиллагаа

Хичээлийн зорилго:

Оюутан ЗХШ-ийн шийдвэр биелүүлэх ажиллагаа нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаанаас ямар онцлогтойг танин мэдэж, шүүхийн шийдвэрийг сайн дураар болон албадан биелүүлэх аргыг мэдсэн байх.

Түлхүүр үгс:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх баримт бичиг
- Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх
- Шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх

Хичээлийн агуулга:

- ЗХШ-ийн шийдвэр биелүүлэх ажиллагааны ойлголт, онцлог
- Шүүхийн шийдвэр гүйцэтгүүлэх арга, журам, хугацааг тодорхойлох шүүгчийн эрх үүрэг



- Шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд тавигдах хууль зүйн шаардлага
- Шүүхийн шийдвэрийг биелүүлэх үндэслэл, арга, журам

Хяналтын асуулт:

- ЗХШ-ийн шийдвэр биелүүлэх, иргэний хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх хоёрын нийтлэг ба ялгаа юу вэ?
- Захиргаа заавал биелүүлэх ажиллагаа шаарддаг шүүхийн шийдвэр бий юу? байгаа бол нэрлэнэ үү?
- Захиргаа заавал тусгайлан биелүүлэх ажиллагаа шаардахгүй (гармагц биелэгдсэнд тооцдог) шүүхийн шийдвэрийг нэрлэнэ үү?
- ЗХШ-ийн шийдвэрийг албадан биелүүлэх арга, журмыг товч ярина уу?

СЭДЭВ 13. Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа

Сэдвийн зорилго: Захиргааны хэрэг үүсгэх болон хэрэг үүсгэсний дараа шүүгчээс явуулах жишиг ажиллагааны агуулгатай танилцаж, улмаар тухайн хэргийн нөхцөл байдлыг илрүүлэхийн тулд бие даан ажиллах чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.

Түлхүүр үгс:

- Захиргааны хэрэг үүсгэх
- Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн жишиг ажиллагаа
- Бусад шаардлагатай ажиллагаа

Хичээлийн агуулга:

- Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаанд удирдлага болгох зарчмууд
- Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн жишиг ажиллагааны талаарх ойлголт
- Бусад шаардлагатай ажиллагааны агуулга
- Хариуцагчийг солих болон гуравдагч этгээдийг татан оролцуулах
- Нэхэмжлэлийн хэд хэдэн шаардлагыг нэгтгэх ба тусгаарлах
- Эвлэрүүлэх

Хяналтын асуулт

4. Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаанд удирдлага болгох гол зарчмуудыг нэрлэнэ үү?
5. Жишиг ажиллагаа нь заавал хийгдэх ажлын дэс дараалал мөн үү?
6. Бусад шаардлагатай ажиллагаа ба жишиг ажиллагаа нь тус тусдаа хийгдэх ажиллагаа юу?

СЭДЭВ 14. Нэхэмжлэлийн үндэслэлийг шалгах \загвар хичээл\

Хичээлийн зорилго:

Захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн үндэслэлийг тодорхой нэг тохиолдол дээр бодлого бодох аргачлалын дагуу бодож шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй гаргах арга барил эзэмшүүлэх, бие даан ажиллах хандлагыг төлөвшүүлэх

Түлхүүр үгс:

- Байнга оршин суух газраа сонгох эрх
- Татвар
- Хураамж
- Төлбөр
- Илт хууль бус акт
- Нэг нэгжээс нөгөөд бүрмөсөн шилжин суурьших

Хичээлийн агуулга:

- Байнга оршин суух газраа сонгох үндсэн эрхийн ойлголт
- Үндсэн эрхийг хязгаарлах үндэслэл, журам
- Татварын тухай ойлголт, төрөл
- Захиргааны үйл ажиллагаа хууль ёсны байх зарчим, түүний агуулга
- Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тусгайлсан бүрэн эрх

Хяналтын асуулт:

- Хураамж нь албан татвар мөн үү вэ?
- Нэхэмжлэгчийн сонирхол юу вэ?
- Хариуцагчийн сонирхол юу вэ?
- Нэхэмжлэгчийн ашиг сонирхол хуулиар хамгаалагдсан уу?
- Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тухайн асуудлаар захиргааны акт гаргах эрх олгогдсон уу?
- НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг зөвтгөх үндэслэл байна уу?
- Цэрэнгийн үндсэн эрх хязгаарлагдсан уу?

Бодлогын нөхцөл: Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчид хөдөө орон нутгаас нийслэл УБ хотод бүрмөсөн шилжин ирж буй насанд хүрсэн хүн тутмаас 50000 төгрөг, насанд хүрээгүй хүүхэд бүрээс 25000 төгрөгийн үйлчилгээний хураамж авч байхыг заасан тогтоол гаргажээ. Ийнхүү шийдвэр гаргахдаа нийслэл хотын хүн амын механик өсөлт урьд өмнө байгаагүйгээр өсөж, хотын даац нэгэнт хэтэрсэн тул энэ өсөлтийг эдийн засгийн аргаар хязгаарлах нь зайлшгүй гэсэн үндэслэл баримталжээ.



Иргэн Цэрэн ам бүл 8, үүнээс насанд хүрсэн 4, насанд хүрээгүй 4 бөгөөд гэр бүлээрээ Ховд аймгаас нийслэлд суурьшихаар нүүн ирсэн боловч үйлчилгээний хураамж 300000 төг төлөх боломж байсангүй. Иймд Цэрэн дээрх шийдвэрийг эс зөвшөөрч зохих журмын дагуу Нийслэлийн ЗХШ-д хандан Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх тухай нэхэмжлэл гаргажээ.

Асуулт:

Иргэн Цэрэнгийн нэхэмжлэл үндэслэлтэй юу?

Нийслэлийн ЗХШ ямар шийдвэр гаргах вэ?

Хичээлийн аргачлал: Бодлогын үндсэн асуултыг тодорхойлох замаар алхам алхмаар урагшлах замаар нэгдсэн дүгнэлтэд хүрэх

Үндсэн 3 асуулт: а\ Гол асуулт

б\ Талуудын сонирхлыг тодорхойлох

в\ Субсумц хийх

Хичээлийн хэрэглэгдэхүүн:

- Үндсэн хууль.1992 он
- Иргэний бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- ЗЗНДНТУГ хууль

Хичээлийн үнэлгээ:

- Үнэлгээний зарчим: Бодитой байх, Хүрэхүйц байх
- Үнэлгээний шалгуур: \ 119-р хуудасыг үзэх\

СЭДЭВ 15. Захиргааны процессын гомдолд тавигдах шаардлага

Хичээлийн зорилго:

ЗХУША-г явуулахад хуулиар нэлээд нарийвчилсан шаардлага тавигдаж буй тул оюутан энэхүү шаардлагыг судалж, гомдлыг каталогийн дагуу шалгах чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Гомдолд тавигдах шаардлага
- Дээд шатны байгууллага
- ЗХШ-д харьяалагдах маргаан
- Гомдлын хэлбэр

Хичээлийн агуулга:

- Захиргааны процессын гомдолд тавигдах шаардлагын ойлголт
- Гомдлын шаардлагын каталоги, тус бүрийн онцлог
- Бичгээр байх
- Хөөн хэлэлцэх хугацаа
- Оршин суугаа газрын хаяг
- Гарын үсэг

Хяналтын асуулт:

- Гомдлын хэлбэр, бүтцэд тавигдах шаардлагыг аль хуульд заасан журмаар тодорхойлох вэ?
- УША-ны хэргийн харьяаллыг аль хуульд заасан журмаар тодорхойлох вэ?
- УША-ны хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ?

СЭДЭВ 16. Гомдлын үндэслэл

Хичээлийн зорилго:

ЗХУША-г явуулаад гаргах шийдвэр нь үндэслэлтэй байхыг шаардана. Иймд ЗХУША-ны шийдвэрийн үндэслэлийг гаргахын тулд оюутан гомдож буй захиргааны актын зорилгодоо нийцсэн хийгээд хууль зүйн үндэслэлтэй эсэхийг шалгаж шийдвэрлэх арга барилд суралцаж, зохих чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Захиргааны акт зорилгодоо нийцсэн эсэх
- Захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэх
- ЗХУША-ны шийдвэр үндэслэлтэй байх

Хичээлийн агуулга:

- ЗХУША-ны шийдвэрийн үндэслэлийн тухай ойлголт
- Захиргааны акт зорилгодоо нийцсэн эсэхийг шалгах нь
- Захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах нь

Хяналтын асуулт:

- Захиргааны акт зорилгодоо болон хууль тогтоомжид нийцсэн эсэхийн алийг нь эхэлж шалгах вэ?
- Захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийн шалгуур нь юу вэ?
- Өгөгдсөн шийдвэрийн үндэслэлтэй эсэхэд анализ хийнэ үү?



СЭДЭВ 17. ЗХШ-д нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөл

Хичээлийн зорилго:

Иргэн, хуулийн этгээдээс ЗХШ-д нэхэмжлэл гаргахад тавигдах шаардлагыг нарийвчлан судласнаар оюутан ЗХШ-д нэхэмжлэх эрх нээгдэх үндэслэл, нөхцлийг тодорхойлох чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Хэргийн харьяалал
- Нутаг дэвсгэрийн харьяалал
- Чадвар, чадамж
- Нэхэмжлэлийн бүрдүүлбэр г.м
- Нэхэмжлэлийн шаардлага (заавал байх)

Хичээлийн агуулга:

- ЗХШ-д нэхэмжлэл гаргахад тавигдах шаардлагын тухай
- Нэхэмжлэх эрх нээгдэх нөхцлүүд
 - ЗХШ-д харьяалагдах
 - Урьдчилан шийдвэрлүүлэх
 - Нэхэмжлэлийн бүрдүүлбэр г.м
- Нэхэмжлэх эрх нээгдэх нөхцлийг шалгах нь (үндэслэл)

Хяналтын асуулт:

- Бусдын эрх, ашиг сонирхол зөрчигдсөн гэх асуудлаар иргэн өөрийн нэрийн өмнөөс ЗХШ-д нэхэмжлэл гаргаж болох уу?
- ЗХШ үндэслэл нь бичигдээгүй гэдэг шалтгаанаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах эрхтэй юу?
- Бүрдүүлбэр хангаагүй нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буцаах шууд шалтгаан болох уу?

СЭДЭВ 18. Захиргааны актын үйлчлэлийг түдгэлзүүлэх

Хичээлийн зорилго:

Захиргааны актын үйлчлэлийг түдгэлзүүлэх шаардлага, түдгэлзүүлж болох ба болохгүй нөхцөл байдлуудыг ялган судлах замаар оюутан практикт уг хуулийн заалтыг хэрэглэх чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Маргаан бүхий захиргааны акт
- Түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал

Хичээлийн агуулга:

- Захиргааны актын үйлчлэлийг түдгэлзүүлэх үндэслэл, журам
- Захиргааны актын үйлчлэлийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал
- Холбогдох хуулиудад дүн шинжилгээ хийх нь

Хяналтын асуулт:

- Захиргааны аль актын үйлчлэлийг түдгэлзүүлэх вэ?
- Захиргааны актын үйлчлэлийг түдгэлзүүлсэнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг хэн хариуцах вэ?
- Захиргааны актын үйлчлэлийг нэхэмжлэгч хүсэлт гаргасан тохиолдолд л түдгэлзүүлэх үү эсхүл хэрэг үүсгэснээр шууд түдгэлзүүлэх үү?
- Холбогдох хуулийн заалтыг үндэслэн тодорхойлно уу?

СЭДЭВ 19. Захиргааны хэргийн болон бусад оролцогч

Хичээлийн зорилго:

Өөрийн ашиг сонирхлыг илэрхийлж эсхүл бусдын ашиг сонирхлыг хамгаалж, түүнчлэн ямар ч сонирхолгүй хөндлөнгийн байр сууринаас процессын ажиллагаанд оролцогчийн эрх зүйн байдлыг оюутан тал бүрээс нь судалж, аль ч ашиг сонирхлыг хамгаалах болон хөндлөнгийн байр сууринаас хандах чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Хэргийн оролцогч
- Бусад оролцогч

Хичээлийн агуулга:

- Захиргааны хэргийн оролцогчийн ойлголт, онцлог
- Захиргааны хэргийн болон бусад оролцогч, тэдгээрийн эрх, үүрэг
- Захиргааны хэргийн болон бусад оролцогчийн эрх зүйн байдалд харьцуулсан шинжилгээ хийх

Хяналтын асуулт:

- Захиргааны хэргийн оролцогч нь хууль зүйн бусад процессын хэргийн оролцогчоос ялгаатай юу, хэрвээ ялгаатай гэж үзвэл түүний шалгуур юу вэ?
- Хэргийн болон бусад оролцогчийг хооронд нь ялгах гол шалгуур юу вэ?
- Хариуцагч шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх эрхтэй, нэхэмжлэгч шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх үүрэгтэй байгаа нь ямар учир холбогдолтой вэ? Тайлбарлана уу?
- Гэрч хэргийн болон бусад оролцогчийн аль нэгд хамаарах уу? Яагаад?



СЭДЭВ 20. Захиргааны хэргийн нотлох баримт

Хичээлийн зорилго:

Оюутан нотлох баримтын тухай ойлголт, нотолгооны хэрэгслийн талаар судалж захиргааны хэрэгт нотлох баримтын болохуйц хийгээд нотлох чадварын талаар цэгцтэй мэдлэг эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Нотлох баримт
- Нотолгооны хэрэгсэл

Хичээлийн агуулга:

- Захиргааны хэргийн нотлох баримтын тухай ойлголт, ангилал
- Нотолгооны хэрэгсэл, түүний хуульд заагдсан байдал
- Захиргааны хэргийн нотлох баримтын хэрэгт хамааралтай байх, нотолгооны ач холбогдолтой, хуулиар зөвшөөрөгдсөн байх шинж

Хяналтын асуулт:

- Нотлох баримт, нотолгооны хэрэгсэл хоорондоо юугаараа ялгаатай вэ?
- Нотлох баримтын болохуйц байдал гэж юуг хэлэх вэ?
- Нотлох баримт нь нотлох чадвараа алдах тохиолдлууд?

СЭДЭВ 21. Нэхэмжлэлийн үндэслэл

Сэдвийн зорилго: Нэхэмжлэлийн үндэслэлийн талаарх ойлголттой танилцах, түүнийг зөв тодорхойлох чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ

Түлхүүр үгс:

- Нэхэмжлэлийг үндэслэлтэй гэж үзэх
- Хүчингүй болгуулах нэхэмжлэлийн үндэслэл
- Даалгах нэхэмжлэлийн үндэслэл
- Илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэлийн үндэслэл
- Хохирлоо арилгуулах нэхэмжлэлийн үндэслэл

Хяналтын асуулт

4. Нэхэмжлэлийн үндэслэл гэдэгт хамаарч буй ойлголтуудыг тодорхойлно уу?
5. Нэхэмжлэлийн төрөл ба нэхэмжлэлийн үндэслэлийн харилцан хамаарал, зааг ялгааг тайлбарлана уу?
6. Материаллаг хэмжүүр гэдэгт юуг хамааруулж байна вэ?

СЭДЭВ 22. Шүүх бүрэлдэхүүн, шүүгчийг татгалзан гаргах

Хичээлийн зорилго:

Шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах хууль зүйн үндэслэлийг судалж энэхүү үндэслэл бүрдсэн үед тэдгээрийг татгалзан гаргах болон шүүгч өөрөө татгалзан гарахын учир холбогдлыг үнэлдэг болно.

Түлхүүр үгс:

- Татгалзан гаргах тухай хүсэлт
- Өөрөө татгалзан гарах

Хичээлийн агуулга:

- Шүүгчийг татгалзан гаргах нь тэгш байдлын зарчимд нийцэх нь
- Татгалзан гаргах үндэслэл
- Татгалзан гаргах тухай хүсэлт тавих нь
- Шүүгч өөрөө татгалзан гарах нь

Хяналтын асуулт:

- Шүүгчийг татгалзан гаргахын учир холбогдол юу вэ?
- Шүүх бүрэлдэхүүнийг эсхүл тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзсан тохиолдолд яах вэ?
- Шүүгч татгалзан гаралгүйгээр хэргийг шийдвэрлэх нь эрх зүйн ямар үр дагаврыг бий болгох вэ?

СЭДЭВ 23. Анхан шатны шүүх хуралдаан

Хичээлийн зорилго:

Анхан шатны шүүх хуралдааныг оюутан өөртөө аль болох хамгийн ойртуулсан аргаар судалж, шүүх хуралдааны уур амьсгалыг бүрдүүлэн хэргийн аль нэг оролцогчийн ашиг сонирхлыг илэрхийлэх юмуу эсхүл хөндлөнгийн байр сууринаас хандах замаар шүүх хуралдаан явуулах чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Шүүх хуралдаан
- Шүүх хуралдааны дэг
- Нотлох баримтыг шинжлэх
- Нотлох баримтыг үнэлэх
- Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт
- Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх
- Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох



Хичээлийн агуулга:

- Хэргийн нөхцөл байдлыг тодорхойлох
- Хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах
- Нотлох баримтыг үнэлэх болон захиргааны актын хууль зүйн үндэслэлийг шалгах нь
- Хэргийн оролцогчийн эрхийг хангах
- Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх
- Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг уншиж сонсгох

Хяналтын асуулт:

- Анхан шатны шүүх хуралдаан дэгийн дагуу явж чадсан уу?
- Шүүх хуралдаан даргалагч хэргийн оролцогчийн эрхийг хангасан уу?
- Шүүх хэргийг шийдвэрлэхэд шаардлагатай хангалттай нотлох баримт цуглуулсан уу?
- Шүүхийн шийдвэр үндэслэлтэй юу? Яагаад?

Хичээлийн арга, зүй:

- Дүрд тоглох \Мини шүүх\

СЭДЭВ 24. Захиргааны хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа

Хичээлийн зорилго:

Оюутан давж заалдах шатны шүүхээр захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогийг судалж уг шатаар хэргийг хэлэлцүүлж шийдвэрлүүлэх чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Давж заалдах гомдол гаргах эрх
- Гомдол гаргах хугацаа
- Хэргийг бүх талаас нь хянах

Хичээлийн агуулга:

- Давж заалдах гомдлын ойлголт
- Гомдлыг хүлээн авах үндэслэл, журам
- Давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа
- Давж заалдах шатны шүүхээс гарах магадлал, түүний төрөл

Хяналтын асуулт:

- Давж заалдах гомдолд ямар шаардлага тавигдах вэ?
- Гомдлын төсөл боловсруулна уу?

- Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ хязгаарлагдах тохиолдлуудыг нэрлэнэ үү?
- Давж заалдах шатны шүүх хуралдаан ба анхан шатны шүүх хуралдааны нийтлэг ба ялгаатай талыг харьцуулан үзнэ үү?

СЭДЭВ 25. Захиргааны хэргийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа

Хичээлийн зорилго:

Оюутан хяналтын шатны шүүхээр захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, онцлогийг судалж уг шатаар хэргийг хэлэлцүүлж шийдвэрлүүлэх чадвар эзэмшинэ.

Түлхүүр үгс:

- Хяналтын шатанд гомдол гаргах эрх
- Гомдол гаргах хугацаа
- Хууль зөрчсөн эсэх

Хичээлийн агуулга:

- Хяналтын шатны гомдолд тавигдах шаардлага
- Гомдлыг хүлээн авах үндэслэл, журам
- Хяналтын шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа
- Хяналтын шатны шүүхээс гарах тогтоол, түүний агуулга

Хяналтын асуулт:

- Хяналтын шатны гомдолд ямар шаардлага тавигдах вэ?
- Гомдлын төсөл боловсруулна уу?
- Хяналтын шатны шүүх хуралдаанд оролцож буй хэргийн оролцогчид тусгайлсан тодорхой шаардлага тавигдах уу?
- Хяналтын шатны шүүх хэргийг бүх талаас нь хянах уу?
- Давж заалдах шатны шүүх хуралдаан ба хяналтын шатны шүүх хуралдааны журмын нийтлэг ба ялгаатай тал юу вэ?
- Захиргааны хэргийг хяналтын шатны журмаар УДШ-ийн захиргааны хэргийн танхим ба УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, ялгааг илрүүлж гаргана уу?

СЭДЭВ 26. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллагаа

Сэдвийн зорилго: Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг дахин хянах болон үүний улмаас хэргийг ердийн журмаар



хянан шийдвэрлэх ажиллагаа тус бүрийн онцлогийг танин мэдэх, уг ажиллагааг явуулах чадварыг эзэмшихэд чиглэнэ

Түлхүүр үгс:

- Шинээр илэрсэн нөхцөл байдал
- Хүсэлт
- Ердийн журам

Хичээлийн агуулга:

- Шинээр илэрсэн нөхцөл байдлын талаарх ойлголт, онцлог
- Хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа
- Хэргийг ердийн журмаар хянан хэлэлцэх нь

Хяналтын асуулт

4. Шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар тодорхой жишээ татан тайлбарлана уу?
5. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллагааны онцлогийг тайлбарлана уу?
6. Хэрийг ердийн журмаар хянан шийдвэрлэх гэдэгт юуг ойлгох вэ?

2. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН АРГА ЗҮЙ

2.1. “Захиргааны процессын эрх зүй” хичээлийн арга зүйд тавигдах шаардлага

“Захиргааны процессын эрх зүй” хичээлээр оюутанд мэдлэг, чадвар, хандлага төлөвшихөд шаардагдах дараах арга зүйг баримтлана.Үүнд:

- Хичээлийн агуулга, хэлбэрт тохирсон арга зүй ашиглан мэдлэг түгээх
- Хичээлийн агуулга оюутан бүрт хүртээмжтэй байх зарчмыг сонгох
- Хичээлийн сэдэв тус бүрийн зорилгыг хангаж чадахуйц арга барилыг хэрэглэх
- Хичээлийг заах арга зүйг багш зохих ёсоор эзэмшсэн, бүтээлчээр хэрэглэж чаддаг байх

2.2. Мэдлэг бүтээхэд ашиглах арга

2.2.1. Лекцийн арга

Энэ аргын гол зорилго нь:

Оюутанд суурь мэдээлэл мөн онолын хувьд маргаантай бөгөөд хэрэглэх эх сурвалж дутмаг асуудлаар шинжлэх ухааны түвшинд нэгтгэн дүгнэж боловсруулсан

мэдээлэл өгч, сонсох болон асуудлыг бие тодорхойлж, томъёолох чадвар эзэмшихэд нь дөхөм үзүүлэх чиглэл баримтлана.

Лекцийн аргыг хэрэглэх явцад дараах зүйлийг анхаарвал зохино.Үүнд:

1. Сэдвийн агуулгыг эхнээс нь танилцуулж, ямар асуудлыг хөндөх тухай эрэмбэлсэн дэд сэдвүүдийг дурдаж, лекцийн зорилго, түүний хүрэх үр дүнг урьдчилан танилцуулах хэрэгтэй.
2. Хүний анхаарал төвлөрөх дундаж хугацаа 15-20 минут байдаг тул лекцийг алхам, алхамаар буюу 15-20 минут уншаад түр азнал хийж урьд ярьсан сэдвээрээ сонирхол татахуйц хялбар асуулт тавих байдлаар оюутны анхаарал төвлөрөлт хэр байгааг мэдэх, эсхүл тухайн сэдэвтэй холбоотойгоор бяцхан хошигнол, сонирхолтой яриа өрнүүлж тэдний идэвхийг сэргээх замаар лекцийг цааш үргэлжлүүлэх нь зүйтэй.
3. Оюутнуудын тоо, ангийн багтаамжийг харгалзан мэдээлэл түгээх орчныг үнэлэх, энэ үндсэн дээр тухайн сэдвээр лекц унших уу, эсвэл илүүтэй бичүүлж тэмдэглүүлэх нь хүртээмжтэй юу гэдгийг үнэлж аль илүү тохирох хувилбарыг сонгох
4. Лекцийн арга нь тухайн сэдвийн хүрээг бүхэлд нь хамрахад цагийн хувьд ихээхэн багтаамж муутай байдаг тул богино хугацаанд тухайн сэдвийн зорилгод заасан үр дүнд хүрэхийн тулд цаг бүрэн ашиглахад анхаарах нь чухал. Юуны өмнө дэлгэрүүлэн унших, судлах сурах бичиг, ном, сэтгүүл, гарын авлагын жагсаалт заавал унших минимумыг тухайлсан сэдэв бүрт өгч байх, түүнчлэн үзүүлэх материал, бүдүүвч, диаграмм ашиглах, гэрэлт самбар болон бусад тоног төхөөрөмж ашиглан бага цаг хугацаанд их хэмжээний мэдээлэл түгээх
5. Лекцийн үр дүн, ач холбогдлыг нэмэгдүүлэх, оюутны цаашид бие даан суралцах идэвх, сонирхлыг нэмэгдүүлэхийн тулд мэдээллийн 10 хүрэхгүй хувь нь оюутанд үлддэг нийтлэг дадлыг өөрчлөхийн тулд сонирхолтой, үндэслэлтэй, тоо баримт, сод жишээ, онцгой тохиолдлыг оновчтой хэрэглэх, чингэхдээ лекцийн бүтэц, агуулгыг алдагдуулахгүйг журам болгох нь зүйтэй.
6. Лекцийн төгсгөлд тухайн сэдвийн ач холбогдол, хүртээмжтэй, ойлгомжтой байсныг хөнгөн хялбар, тухайн үед шууд хариулах боломжтой асуултаар шалгах нь зүйтэй.
7. Цаашид тухайн сэдвийг хэрхэн судлах талаар сонирхол төрүүлэхүйц зөвлөгөө өгөхөд анхаарах



2.2.2. Эвлүүлгийн арга

Энэ аргыг лекцийг орлуулахад ашиглах бөгөөд оролцогчдод богино хугацаанд их мэдээлэл олж авах боломж олгодог.

Энэ аргын гол зорилго нь:

Харилцан суралцах боломжийг олгож тухайн хичээлээр бие биеэсээ асуулт асуух, мэдээлэл олж авах, хүнд хэцүү сэдвийг тал бүрээс нь хөндөж тайлбарлах, бусадтай харилцах, бусдыг сонсох чадвар олгоход дөхөм үзүүлэхэд оршино.

Хэрэглэх үе шат:

1. Багш шаардлагатай материалыг бэлтгэнэ.
2. Багш оюутны багуудыг бүрдүүлнэ.
3. Суралцагчид “мэргэжилтэн”-ий багт шилжин мэдээлэл олж авна.
4. Суралцагчид “өөрийн” багтаа эргэн ирж мэдээллээ солилцоно.
5. Багш ойлгосон эсэхийг нь шалгаж дүгнэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

Зарим хичээлээр суралцагчид маш их мэдээлэл түгээх хэрэгтэй байдаг. Энэ тохиолдолд тухайн мэдээлэл, лекцийн агуулга болон бусад нэмэлт хэрэглэгдэхүүнийг тухайн ангид ажиллах багийн тоогоор хувааж бэлтгэсэн байна. Бэлтгэсэн материалаа нэг нэг дугтуйд хийж багуудад тараан өгөх болно. Мөн төрөл бүрийн өнгийн цаас бэлтгэнэ.

1. Эхлээд багийг бүрдүүлнэ. Ингэхдээ 1, 2, 3-аар тоолуулан багт хуваарилна. Баг бүрийн гишүүн тус бүр өөр өөр өнгийн цаастай байна. Жишээ нь 1-р багт 5 гишүүн байгаа бол хүн тус бүрт өөр өөр өнгийн цаас байна. Нэг нь улаан, нөгөө нь цэнхэр, гурав дахь нь ногоон, дөрөв дэх нь шар г.м\
2. Одоо гол зорилгыг нь хэлнэ. Багийн гишүүд шинэ газар очиж эрдэм сурч ирээд бие биедээ сурсан эрдмээ заана гэдгийг ойлгуулна. Үүний дараа баг бүрт байгаа адил өнгийн цаастай хүмүүсийг дахин шинэ баг үүсгэхийг хүснэ. Шинээр үүссэн энэ баг бол “мэргэжилтэн”-ий баг бөгөөд энэ багт шинэ юм мэдэж авах болно гэдгийг хэлнэ.
3. ”Мэргэжилтэн”-ийн багуудад бэлтгэсэн ууттай материалуудыг өгч ажиллах заавраар хангана. Тухайлбал:
 - a) Дүрүүдийг хуваарилна: хөтлөгч, цаг харагч, асуулт тавигч г.м
 - b) Багууд тараасан ууттай материалыг уншиж ярилцах
 - c) Асуултад хариулж буй “мэргэжилтэн” бүгд материалыг ойлгосон гэдэгт итгэлтэй байхын тулд бусдаасаа асууж ярилцах
 - d) Багийн гишүүд өөрийн багийнхандаа чухам юут заахаа шийднэ.

Тэдэнд “мэргэжилтэн” болоход хангалттай хангалттай хугацаа өгөх хэрэгтэй. Хэрэв уг материал хүнд бөгөөд бүрэн танилцахад хугацаа хэрэгтэй бол бүтэн нэг хичээл зориулна. Мөн баг бүрт очиж материалаа ойлгож байгаа эсэх гэрийнхэндээ очоод яаж тайлбарлах талаар ярилцаж туслах хэрэгтэй байдаг.

1. Суралцагчид өөрийн багтаа буцаж очино. Багт “мэргэжилтэн”-ий багаас нэг нэг төлөөлөгч буцаж ирнэ. Өөрсдөө юу сурснаа багийн гишүүддээ нэг нэгээрээ зааж өгнө. Материалын их, бага, хүнд хөнгөнөөс шалтгаалаад дахиад нэг бүтэн хичээл шаардагдаж магадгүй.
2. Шалгах асуултауд бэлтгээд тэдний юу сурсныг дүгнэнэ. Мөн шаардлагатай нэмэлт мэдээллийг өгнө.

2.2.3. Хүн бүр багш \Each one teach one\

Үзсэн сэдвийн агуулга, ойлголтыг дүгнэх, лекцийн агуулгыг хүргэхэд энэ аргыг гол төлөв хэрэглэнэ.

Энэ аргын зорилго нь:

Оюутан сургалтын үйл явцад идэвхтэй оролцох болон бие биетэйгээ санаа бодлоо солилцоход ихээхэн ач холбогдолтой. Энэ аргыг хэрэглэснээр хичээлийн үед заавал эзэмших ёстой агуулга, ойлголтын талаар ерөнхий мэдээлэл өгөх ба тэдний сонирхлыг өдөөж, асуулт тавихад хүргэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

- Лекцийн агуулга, мэдээллийг утгат хэсгээр нь хувааж, хүнд тарааж өгөх зорилгоор жижиг цаасан дээр бичиж бэлдэнэ. Энэ нь таны сургалтад оролцогчдын тоогоор байх ёстойг анхаараарай.
- Оролцогч бүрт тараана.
- Оролцогчид мэдээллийг уншсаны дараа уншсан зүйлийнхээ агуулгыг ярих, зураглал, бүдүүвчээр илэрхийлэх зэргээр бусдад түгээх бэлтгэлээ хийнэ. Энэ үед багш тусламж шаардагдаж байгаа хүн дээр очиж зөвлөгөө өгч, тайлбарлаж болно.
- Бэлтгэх хугацаа дууссаны дараа тэд мэдээллээ бие биедээ танилцуулж ангиа тойрон явна. Хүн бүр өөрт буй мэдээллээ танилцуулж, бусдаас мэдээлэл авч дуустал энэ ажил үргэлжилнэ. Зорилго нь бусадтай мэдээлэл солилцох буюу өөрт буй мэдээллээ бусдад тарааж, шинэ мэдээлэл бусдаас олж авахад оршино.
- Энэ ажлыг дууссаны дараа багш бие биенээсээ юу мэдсэн, ямар шинэ мэдээлэл авсан тухай, уг мэдээллийг юу гэж ойлгож байгаа тухай, энэ мэдсэн зүйл өөрт нь ямар хэрэг болох тухай ярилцуулна.
- Ярилцлагын явцад оюутнуудад юу хэрэгтэй байгаа, тэдний бие биеэсээ авсан мэдээллийг хэрхэн цэгцлэх шаардлагатайг багш ажиглаж, тэр дагуу нэмэлт мэдээллийг өгнө.



2.3. Мэдлэг бүтээх буюу “Оролцооны аргууд”

2.3.1. Тохиолдол судлах арга /Case study/

Энэ арга нь мэдээлэл түгээх болон бие даалтаар олж авсан, эзэмшсэн мэдлэгээ тодорхой тохиолдолд хэрэглэж, оюутанд чадвар эзэмшүүлэхэд хэрэглэнэ.

Тохиолдол судлах аргын зорилго:

Хичээлийн явцад эзэмшсэн мэдлэгээ тодорхой тохиолдолд бодитойгоор хэрэгжүүлж, чадвар, дадлыг төлөвшүүлж буй болгоход энэ аргын зорилго оршино.

Тохиолдол судлах аргыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

1. Уг аргыг хэрэглэх хичээлийн сэдэвт хэр тохирох, үр дүнтэй эсэхийг тодорхойлох.
2. Тухайн тохиолдлыг авч үзэх сэдэв нь өргөн цар хүрээтэй, шинжлэх ухааны онолын олон салбарыг хамарсан, хугацаа шаардахуйц, уг аргыг хэрэглэхэд хүндрэлтэй эсэхийг анхаарах
3. Сурагчдын мэдлэгийн төвшин тухайн тохиолдлыг шинжлэхэд хангалттай буюу боломжтой эсэхийг анхаарах /курсын ялгааг анхаар/
4. Тухайн тохиолдол нь шинжилгээ, задаргаа хийх боломж, шаардлагатай эсэхийг анхаарах. Өөрөөр хэлбэл хэлбэр, агуулгын хувьд илтэд бодит байдалд нийцсэн ба нийцээгүй нь тодорхой байгаа эсэхийг анхаарах нь зүйтэй.

Тохиолдол судлах аргын дүрэм:

- Юун түрүүнд багуудыг аль болох тэнцүү тооны оюутантайгаар хуваарилна.
- Тухайн тохиолдлыг шинжилж, хариу, дүгнэлт болохуйц бодитой, мэдээ сэлт, баримтыг тодорхой хугацаатайгаар тараах
- Ямар хариу, дүгнэлт гаргах талаарх тодорхой асуулт тавих.
- Эцэст нь багш үнэн, зөв, үндэслэлтэй хариултыг танилцуулж, түүнд ямар арга хэрэглэснийгээ хэлнэ.

2.3.2. Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах аргын зорилго:

Хичээлийн хүрээнд эсрэг тэсрэг үзэл бодлыг хамтран хэлэлцэж, эдгээр үзэл баримтлал нь ямар нөхцөл, орчин, үед хэрэглэгдэж болох талаарх үндэслэлтэй, нотолгоо сайтай баримтуудыг хөндөх, гаргаж тавих, түүнийг бүлэг, хэсэг, ангиараа хэлэлцэж зөв, зохистой шийдэлд хүргэх чадварыг олгоход оршино.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг хийх аргаар хичээлийг явуулахад оюутанд дараах чадвар, хандлага төлөвших боломжтой. Үүнд:

- Нийгмийн амьдралд идэвхтэй байр суурь эзлэх эрмэлзлэлтэй болох;
- Төрийн удирдлага болон улс төр, нийгмийн чухал асуудлуудыг олон талаас нь шүүмжлэлтэйгээр эргэцүүлэн бодож, түүнийгээ илэрхийлэх чадварт суралцах;
- Эсрэг, тэсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, ойлгож, няцаах үндэслэл, нотолгоог дэвшүүлэх чадвар хөгжих.

Хичээлээр хэлэлцэх маргаантай асуудлыг сонгох шалгуур:

1. Асуудлыг олон талаас нь авч хэлэлцэх боломжтой юу?

Хоёр талын маргаантай, тодорхойгүй байгаа баримтыг сайтар үнэлж сонсож чадах уу? Бэлтгэсэн хэрэглэгдэхүүн хоёр талын тэнцвэртэй байдлыг хангаж чадах уу?

2. Энэхүү асуудал үнэхээр маргаантай асуудал уу?
3. Ардчилалыг хөгжүүлэхэд болон хуулийг дээдлэхэд энэхүү асуудал нь чухал ач холбогдолтой юу?
4. Энэ асуудал суралцагчдын хувьд чухал уу?
5. Энэ асуудал нь тухайн ангид /курсын ялгааг хэлж байна/ хэлэлцэхэд тохиромжтой эсэх?

1.1 Маргаантай асуудлыг хэлэлцэхэд баримтлах дүрэм:

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд хувь хүний үзэл бодлыг хөндөж сэтгэлийн хөдөлгөөн үүсгэдэг учраас заримдаа түүнийг зохион байгуулалттай дарааллаар хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Иймээс хичээлийг дээд зэргийн төвшинд явуулах, үүссэн байдлыг хяналтандаа байлгахад маргаантай асуудлуудтай ажиллах дараах дүрэм нь багшид тус болно. Тухайлбал, Дүрмийг зөвшилцөж гаргаад бүгд биелүүлнэ.

Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.

- Цаг барьж, ганцаараа ярихаас зайлсхийнэ.
- Уриа хэрэглэхээс зайлсхийнэ.
- Маргааныг хийсвэр төвшинд хүргэхээс өмнө тодорхой асуудлуудаар ярилцана.
- Таны байр сууринд эргэлзэх бололцоог бусаддаа олгоно.
- Өөрийн байр суурийн эргэлзээтэй зүйл, хүнд хэцүү болон сул талуудыг хүлээн зөвшөөрнө.
- Бусдын санааг өөрчлөн хэлэх замаар ойлгож сурна. Ийм дадалтай болгохын тулд бусдаас сонссоноо өөрчлөн хэлж сурна.
- Үзэл бодол болгонд хүндэтгэлтэй хандана.



2.3.3. Байр сууриа илэрхийлэх арга

Энэ арга нь маргаантай асуудлыг хэлэлцэхэд ихээхэн ач холбогдолтой. Маргаантай асуудал нь хууль зүйн үндэслэлтэй, зөв хариулт байхгүй, 2-ба түүнээс дээш эсрэг байр суурьтай байх ёстой.

Байр сууриа илэрхийлэх аргын зорилго:

Үзэж буй сэдвийн хүрээнд олон янзын эсрэг байр сууриуд байдаг гэдгийг харуулах, суралцагчдад өөрсдийн байр сууриа илэрхийлэх болон харилцааны чадвараа хөгжүүлэх боломж олгох зэрэг болно. Тухайн сэдвийг сурагчид хэрхэн ойлгосныг үнэлж дүгнэх үүднээс мөн хичээлийн эцэст хэрэглэж болно.

Хэрэгжүүлэх дараалал:

- Ангийн булангуудад хэлэлцэх асуудлын сэдвээс хамааран “Санал бүрэн нийлж байна”, “Санал нийлж байна”, “Санал нийлж байна”, “Шийдээгүй буюу эргэлзэж байна”, “Санал нийлэхгүй байна”, “Санал бүрэн нийлэхгүй байна” эсвэл “Маш зөв”, “Зөв”, “Шийдээгүй буюу эргэлзэж байна”, “Буруу”, “Маш буруу” гэсэн бичиг бүхий цаасыг дээрх дарааллаар байрлуулсан байна.
- Энэ дасгал ажлыг хэрхэн хийх талаар дүрэм зохиогоод түүнийгээ хэлэлцэж батлана. Дүрмийн жишээг доороос үзнэ үү.
- Хэлэлцэж буй асуудлын хүрээнд сурагчид өөрсдийн байр суурийг илтгэсэн бичиг бүхий буланд очиж зогсоно.
- Суралцагчдаас өөрсдийн байр суурийг тодруулж тайлбарлахыг хүснэ. Бүх сурагчдыг хамруулах үүднээс ижил сонголттой оюутнууд нэг багийг үүсгэж ярилцаад байр сууриа танилцуулахад бэлдэнэ.
- Оюутнуудыг өөрсдийн байр сууриа тайлбарласны дараа хэн нэг нь байр сууриа өөрчилж өөр буланд очихыг хүсэж байгаа эсэхийг асууна. Хэрэв өөрчлөх хүсэлтэй оюутан гарвал яагаад ингэх болсон шалтгааныг асууна.
- Эсрэг баримтлалуудын дэвшүүлсэн үндэслэлээс аль нь хамгийн үнэмшилтэй байсныг асууж ярилцана.

Байр сууриа илэрхийлэхэд баримтлах дүрэм:

- Ярих ээлжээ хүлээх.
- Нэгийгээ ярьж байхад бусад нь чимээгүй сонсох.
- Шинэ үндэслэл, санал, гаргах. Хоорондоо маргалдахгүйгээр, тэвчээртэй зөв харилцах.
- Байр сууриа хэзээ ч өөрчилж, өөр буланд очиж болно. Гагцхүү үзэл бодлоо өөрчлөх болсон шалтгаанаа хэлнэ.
- Бусдын санал бодлыг сонсож тэдгээрээс аль нь илүүтэй таалагдсаныг тайлбарлах.

Байр сууриа илэрхийлж сурахын тулд дагаж мөрдөх үе шат:

- Өөрийн үзэл бодлыг тодорхойлох.
- Өөрийн үзэл бодлыг хамгаалсан нэг шалтгааныг хэлэх.
- Өөрийн хэлсэн шалтгаанаа тодруулах нэг жишээ хэлэх.
- Өөрийн үзэл бодлоо нэгтгэх.

Жишээ:

- ЗХШ-ийн үүрэг зорилго нь иргэний эрх, эрх чөлөөг захиргааны дур зоргын шийдвэрээс хамгаалахад оршино.
- Учир нь Монголд захиргааны байгууллагын иргэн, хуулийн этгээдэд чиглүүлж гаргасан хууль бус шийдвэр, үйл ажиллагаа хавтгайрчээ.
- Хамгийн наад зах нь захиргааны албан тушаалтан хураамж, төлөөс нэрээр янз бүрийн татварыг иргэдээс дураар авдаг гэдгийг судалгаа харуулсан.
- Ийм учраас би захиргааны байгууллагын дур зоргын үйл ажиллагааны эсрэг байдаг.

2.3.4. Цомхон багаар ажиллах /Group work/ арга.

“Цомхон багаар ажиллах” энэхүү арга нь бусдыг анхааралтай сонсох, нэгдсэн дүгнэлтэд хүрэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, багийг буюу хэсэг бүлгийг төлөөлөх зэрэг чадварыг амьдралд хэрэглэх боломжийг оюутанд олгодог учир ихээхэн дэлгэрсэн юм.

Цомхон багаар ажиллах аргын зорилго:

Энэхүү арга нь хамтран ажиллах, бусдыг ойлгох зэрэг чухал чадваруудыг эзэмших боломжийг олгодог. Үүнээс гадна өөр хоорондоо зөрүүтэй бодол санааг нэгтгэхэд тусалдаг.

1.1 Цомхон багаар ажиллуулахад юу анхаарах хэрэгтэй вэ?

- Суралцагчид тухайн ажлыг гүйцэтгэх мэдлэг, дадал, чадвар эзэмшсэн байх ёстой. Эзэмшээгүй тохиолдолд тэд тухайн даалгаврыг хийж гүйцэтгэх ямар ч сонирхолгүй байх тул та үүнийг нэн түрүүнд мэдэх шаардлагатай.
- Багт ажлын зааварчилгааг маш тодорхой өгөх ёстой. Нэг дор (хэдий маш тодорхой ч) нэг юм уу хоёроос дээш зааварчилгаа өгөхгүй байх.
- Багт тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд хангалттай цаг хугацаа олгох ёстой. Түрүүлж ажлаа дуусгасан багийг бусаддаа саад болгохгүйн тулд юу хийлгэхээ сайтар төлөвлөсөн байна.
- 2-4 гишүүнтэй баг бүрдүүлэх. Гэхдээ эхлээд 2-3 гишүүнтэй багтай ажиллах. Цомхон багийн хувьд 5 гишүүнтэй байх нь хамгийн дээд хэмжээ байна.



- Бие дааж болон хамтаараа ажиллах чадварыг зэрэг хөгжүүлэх буюу тэнцвэртэй байлгахыг зорьсон асуудал, даалгаврыг өгөх ёсгүй. Учир нь цомхон багаар ажиллах аргыг сурагчдын ширээ тойрон сууж бие даан ажиллах чадварыг бус зөвхөн хамтаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд л ашиглах нь илүү тохиромжтой байдаг.
- Энэ аргыг тодорхой зорилготойгоор, тохиромжтой үед, дүрмийн дагуу хэрэглэх ёстой болохоос биш зөвхөн улиг домог болсон лекцийг орлуулах нэгэн арга болгох ёсгүй юм.
- Баг доторх удирдлагын асуудлыг мөн тооцож үзэх ёстой. Багаас нэг гишүүн хийсэн зүйлээ танилцуулах тохиолдолд тэр гишүүнийг шударгаар сонгоход анхаарах.
- Багаар ажиллахад гарах дуу чимээг хүлээн зөвшөөрөх ёстой.
- Цомхон багаар ажиллах явцад суралцагчид бие биеийнхээ нүдийг харах боломжтой байдлаар суусан байна. Гишүүн тус бүр бусад гишүүдээ төвөггүйгээр харж, харилцах ёстой.

2.3.5. Мэтгэлцээний арга:

Энэ арга нь оюутанд шинжлэх ухааны хувьд илүү их шаардлага тавих төдийгүй мэтгэлцэх асуудлаар нэлээдгүй судалгаа, боловсруулалт шаарддаг мэдлэг, чадварыг бүтээх хамгийн сонгодог арга юм.

Мэтгэлцээний аргын зорилго:

Оюутанд тухайн сэдвийн хүрээнээс хамааран бие даан өөрийн үзэл бодлыг хамгаалах нотолгооны зайлшгүй шинжийг ухамсарлуулах, алив асуудалд хандахдаа жишээ, тоо, баримтыг ямар хэмжээнд үнэлж, дүгнэх, илтгэх болон сонсох урлаг эзэмшүүлэх, асуудалд зөв зохистой хандах хувилбарын шалгуурыг тогтоож сургахад оршино.

Мэтгэлцээний аргыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

4. Тухайн асуудлаар мэтгэлцээн зохион байгуулах нь зохистой эсэхийг тодруулах хэрэгтэй
5. Мэтгэлцээний талууд, тэдгээрийн баримтлаж буй үзэл баримтлал нь тэнцвэртэй эсэхийг анхаарах хэрэгтэй.
6. Мэтгэлцэх асуудлыг тодорхой болгож, түүний хамрах хүрээ хэр зэрэг өргөн эсэхэд анхаарах хэрэгтэй
7. Мэтгэлцээний зорилго-агуулга хоёр хэр зэрэг нийцэж байгаад анхаарах хэрэгтэй.

Мэтгэлцээний аргын дүрэм:

- Мэтгэлцээний талуудыг тэнцүү тооны оюутантайгаар хуваарилана. Нэг тал орж буй оюутнуудын тоо 3-аас илүүгүй байна.
- Мэтгэлцэх асуудлуудыг багш шууд тараах бус харин мэтгэлцээний талуудын баримтлах үзэл баримтлалыг танилцуулж, энэ дагуу багууд шодож асуудалд бэлтгэнэ
- Мэтгэлцээнийг нээлттэй явуулна.
- Талуудын аль нэг нь тайлбар, нотолгоо, үндэслэлээ тайлбарлаж байхад нөгөө тал сонсох үүрэгтэй
- Мэтгэлцэж буй асуудал тавьсан зорилго, агуулгаас хальсан тохиолдолд багш мэтгэлцээнийг шууд зогсоож, урьд хэлэлцэж байсан асуудлаас эхлүүлнэ.
- Талууд хэн нэгнийгээ доромжлох, гүтгэх, зүй бус авир гаргасан тохиолдолд ийм явдал гаргасан талыг мэтгэлцээнд хангалтгүй оролцсонд тооцож мэтгэлцээнийг зогсооно.

2.3.6. Дүрд тоглох

Энэ арга нь оюутнуудыг хичээлийн агуулгын гол цөмд аваачиж, тэднээр бие даалган шийдвэр гаргуулах, дүгнэлт өгөхөд чиглэсэн чадварын талыг хөгжүүлдэг.

Зорилго:

Оюутнуудыг захиргааны процессын эрх зүйн тухайлсан зохицуулалтанд хийсвэрлэн аваачиж, хичээлийн явцад эзэмшсэн мэдлэгийг практикаар дадлагуулах, мөн тухайн мэдлэгийг зөв, зохистойгоор хэрэглэж сурах чадвар буй болгох, мөн тухайн орчиноос хамаарсан өөрийн хувь дүгнэлт, санал, шүүмжийг бий болгож асуудалд хариуцлагатай хандаж шийдвэр гаргах хандлага төлөвшүүлэхэд оршино.

Дүрд тоглох аргыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

- Тухайн сэдвийн хүрээнд боловч цаг ашиглалтад анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ аргыг хэрэглэх тохиолдолд нилээдгүй хугацаа шаардлагатай байдаг.
- Дүрд тоглуулах тохиолдол нь онолын маргаантай, шийдвэрлэхэд хэцүү, нарийн мэргэшлийн практик тогтоогүй байдлаас аль болох зайлсхийх.
- Одоо байгаа бодит байдлыг сонгон авч хэрэглэх нь сэдвийн агуулгад тохирох хийгээд илүү үр дүнтэй болох тул ирээдүйд байж болох, эсхүл өнгөрсөн үйл баримтуудаас аль болох татгалзах
- Хамгийн гол асуудал нь дүрд тоглосны эцэст ямар мэдлэг, чадвар, үр дүнд хүрэхийг сайтар тогтоож, түүнд хэрхэн хүрэх ямар дүрд тоглуулах нь зүйтэйг анхаарах.



- Процессийн эрхийн зохицуулалтыг урьдчилан тухайн курсын оюутнууд судалсан эсэхийг тодруулах.

Дүрд тоглох аргын дүрэм.

- Юун түрүүнд урьдчилж дүрд тоглох нөхцөл /case/-ийг хуваарилж өгнө. Ийнхүү хуваарилж өгснөөс хойш 3-5 хоногийн дараа уг аргын тусламжтайгаар хичээл явуулах нь зүйтэй.
- Хичээл эхлэхэд тасралтгүйгээр, хэсэгчилсэн үзэгдэлтэйгээр уг аргыг ашиглана.
- Дүрд тоглогч талууд тухайн нөхцлийг хэрхэн яаж, ямар байдлаар шийдвэрлэсэн, гүйцэтгэсэн байхыг үе шаттайгаар тогтоож өгнө.
- Эцэст нь оюутнууд өөрсдийн дүрд тоглосон байдлыг тодорхойлж, алдаа дутагдал, зөв зүйтэй үйлдлүүдээ хэлэлцэж багш дүгнэж хэлнэ.

2.4. Загвар хичээл

3. “ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ” ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

3.(1). Үнэлгээний зорилго:

“Захиргааны процессын эрх зүй” хичээлийн үнэлгээ нь уг хичээлийн зорилго, зорилтуудад тусгагдсан хичээлийн агуулга, түүний үр дүн болох мэдлэг, чадвар, хандлагыг оюутан хэрхэн эзэмшсэнийг бүрэн дүүрэн, тал бүрээс нь, бодитойгоор, ил тод байдлаар үнэлгээний шалгуур, журмын дагуу тогтооход оршино.

3.(2). “Захиргааны процессын эрх зүй” хичээлийн үнэлгээний журам

“Захиргааны процессын эрх зүй” хичээлийг бүхэлд нь улирлын эцэст 100%-иар үнэлнэ. Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэхдээ “А, В, С, D, F” гэсэн үсгэн дүн, “4, 3, 2, 1, 0” гэсэн тоон дүн болон “0-100%” хүртэлх процентон дүн хэрэглэнэ.

Оюутны үнэлж, дүгнэхдээ доорх үсгэн дүнг хэрэглэнэ.

- ❖ А – Сурлагын дээд амжилтыг илтгэх дүн: тухайн хичээлийн агуулгыг бүхэлд нь байх ёстой хэмжээнд бүрэн дүүрэн ойлгосон, нэр томъёо, ойлголтуудыг чадварлаг ашигладаг, тухайн хичээлээр өргөн мэдлэгтэй болохыг илтгэнэ:
 - Бие дааж эх материал уншиж, даалгавар гүйцэтгэж лекцийг өргөжүүлсэн хүрээнд судласан.
 - Захиргааны процессын эрх зүйн талаарх өөрийн гэсэн үзэл хандлагатай болсон, захиргааны процессын эрх зүйн мөн чанар, онцлогийг сайтар ойлгон бусад эрх зүйн салбараас ялгах бүрэн чадвартай болсон.
 - Захиргааны процессын ажиллагааны баримт бичгийг боловсруулах чадвар эзэмшсэн.

- Асуултанд тал бүрээс нь, бүрэн дүүрэн хариулж, жишээ баримт, тоон үзүүлэлтийг хэрэглэсэн.
- Тест, шалгалтын даалгаварыг 90-ээс доошгүй хувьтайгаар гүйцэтгэсэн.
- ❖ В – Дундаж төвшнөөс дээгүүр амжилтыг илтгэх дүн: тухайн хичээлийн агуулгыг сайн ойлгосон, тухайн хичээлтэй холбоотой бодлого бодох, ухагдахууныг ашиглах чадвартай:
 - Захиргааны процессын эрх зүйн хичээлийн сэдвийн агуулгыг хангалттай ойлгосон.
 - Бие даасан даалгаварыг бүрэн биелүүлсэн.
 - Семинарын хичээлд идэвхтэй оролцсон.
- ❖ С – Тухайн хичээлийн агуулгыг дундаж төвшинд эзэмшсэн байгааг илтгэх дүн: тухайн хичээлийн ухагдахууны ихэнхи хэсгийг хангалттай ойлгосон, хялбар бодлогуудыг бодох чадвартай, цаашид энэ чиглэлээр хичээл судлах хангалттай бэлтгэлтэйг илэрхийлэх дүн:
 - Захиргааны процессын эрх зүйн зохицуулалтын зарим хэсгийг ойлгосон.
 - Ерөнхий зүй тогтол, бүтэц, зохион байгуулалтын талаар ойлголттой болсон.
 - Бие даасан даалгаварын 60-70%-г гүйцэтгэсэн.
 - Семинарт идэвхтэй оролцоогүй.
- ❖ D – Дундаж төвшнөөс доохнуур амжилтыг илтгэх дүн: тухайн хичээлийн ухагдахууныг жигд ойлгоогүй, харьцангуй хялбар бодлого бодох чадвартай, гэхдээ хариулт нь мэдлэг ихээхэн дутагдалтайг илтгэнэ:
 - Захиргааны процессын эрх зүйн талаархи төсөөлөл төдий мэдлэгтэй.
 - Бие даасан даалгавар хийгээгүй.
 - Асуултын 30-40%-д хариулсан.
- ❖ F – Мэдлэг, чадвар хангалтгүйг илтгэх дүн: тухайн хичээлийн агуулгыг эзэмшиж чадаагүй, хялбархан асуултанд хариулах чадваргүй:
 - Бие даасан даалгавар хийж гүйцэтгээгүй.
 - Тайлбар, дүгнэлт гаргаж чадахгүй байгаа.
 - Асуултад хариулт өгч чадаагүй буюу хариулахыг оролдсон.

Үсгэн, процентон болон тоо /оноо/-н дүнгүүдийг дараахь жишгээр нэгээс нөгөөд шилжүүлнэ.



Үсгэн дүн	Тоон дүн	Процентон дүн
A	4.0	90-100
B	3.0	80-89
C	2.0	70-79
D	1.0	60-69
F	0	0-59

Оюутан “F” үнэлгээ авсан тохиолдолд тухайн хичээлийг хангалтгүй судалсанд тооцож, шалгалтанд тэнцээгүйг илэрхийлнэ.

Оюутан дараахь шатлалтайгаар үнэлэгдэнэ.

Явцын үнэлгээ: 50 оноо. Энэ нь дотроо:

1. семинар 25 оноо
2. улирал дундын шалгалт 10 оноо
3. бие даалт 10 оноо
4. сонгон гүйцэтгэх ажил 5 оноо

Улирлын шалгалт: 50 оноо. Улирлын шалгалтыг амаар авна.

3.(3). Үнэлгээний шалгуур

Үнэлэх зүйл	Үнэлгээний жишиг шалгуур
Мэдлэг	<ol style="list-style-type: none"> 1. Асуултын агуулгыг ойлгож, асуултад хариулт болохуйц нөхцлийг тодорхойлж чадаж байгаа эсэх 2. Асуудалд онолын үүднээс хариулж чадаж байгаа эсэх 1. Мэдлэгээ бусдад дамжуулж, тайлбарлаж чадаж байгаа эсэх 2. Тодорхойлолт хэлэх, харьцуулалт хийх, гол ба гол бусыг ялгах харилцан хамаарал, зүй тогтлыг тодорхойлох арга зүйг эзэмшсэн эсэх 3. Хариултын үндэслэл, нотолгоог оновчтой гаргаж байгаа байдал 4. Бүхэлдээ “...гэж юу вэ?” буюу хаалттай асуултад хариулж чадаж байгаа эсэх
Чадвар	<ul style="list-style-type: none"> ◆ Онолын мэдлэгийг ашиглан /үндэслэл, нотолгоо болгох, жишээ баримт татах, тайлбарлах/ өгөгдсөн нөхцөлд задаргаа хийж, тайлбарлаж, нэгтгэн үнэлж, шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх ◆ Бодлого бодох, тохиолдол шийдвэрлэхдээ сургалтын явцад эзэмшсэн мэдлэгтээ тулгуурлаж байгаа байдал ◆ Баримт бичгийг шаардлагын дагуу боловсруулж чадаж байгаа эсэх ◆ Мэдлэгтээ тулгуурлан диаграмм, схем зохиох, системчлэл, бүдүүвчийг хэрхэн гүйцэтгэж байгаа ◆ Өөрийн үзэл бодол, байр суурь, үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж чадаж байгаа эсэх,

Хандлага	<ul style="list-style-type: none"> ◆ Ийнхүү бусдын үзэл бодол, байр сууринд хүндэтгэлтэй хандаж түүнээс үнэ цэнэтэй зүйлийг олж харж, авч чадаж байгаа эсэх ◆ Ялгаатай үзэл хандлага, байр сууринд хандах хандлага, түүнийг хүлээн зөвшөөрч байгаа байдал ◆ Тухайн асуудлаар өөрчлөлт, шинэчлэлт хийх оновчтой арга замыг тодорхойлж чадаж байгаа эсэх ◆ Хөгжлийн гольдрол хийгээд цаашид ямар байх төлөвийг тодорхойлж буй эсэх,
-----------------	---

3.(4). Хичээлийн жишиг үнэлгээ

Есдүгээр хичээл: Нэхэмжлэлийн үндэслэлийг шалгах \загвар хичээл\

Хичээл явагдах хэлбэр: Тохиолдол шинжлэх арга

Хичээлийн зорилго:

Захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн үндэслэлийг тодорхой нэг тохиолдол дээр бодлого бодох аргачлалын дагуу бодож шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй гаргах арга барил эзэмших, бие даан ажиллах хандлага төлөвшихөд нь туслах

НЭГ: /мэдлэгийн талыг үнэлэх/21

Асуулт:

- Хураамж албан татвар мөн үү вэ?
- Нэхэмжлэгчийн сонирхол юу вэ?
- Хариуцагчийн сонирхол юу вэ?
- Нэхэмжлэгчийн ашиг сонирхол хуулиар хамгаалагдсан уу?
- Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тухайн асуудлаар захиргааны акт гаргах эрх олгогдсон уу?
- НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг зөвтгөх үндэслэл байна уу?
- Цэрэнгийн үндсэн эрх хязгаарлагдсан уу?

ХОЁР: /чадварын талыг үнэлэх/

НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол хууль зүйн үндэслэлтэй эсэхийг холбогдох материаллаг хуулийг хэмжүүр болгон шалгаж, хууль зүйн үнэлэлт, дүгнэлтийг \субсумц хийх\ хэрхэн хийн гаргалгаа гаргаж байгааг үнэлж дүгнэнэ.

¹ Мэдлэгийн талыг үнэлэх жишиг шалгуурыг баримтлан эдгээр асуултанд үндэслэлийг нь гарган хариулж, тайлбарлаж, дүгнэж байгаагаар нь үнэлэнэ.



ГУРАВ: /хандлагыг үнэлэх/

НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын хууль зүйн үндэслэлийг шалган тогтоож хууль зүйн үнэлэлт дүгнэлт өгснөөр нийтийн захиргааны байгууллагын гаргаж буй захиргааны акт нь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хэр нийцэж байгаа, тийм хууль бус шийдвэр, үйл ажиллагаа практикт түгээмэл байгаа эсэх, цаашид нийтийн захиргааны шийдвэр, үйл ажиллагаанд хууль ёсыг хангаж зүй ёсын соёлыг төлөвшүүлэхийн төлөөх мэргэжлийн хандлагыг илэрхийлж буй байдлаар нь хандлагыг үнэлж болно.

Үнэлгээний шалгуурыг хэрэглэх журам:

- Оюутны тухайн асуудлыг хэрхэн ойлгож, тал бүрээс нь үнэлж дүгнэж буй мэдлэгийн түвшин болон, хууль зүйн үндэслэлийг оновчтой, зөв гарган ирж үндэслэл бүхий хариулт өгч буй чадварыг харгалзан үзэх
- Үг хэллэг, нэр томъёог хэрхэн зөв, оновчтой хэрэглэж буйг анхаарах



48. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. ТМ. 2002 оны №8. нэмэлт, өөрчлөлт- ТМ. 2007, №32.
49. Шүүхийн шинжилгээний тухай хууль. ТМ, 2010, №2.

Эрх зүйн бусад акт

3. Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам. ЗГ-ын 2009-01-28-ны 22 дугаар тогтоол.
4. Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”- УИХ-ын 2003-05-08-ний 14 дүгээр тогтоолын хавсралт. ТМ эмхтгэл. 2003, №20.

